

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН**

**“ДЭЛХИЙН ӨВ: БУРХАН ХАЛДУН УУЛ, ТҮҮНИЙГ ХҮРЭЭЛСЭН ТАХИЛГАТ  
ГАЗАР НУТАГ”-ИЙН ОРЧНЫ БҮСИЙН ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА”**

захиалгат төслийн тайлан

Дугаар ШуУз 92019/25

Эхэлсэн: 2019.01.01

Дууссан: 2022.12.31

<b>Төслийн удирдагч:</b>	С.Чулуун, академич
<b>Захиалагч:</b>	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
<b>Санхүүжүүлэгч:</b>	Шинжлэх Ухаан, Технологийн Сан
<b>Гүйцэтгэгч:</b>	ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн

**Улаанбаатар хот  
2022**

## ГАРЧИГ

Реферат	
<b>Нэг.</b> Ажлын зорилго .....	7
<b>Хоёр.</b> Зохион байгуулалт.....	8
<b>Гурав.</b> Төсөл гүйцэтгэх үндэслэл, шаардлага .....	9
<b>Дөрөв.</b> Гүйцэтгэсэн үе шат.....	10
<b>Тав.</b> Судалгааны ажлын эцсийн үр дүн .....	14
5.1. Хээрийн судалгаа.....	14
5.1.1. 2019 оны хээрийн судалгаа .....	14
5.1.2. 2020 оны хээрийн судалгаа.....	21
5.1.3. 2021 оны хээрийн судалгаа.....	47
5.1.4. 2022 оны хээрийн судалгаа.....	52
5.2. Мэдээллийн сан бүрдүүлэлт .....	56
5.3. Бүтээлийн танилцуулга .....	57
5.3.1. Э.Равдан. <i>Дэлхийн өв-Бурхан халдуны бүс дэх газар нутгийн байршлын толь.</i> УБ., 2023. 104 тал.....	57
5.3.2. Н.Хатанбаатар, С.Чулуун. <i>Балданбэрээвэн хийд.</i> УБ., 2020. 96 тал. ....	58
5.3.3. “Дэлхийн өв: Бурхан халдун” каталоги. УБ., 2023.....	59
5.3.4. Чингис хааны өв, соёл: Архивийн баримтын эмхэтгэл. Крилл үсэгт хөрвүүлж, эрдэм шинжилгээний тайлбар хийсэн Г.Мягмарсамбуу, Г.Цэрэнсугар. УБ., 2020. 727 тал. ....	60
5.4. “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” болон орчны бүсийн дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газруудын виртуал танилцуулга .....	61
5.5. Хан Хэнтий уул (Бурхан Халдун) -ын тахилга тайлгын тухай архивын баримт, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг эмхэтгэх .....	65
<b>Зургаа.</b> Шинэлэг тал.....	90
<b>Долоо.</b> Шинжлэх ухаан, эдийн засаг, нийгмийн ач холбогдол.....	92
<b>Найм.</b> Дүгнэлт.....	93

## РЕФЕРАТ

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс 2019 оны 01 сараас 2022 оны 12 сарын 31 хүртэлх хугацаанд Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын захиалгаар “Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн орчны бүсийн түүх, соёлын өвийн судалгаа” сэдэвт захиалгат төслийг гүйцэтгэсэн болно.

Бурхан халдун ууланд Чингис хааны алтан ургийн их хаад, язгууртнуудын ариун онгоныг нууцлан хадгалсан “Их хориг” оршин буй нь баттай учир Монгол улсын төдийгүй дэлхийн нийт монгол угсаатны эрхэм нандин өв сан, итгэл, бишрэлийн нэгэн төв орон зай мөн билээ. Өнөөгөөс 780 гаруй жилийн өмнө бичигдсэн “Монголын нууц товчоон” хэмээх гайхамшигт түүхэн эх сурвалж “*Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо марал ажээ. Тэнгэс гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж бүхүйд төрсөн Батачихан ажгуу*” хэмээн эхэлдэг бөгөөд Чингис хаан “...*Бурхан халдуныг өглөө бүр мялаасугай, өдөр бүр өчсүгэй, ургийн ураг минь ухан мэдтүгэй*” (МНТ§103), “*Гурван мөрний тэргүүнд хэнийг ч бүү буулгагтун*” (МНТ§179) хэмээн айлдсан захиасыг монголчууд үеийн үед мөрдөн дагасаар, тайн тахисаар, хайрлан хамгаалж ирсэн түүхтэй. Тийм учраас Бурхан халдун хайрхан уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн тухай судалгааг өргөжүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй танилцуулга, мэдээлэл бэлтгэх, Бурхан халдун уулын тухай судалгааны өнөөгийн түвшинг нэгтгэн дүгнэх, цаашдын төлөвлөлтийг боловсруулахад шаардлагатай мэдээллийн сан бүрдүүлэх нэн чухал шаардлагатай байсан юм.

Энэ төслийг хэрэгжүүлэхдээ түүх, археологи, түүхэн газарзүй, угсаатан судлалын эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлахын зэрэгцээ угсаатны зүй, түүх соёлын өвийн дурсгалыг илрүүлэх, олж бүртгэх, баримтжуулах хээрийн судалгааг 4 удаа зохион байгуулж мэдээлийн сан бүрдүүлэх, байгаль түүхийн мэдээлийн санг нэг дор төвлөрүүлэх, архивийн баримт материалуудыг шүүрдэн үзэж Бурхан халдун уул, түүний тахилга шүтлэг, хамгаалалтад холбогдох баримтуудыг цахим байдлаар хуулбарлан авч нэгдсэн сан бүрдүүлэх гэх зэрэг тодорхой зорилго тавьж ажилласан.

Бидний энэхүү төслийн үр дүнгийн шинэлэг бөгөөд олон талын ач холбогдолтой байдлыг дараах байдлаар тодорхойлж болно.

Нэг. Дэлхийн өв: Бурхан халдун уулын өнөөгийн түүх соёлын өвийг бүртгэн баримтжуулж, судалгааны түвшинг нэгтгэн дүгнэснээр цаашдын судалгааны чиг баримжааг тогтоох, анхаарах асуудлуудыг илрүүлэн гаргаж ирэх, улмаар хадгалалт, хамгаалалт, сурталчилгаа, цаашдын менежментийн төлөвлөлтийг хийхэд шаардлагатай үндсэн мэдээллийн сан бүрдүүлсэн.

Хоёр. Судалгааны ажлын үр дүнд Дэлхийн өв: Бурхан халдун уулын соёлын нөөцийг тодорхой хэмжээнд нээн харуулах, судлан тогтоох, монгол түмний голомт нутаг болох тахилгат хайрхны шүтлэг бишрэл, тайлга тахилгатай холбогдох уламжлалт соёлын элементүүдийг илрүүлэн гаргах, Их хаадын ариун онгоныг хадгалан буй “Их хориг”-ийн судалгааг ахиулах, хадгалалт хамгаалалтын менежментийг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулсан.

Гурав. Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Чингис хааны өлгий нутаг” түүхэн аялал жуулчлалын үндэсний парк байгуулах ажлын хүрээнд Бурхан халдун уулыг цаашдаа нийт монгол туургатны их шүтээн уул болгон зарлаж, аялал жуулчлалыг тодорхой хэмжээнд хөгжүүлэх оновчтой төлөвлөлтийг хийхэд энэхүү төслийн үр дүн чухал эх хэрэглэгдэхүүн болсон.

Төслийн хүрээнд хийгдсэн ажил:

№	Хийгдэх ажил (үр дүнгийн даалгавар)	Тоо хэмжээ	Биелэсэн эсэх
1	Дэлхийн соёлын өв: "Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг"-т хайгуул судалгааны экспедиц ажиллуулж, түүх соёлын өвийг бүртгэх	4 цуврал тайлан	Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт түүх, түүхэн газар нутаг, угсаатны зүй, археологийн чиглэлийн 4 багц хээрийн судалгааг 2019, 2020, 2021, 2022 онуудад зохион байгуулж нийт 5 багц эрдэм шинжилгээний тайлан бичсэн.
2	Дэлхийн өвийн дурсгалт газрын түүх, археологийн дурсгалын мэдээллийн сан бүрдүүлнэ.	1 иж бүрдэл	5 удаагийн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн (Үүнд: Археологийн дурсгалын хайгуул судалгааны үр дүн, баримтжуулалт, угсаатны зүйн судалгааны үр дүн, эх хэрэглэгдэхүүн, түүхэн газар нутгийн судалгааны үр дүн, эх хэрэглэгдэхүүн), 2500 гаруй гэрэл зураг, 20 орчим аудио болон видео бичлэг, 1347 нүүр архивийн баримт, 20 орчим Бурхан халдун ууланд холбогдох өгүүлэл, илтгэлийн

			эмхэтгэл, Бурхан Халдун уул, Балданбэрээвэн хийд, Рашаан хадны дурсгалыг виритуал танилцуулга, Дэлхийн өвийн газар нутаг дахь 200 орчим газар зүйн биетийн байршил, нэрийн судалгаа, газрын зураг, газар зүйн мэдээллүүд гэх зэргийг багтаасан цогц мээдллийн сан бүрдсэн.
3	Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар болон дэлхийн өвийн бүс нутгийн газар усны нэрийн бүртгэл судалгаа	13 х.х	Э.Равдан. <i>Дэлхийн өв-Бурхан халдуны бүс дэх газар нутгийн байршлын толь</i> . УБ., 2023. 104 тал. Энэ тольд Дэлхийн өвийн газрын нутагт хамаарах 200 орчим газар зүйн биетийн байршлыг газрын зургийн нэр, дугаараар нь тогтоон оруулсан. Чингэхдээ Монгол улсын 1:100 000 нарийвчлал бүхий газрын зургаас газрын биетүүдийн байршлыг заахдаа зургийн хэсгийг байршлын тоон үзүүлэлттэй хамтад нь оруулсан нь уг биетийг GPS- гүй тохиолдолд орчны газраар нь тоймлон тогтоох боломжтой болгожээ. Тус бүтээл нь Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн түүхэн газар орны бүх талын судалгааг хийхэд, тус нутаг оронд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал хэрэгцээтэй мэдээлэл агуулсан бүтээл болсон.
4	“Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” болон орчны бүсийн дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газруудын виртуал танилцуулга	3 ш Бүрдэл	Энэхүү төслийн хүрээнд бид Google street view-ийн жишгээр Бурхан Халдун уул, Балдан Бэрээвэн хийд, Биндэр уул болон Рашаан хадны дурсгалын 360 виртуал танилцуулгыг бэлтгэсэн.
5	Бурхан Халдун уулын дэлхийн өвийн газар нутаг дахь байгалийн нөөцийн судалгаа	1 боть тайлан	2020-2022 оны хооронд Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны оролцоотойгоор Бурхан халдун уул, түүний орчны бүсийн байгалийн

			өвийн судалгааг хийж, нэг боть товч тайлан бичсэн.
6	Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгалт газрын аялал жуулчлалын маршрут, газрын зурагтай цомог хэвлүүлэх	1 боть	Зургийн цомог: Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгал газар” нэртэй каталогийг бэлтгэн хэвлүүлэв. Цаасны хэмжээ 25,7 х 25,7, 96 тал. Тус каталогид ашигласан зургууд нь 2019-2022 онд төслийн хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны дүнд цуглуулсан гэрэл зургийн сан болон каталогид зориулан авсан гэрэл зургуудаас бүрдэж байна. Тус каталоги нь Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүх, соёлын өв, байгалийн өв, аялал жуулчлал гэсэн ерөнхий агуулгатай.
7	Дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтанд бүртгэгдсэн Бэрээвэн хийдийн түүхэн зураг, танилцуулгын товхимол хэвлүүлэх	6 х.х	Н.Хатанбаатар, С.Чулуун. <i>Балданбэрээвэн хийд</i> . УБ., 2020. 96 тал.  Энэхүү номонд Монголын дорнод бүсийн томоохон хийд Сэцэн хан аймгийн нутагт оршиж байсан Балданбэрээвэнгийн үүсэл хөгжил, бүтэц, зохион байгуулалт, бурхан шүтээн, хурал ном, аж ахуй-эдийн засгийн түүхийн зарим асууллыг тоймлон өгүүлж, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримтын төв, Оросын ШУА-ийн Санкт-Петербургийн салбарын архивт хадгалагдаж буй түүхэн гэрэл зургаар баримтжуулсан болно.
8	Хан Хэнтий уул (Бурхан Халдун) -ын тахилга тайлгын тухай архивын баримт, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг эмхэтгэх	2 боть	Хан хэнтий уул буюу Бурхан халдун уулын түүхэнд холбогдох 10 илтгэл, 13 өгүүлийн эмхэтгэлийг бэлэн болгосон. Мөн Бурхан халдун уулын тахилга тайлга, өв соёл, хатгаалалтад холбогдох Монголын Үндэсний Төв Архивт хадгалгадаж буй 25 хадгаламжийн нэгжийн 1347 нүүр нугалбаруудыг сканераар хувиалан авч цахим сан бүрдүүлсэн.

			Түүний зарим баримтыг сонгон авч нэг боть тайлан хэвлэсэн.
9	Төслийн эцсийн тайлан бичиж захиалагч, санхүүжүүлэгчид хүлээлгэн өгөх	1	Төлсийн эцсийн тайланг хуулийн хугацаанд нь бичиж, захиалагч талд хүлээлгэн өгсөн.

**Түлхүүр үгс:** Бурхан халдун, Хан хэнтий, тахилга, соёлын өв, хээрийн судалгаа, виртуал танилцуулга

### НЭГ. ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг нь 2015 онд Дэлхийн соёлын өвийн жагсаалтанд албан ёсоор бүртгүүлснээс хойш дөрвөн жилийн хугацаанд хадгалалт хамгаалалт, түүх соёлын өвийн судалгааны ажил хийгдээгүй байсан учир Чингис хааны шүтээн хайрхан Бурхан Халдуны тахилгын уламжлал, “Их Хориг”-ийн түүхэн учир холбогдол, Хоригийг сахигч Урианхад нарын удам хойчис хаана тархан суурьшсан, XIX-XX зууны эхэн үеийн тайлга тахилгын зан үйлийн онцлог, ялангуяа түүхэн газар усны зарим нэрс хэрхэн өөрчлөгдсөн, орчны бүсийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан үүсгэх зэрэг асуудлыг тусгай захиалгат төслийн хүрээнд судлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зорилготой хэрэгжүүлсэн. Үүний тулд түүх, археологи, газарзүй, угсаатан судлалын шинжлэх ухааны салбарын эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийн түвшинд нэгтгэн дүгнэх, “Монголын нууц товчоон” ба бусад эх сурвалжид бичигдсэн Бурхан халдун уулын тухай мэдээ баримтуудыг нягтлах, цуглуулах, түүх-соёлын өвийг бүртгэх, археологийн хайгуул судалгаа явуулах, Бурхан халдун уулын тахилга шүтлэг, хорио цээртэй холбоотой угсаатны зүйн хээрийн судалгаа явуулж мэдээлэл цуглуулах, тус сэдэвт холбогдох архивын баримтыг шүүрдэн үзэх, цахим сан болгох, Бурхан халдун уул, түүний орчны бүсийн чухал дусргалуудын 3D танилцуулга бэлтгэх гэх зэрэг бодитой зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. Дээрх зорилтуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоон баримжуулж, улмаар үндэсний түүх, соёл иргэншлийн аюулгүй байдлын нэг чухал дархлаа болсон Бурхан халдун хайран уулын тухай мэдээлийн сан бүрдүүлэх, Дэлхийн өвийн газарт аялал жуулчлалын төлөвлөлт хийх, цаашдын хадгалалт, хамгаалалтын оновчтой төлөвлөгөө боловсруулахад үндсэн мэдээлэл бүрдэх юм.

Энэхүү захиалгат төсөл БСШУС-ын сайдын 2019 оны 05 сарын 24-ний өдрийн А/324 тоот тушаалаар батлагдсан боловч ШУТ-ийн Сан 2019 оны 09-р сард гэрээ байгуулж, тус оны 10-р сард эхний санхүүжилт өгсөн.

### **ХОЁР: ТӨСЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- **Төслийн удирдагч:**

1. *Сампилдондовын Чулуун*, РД: Н377071470 /Чингис хаан музейн захирал, академич

#### **8. Төслийн зохицуулагч:**

1. *Батмөнхийн Цогтбаатар*, РД: СМ67092811 /ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор /Ph.D/, дэд профессор

#### **9. Төслийн гүйцэтгэгч, оролцогчид:**

*Энхбаярын Равдан*, РД: ХА44070114 /МУИС-ийн Эмерит профессор, Хэл шинжлэлийн ухааны доктор /Sc.D/

*Лхүндэвийн Ганбат*, РД: СУ81070478 /ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэнгийн Дундад зууны түүхийн салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор /Ph.D/, дэд профессор/

*Бямбасүрэнгийн Хашмаргад*, РД: ХВ72112775 /Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга/

*Цэдэндашийн Түвшинбат* РД: ВЖ87111715/Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дэлхийн өв хариуцсан мэргэжилтэн/

*Шаравын Цолмон* РД: ЕЙ79122401 /Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн/

*Жүмпэрэлийн Саруулбуян*, РД: ЧМ57060111 /Урлаг судлалын ухааны доктор /Ph.D/, профессор/

*Насан-Очирын Эрдэнэ-Очир*, РД: ХЖ79101036 /ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Хүрэл, төмрийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор /Ph.D/

*Ганбатын Алтансүх*, РД: ВМ87012812 /ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн Угсаатан судлалын салбарын эрдэм шинжилгээний дэд ажилтан, доктрант/

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Жуковын гудамж, ШУА-ийн I байр, Археологийн хүрээлэн  
Утас: 976-11-458305  
Факс: 976-11-458305  
Э-шуудан: [samchuluun@gmail.com](mailto:samchuluun@gmail.com)



## ГУРАВ: ТӨСӨЛ ГҮЙЦЭТГЭХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Бурхан Халдун уул нь монгол туургатны эх түүхийн голомт нутаг билээ. *“Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бэртэ чоно ажгуу. Гэргий нь Хоо марал ажээ. Тэнгэс гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ Бурхан халдунаа нутаглаж бүхүйд төрсөн Батачихан ажгуу (МНТ§1)”* хэмээн өнөөгөөс 779 жилийн өмнө бичиж дууссан Монголчуудын түүх, утга соёлын гайхамшигт дурсгал “Монголын нууц товчоон” түүхэн сурвалж эхэлдэг. Чингис хаан “...Бурхан халдуныг өглөө бүр мялаасугай, өдөр бүр өчсүгэй, ургийн ураг минь ухан мэдтүгэй” (МНТ§103), “Гурван мөрний тэргүүнд хэнийг ч бүү буулгагтун” (МНТ§179) хэмээн айлдсан захиасыг Монголчууд үеийн үед мөрдөн дагасаар, тайн тахисаар, хайрлан хамгаалж ирсэн билээ.

Түүхэн эх сурвалжуудад Бурхан Халдун уул нь Чингис хаан болон түүний удмын хаадын “их ясыг тавьсан” дархан газар болох “Их Хориг”-той салшгүй хамт тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал Перс түүхч Рашид-Ад-Диний “Судрын чуулган” /1311/-д “Чингис хаанаас хойш түүний хөвүүд эзэн хааны их ясыг тавьсан Бурхан Халдун гэдэг дархалсан газар”... “Дурдан буй газарт Чингис хааны хөвүүдээс Тулуй хаан, Мөнх хааны их яс бас Хубилай хааны хөвүүд, тэдний овгийнхны ясыг ч тавьсан ажээ”. “Гүрэг (Хориг)-ийг мянган урианхан харгалзаж байсан бөгөөд Бурхан Халдунд хүрэх гол ганцхан жим замыг тосуулан байгуулжээ” хэмээн бичжээ. Энэ зам дагуу уулын гурван аманд суусан харуулыг хэн ч гэтэлж Их хоригт орж чаддаггүй байсан хэмээн өнөөг болтол хэлэлцдэг. Энэхүү дархан бүс нутаг болох “Их Хориг” нь одоо ч нэрээ хадгалсаар, эдүгээ Бурхан Халдун уулын баруун өмнө талаас очих гол зам дагуу Гурван хориуд буюу Дээд хориуд, Дунд хориуд, Мухар /доод/ хориуд нэртэй байна.

XIII зууны үеэс Бурхан Халдун уулыг дархлан хамгаалж, тахин шүтэж ирсэн уламжлал нь лавтай ХҮI зуун хүртэл үргэлжилсэн бөгөөд улс төрийн хямрал, харийн эрхшээлд орсон цаг үед тодорхой хэмжээнд тасалдаад 1818 оноос дахин сэргэж Манжийн хааны зарлигаар Халхын хаад, Их шавийнхан хамтран жил бүрийн хавар, намар хоёр удаа тахидаг болжээ. Энэхүү тахилга 1930-аад он хүртэл үргэлжилж байгаад социалист улс төр, үзэл суртлын нөлөөгөөр 60 гаруй жил тасалдсаны эцэст 1995 оноос Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн тахилга үйлддэг болсон билээ. Улмаар Бурхан халдун уулыг 2013 онд Монгол Улсын Засгийн Газрын 364 тоот тогтоолоор Монгол түмний “Үндэсний бахархалт хайрхан”-аар

өргөмжилсөн ба 2015 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн жагсаалтанд албан ёсоор бүртгэгдсэн билээ. Ингэснээс Дэлхийн соёлыг өвийн жагсаалтад бүртгэгдсэн Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн талаар судалгаа шинжилгээний ажлыг хийх үүргийг Монгол улсын Засгийн газар ЮНЕСКО-гийн өмнө хүлээсэн юм.

Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг нь дэлхийн соёлын өвийн жагсаалтанд албан ёсоор бүртгүүлснээс хойш дөрвөн жилийн хугацаанд хадгалалт хамгаалалт, түүх соёлын өвийн судалгааны ажил бараг хийгдээгүй байсан тул Чингис хааны шүтээн хайрхан Бурхан Халдуны тахилгын уламжлал, “Их Хориг”-ийн түүхэн учир холбогдол, Хоригийг сахигч Урианхан нарын удам хойчис хаана таран суурьшсан, XIX-XX зууны эхэн үеийн тайлга тахилгын зан үйлийн онцлог, ялангуяа түүхэн газар усны зарим нэрс хэрхэн өөрчлөгдсөн, орчны бүсийн соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан үүсгэх зэрэг асуудлыг тусгай захиалгат төслийн хүрээнд судлан шинжлэх, нэгтгэн дүгнэх шаардлагатай болсон.

Бурхан Халдун, Их хориг, Гурван мөрний эх бол дан ганц шүтлэг бишрэл, тахилга тайлгын газар байгаагүй монголчуудын улс төрийн сэтгэлгээний цөм, оршихуйн үндэс байсан хэмээн судлаачид үздэг. Гэсэн хэдий ч өнөөг болтол хугацаанд Бурхан Халдун уулын тахилгын уламжлал, шинэчлэл, учир холбогдол төдийгүй орчны бүсийн түүх соёлын өвийн бүртгэл, газар усны нэрийн хувирал өөрчлөлт, овгийн бүрэлдхүүн, угсаатны зан үйлийн онцлог, нүүдэл суурьшил зэрэг асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлах ажил бараг хийгдээгүй байна. Гэвч сүүлийн жилүүдэд ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Хан Хэнтийн Улсын Тусгай Хамгаалалттай Газрын Захиргааны хамтын санаачлагаар Бурхан Халдун уул орчмын түүх, соёлын өв, тахилга, хүндэтгэлийн уламжлалыг судлах, хадгалж хамгаалах, сурталчлан таниулах чиглэлээр өөрсдийн нөөц, боломжоороо зарим ажлыг хийсээр байгаа билээ.

### **ДӨРӨВ. СЭДЭВТ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЕ ШАТ**

Төслийн хүрээнд нийт 3 жилийн хугацаанд хийгдэх ажлын төлөвлөгөөг жил тус бүрээр гаргаж, тухайн ажлын эхлэх болон дуусах хугацаа, хариуцсан ажилтны нэрсийг төлөвлөн ажилласан боловч 2021 оны санхүүжилт удааширч хоцорч орж ирснээс шалтгаалан төслийн хугацаа 2022 он болж сунсан. Тиймээс доорх хүснэгтэд төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын гүйцэтгэсэн цаг хугацаа, гүйсэтгэсэн хүнээр тодорхойлон гаргав. Үүнд:

Д/д	Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлын нэр	Эхлэх дуусах хугацаа (он, сар)	Гүйцэтгэгчдийн овог, нэр, мэргэжил
<b>2019</b>			
1	Түүх, археологи, газарзүй, угсаатан судлалын шинжлэх ухааны салбарын эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаа шинжилгээний ажлын үр дүн баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.	6-7 сар	С.Чулуун, Түүхч Э.Равдан, Хэл шинжээч Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч Ж.Гэрэлбадрах, Түүхч Ц.Түвшинбат эрх зүйч Ш.Цолмон байгаль судлаач
2	Төслийн багийн зөвлөгөөн зохион байгуулна.	7 сар	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Б.Хашмаргад, Байгаль шинжлэл Ж.Гэрэлбадрах, Түүхч,
3	Төслийн хүрээнд бичиж хэвлүүлэх бүтээлүүдийн онол, арга зүй, бүтцийг хэлэлцэх	8-9 сар	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Э.Равдан, Хэл шинжээч Ж.Саруулбуян, Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч Ч.Амартүвшин, Археологич
4	Дэлхийн өвийн дурсгалт газраар хээрийн шинжилгээний экспедици зохион байгуулна.	9-10 сар	С.Чулуун, Түүхч Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч Б.Хашмаргад, Н.Эрдэнэ-Очир, Археологи Ц.Түвшинбат эрх зүйч Н.Гонгоржав, соёл судлаач
5	Гадаад, дотоодын архив, номын санд судлаачдыг ажиллуулж шинэ баримт материал цуглуулна.	9-12 сар	С.Чулуун, Түүхч Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч Х.Мэндсайхан, Түүхч Н.Хатанбаатар Түүхч
6	Дэлхийн өвийн дурсгалт газар түүний орчны бүсийн түүх, соёлын өвийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эхлүүлэх	10 сард	Г.Алтансүх, Түүхч Г.Энхбат, Соёл судлаач Ч.Амартүвшин, Археологич Н.Эрдэнэ-Очир, Археологич
7	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын тайлан	12 сард	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Г.Алтансүх, Түүхч

	бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх		
<b>2020</b>			
1	Гадаад, дотоодын архив, номын санд судлаачдыг ажиллуулж шинэ баримт материал цуглуулна.	1-6 сар	С.Чулуун, Түүхч Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч Х.Мэндсайхан, Түүхч Н.ХатанбаатТүүхч
2	Дэлхийн өвийн бүс нутгийн газар усны нэрийн судалгааны экспедици зохион байгуулна.	5 сар	Э.Равдан, Хэл шинжээч Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч Н.Одхүү, Газарзүйч Ц.Түвшинбат эрх зүйч Н.Гонгоржав, соёл судлаач
3	Бурхан Халдун уулын дэлхийн өвийн газар нутаг дахь байгалийн нөөцийн судалгаа	3-6 сар	Б.Хашмаргад, байгаль судлал Ц.Түвшинбат эрх зүйч Ш.Цолмон байгаль судлаач
4	Дэлхийн өвийн дурсгалт газар түүний орчны бүсийн түүх, соёлын өвийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх	2-10 сар	Г.Алтансүх, Түүхч Г.Энхбат, Соёл судлаач Б.Батдалай, Археологич Н.Одхүү, Газарзүйч Ц.Түвшинбат эрх зүйч Н.Гонгоржав, соёл судлаач
5	“Их Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” түүний орчны бүсэд хамаарах урьдчилсан жагсаалтанд бүртгэгдсэн дурсгалт газруудын виртуал танилцуулгын хувилбар бэлтгэх, дуусгах	5, 10 сард	Б.Цогтбаатар, Археологич Б.Алтансүх,к/ графикч Н.Эрдэнэ-Очир, Археологи Б.Батдалай, Археологич
6	Дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтанд бүртгэгдсэн Бэрээвэн хийдийн түүхэн зураг, танилцуулгын товхимол хэвлүүлэх	5 сар	Н.Хатанбаатар, түүхч Х.Мэндсайхан, түүхч
7	Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгалт газрын аялал жуулчлалын маршрут, газрын зурагтай, цомог бэлтгэх	10-12 сар	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Ж.Саруулбуян, Урлаг судлаач, Б.Хашмаргад, Г.Алтансүх, Түүхч Н.Эрдэнэ-Очир, Археологич

			Б.Алтансүх, Графикч
8	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын тайлан бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх	6,12 сард	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч
<b>2021</b>			
1	Дэлхийн өвийн дурсгалт газрын түүх, археологийн дурсгалын мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.	1-9 сар	Г.Алтансүх, Түүхч Г.Энхбат, Соёл судлаач Б.Батдалай, Археологи Ц.Түвшинбат эрх зүйч Н.Гонгоржав, соёл судлаач
2	Дэлхийн өвийн дурсгалт газраар хээрийн хайгуул шинжилгээний экспедици зохион байгуулна.	6, 9 сард	С.Чулуун, түүхч Б.Цогтбаатар, Археологич Г.Алтансүх, Түүхч Н.Эрдэнэ-Очир, Археологич Ч.Амартүвшин, Археологи
3	Хан Хэнтий уул(Бурхан Халдун) -ын тахилга тайлгын тухай архивын баримт, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг эмхэтгэх	10-12 сар	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч
4	Санхүүгийн болон үйл ажиллагааны явцын тайлан бичиж, санхүүжүүлэгч, захиалагчид хүргүүлэх	6 сард	С.Чулуун, Түүхч Г.Алтансүх, Түүхч
5	Төслийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан бичиж хүлээлгэн өгөх	12 сард багтаана	С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Г.Алтансүх, Түүхч
<b>2022</b>			
1	Дэлхийн өвийн дурсгалт газрын түүх, археологийн дурсгалын мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.		С.Чулуун, Түүхч Б.Цогтбаатар, Археологич Л.Ганбат, Түүхч Г.Алтансүх, Түүхч
2	Хан Хэнтийн тусгай хамгаалалттай газар, Бурхан Халдун уулын дэлхийн соёлын өвийн бүс нутгийн газар усны нэрийн толь бэлтгэн хэвлүүлнэ.	9-10 сар	Э.Равдан, хэл шинжээч П.Энхжаргал Г.Алтансүх, Түүхч Н.Одхүү, Газарзүйч

## ТАВ. ТӨСӨЛТ АЖЛЫН ЭЦСИЙН ҮР ДҮН

### 5.1. ХЭЭРИЙН СУДАЛГАА

Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн түүх, түүхэн газар нутаг, угсаатан, археологийн чиглэлийн 4 хээрийн судалгааг 2019, 2020, 2021, 2022 онуудад зохион байгуулж нийт 5 багц эрдэм шинжилгээний тайлан бичсэн.

#### 5.1.1. 2019 оны хээрийн судалгаа:

“Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн орчны бүсийн түүх, соёлын өвийн судалгаа” сэдэвт захиалгат төслийн хүрээнд түүхэн газар нутгийн нэр, байршлыг тодруулах угсаатны зүйн хээрийн судалгааны ажлыг 2019 оны 10 сарын 02-оос 11-ний хооронд ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн Эзэнт гүрэн ба дунд үеийн Монголын түүхийн судалгааны салбарын ЭША, доктор (Ph.D) Г.Алтансүх, тус хүрээлэнгийн С.Бадамхатаны нэрэмжит угсаатны судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Э.Пүрэвжав нар хийж гүйцэтгэв. Энэхүү судалгаанд Төв аймгийн Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Жаргалтхаан сумын уугуул иргэдтэй уулзаж түүхэн газар нутгийн нэр, Бурхан Халдун уулыг тойрсон тахилгат газар нутгийн тухай аман мэдээ цуглуулсан. Энэхүү хээрийн судалгаа нь Бурхан халдун хайрхан уултай холбоотой шүтлэг бишрэл, тахил тайлгын тухай мэдээлэл цуглуулах, Бурхан Халдун хайрхан уул орчмын газар усны нэрийг бүртгэн авах, тус уултай холбоотой домог хууч яриа цулуулахад чиглэсэн.

Судалгааны ажлын явцад Хэнтий аймгийн Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутагт ажиллаж, уугуул иргэдээс мэдээлэл цуглуулсан бөгөөд түүхэн дурсгалт газруудын гэрэл зургийг авч баримтжуулсан болно. Үүнд түүхэн дурсгалт газар нутгийн байршил, нэрийн судалгаанд тодорхой үнэ цэнтэй эх хэрэглэгдэхүүн болох хэд хэдэн чухал газруудыг тэмдэглэж авсан. Тухайлбал, Хэрлэн голын эх орчмоор эртний түүхэн Бүрги эрэг хэмээх газрын байршилтай холбогдох Улаан эрэг, Хөх эрэг, Бүгээн эрэг, Эрэг бүрэг гэх зэрэг олон газрыг байршлыг нь холбогдох аман ярианы хамтаар тэмдэглэж авсан. Хурхын голын эхэн, Жаргалантын голын эхэнд орших Харгантын энгэр хэмээх газрыг тэмдэглэж авсан нь МНТ-ны Айл харагана хэмээх газрын байршилтай тодорхой хэмжээнд холбоотой байх магадлалтай байна. Мөн Бурхан халдуны өвөр, Хэрлэн голын баруун эрэгт Сүүл өндөр хэмээх газар оршиж буй нь

МНТ-д гардаг Тэргүүн өндөрийн байршлийг тогтоохон хэрэг болохуйц нэгэн газар зүйн биет болж болохоор юм. Энэ мэтчилэн Хэрлэн голын эх, Бурхан халдун хайрхан уулын өврийн газар нутгийн нэрс, Цэнхэрийн голын хөндийн газар усны нэрс, Харзүрхний хөх нуураас Хурх голын эх рүү орох гол үндсэн замын дагуух газар усны нэр, Хурхын хөндийн эхний газар усны нэрсийг бүртгэн авч, гэрэл зургаар баримтжуулсан. Үүний зэрэгцээ Бурхан халдун хайрхан уулын тахилга, тайлга, домог хууч яриатай холбоотой мэдээллүүдийг цулуулж авсан юм. Мөн түүхэн дурсгалт газар орны тухай мэдээллийг ч лавлан асууж байв. Энэ бүх мэдээллийг эрдэм шинжилгээний тайланд судалгааны эх хэрэглэгдэхүүнд болгон хавсаргасан болно.

**Бурхан Халдун хайрхан уулын өвөр, Хэрлэн голын эх орчмын  
зарим газар усны нэр**



*Бурхан Халдуны араар харагдах өндөр уул Баруун түшлэг. Наад талын нам нь Дэлүүний нуруу, Дэлүүний нурууны наад үзүүрийг нь Хадан хошуу.*



*Хадан хошууны чанх цаана харагдах нь тэмээн бөх шиг хоёр бөндгөрийн баруун талынх нь Хүрэн хад, Зүүн талынх нь Мухар жүхүүжин, энэ хоёрын дундуур харагдаж буй нь Баян-Өндөр.*




*Баатар хайрхан, Баатар хайрханы наад талын нам хамруудыг Таяа гэдэг. Таяагийн горхи гэж буй. Илүүрийн гол наад талаар нь орж ирнэ. Таяа нь Баатар хайрханаасаа салбарлаж, Хэрлэнрүү орсон жижиг хошуунуудыг хэлдэг.*





*Баатар хайрханы урдуур харагдаж буй наад талын өндөр нь Богд ян, түүний наад талын модтой арыг Солооч гэн. Солоочийн наад талын модтой ар нь Бунханч гэдэг.*



*Хойд хориудын ам. Хойд хориудын эхний зоог Дашноровын зоо гэдэг.*



*Хойд хориудын амны урд хэсэгт нийлэх их модыг Үүд мод гэдэг.*



*Дунд хориуд. Дунд хориудын эхэнд буй уулыг Баянбуурал гэнэ.*



*Ант, Дунд хориудын урд талын жижиг ам.*



*Айлууд буусан шар энгэрийн Энгэр нуур гэдэг. Байшингийн хойд талд Энгэр нуур нь байдаг. Энгэр нуурын цаад өндөрийг Ширээтийн гозгор гэнэ.*



*Голд байх ганц толгойг Хоньчийн толгой гэнэ. Түүний наад талын шар үзүүрийг Батцагаан гэдэг. Энэ амаар зүүнтэйгээс Тэнүүний гол орж ирдэг. Хоньчийн толгойн дээгүүр харагдаж буй их зоог Ар хадат гэдэг.*



*Тэнүүний хөндийн урд орших тэмээний бөх шиг хоёр өндрийн наад талынх нь Цогт өндөр. Цаад талынхыг нь Агуйт гэдэг. Түүнээс цаагуур харагдах урт хадтай зоог Дадалын зоо гэдэг.*



### 5.1.2. 2020 оны хээрийн судалгаа:

#### Археологи, түүхэн газар зүйн хээрийн судалгаа

Тус хээрийн судалгааны ажлыг 2020 оны 09 сарын 04-өөс 17-ны өдрийг дуустал нийт 14 хоногийн хугацаанд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), дэд профессор Б.Цогтбаатар, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Эзэнт гүрэн ба дунд үеийн Монголын түүхийн судалгааны салбарын ЭША, доктор (Ph.D) Г.Алтансүх, Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Энхбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Алдармөнх, Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны мэргэжилтэн Б. Өнөрбаяр, П.Хатансайхан, Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын дарга Б.Хашмаргад, Байгаль хамгаалагч Д.Батжаргал, Ө.Бат-Амгалан, гэрэл зураг, 3D баримтжуулалтын мэргэжилтэн Б.Алтансүх, жолооч Г.Дорж, Г.Төмөр, Б.Валя гэсэн 13 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж түүх, угсаатны зүй хээрийн судалгаа, археологийн дурсгалын хайгуул судалгаа хийсэн.



*Судалгааны багийн бүрэлдэхүүн*



### Хээрийн судалгааны маршрут

Хээрийн судалгааг Төв Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумдын нутаг, Хэрлэн, Онон, Туул гурван голын эх орчмын нутагт хийсэн. Энэ удаагийн хээрийн судалгаанд түүхэн газар зүй, угсаатны зүйн судалгаа, археологийн хайгуул судалгаа хийсэн юм.

Археологийн хайгуул судалгаанд Бурхан Халдун хайрхны өвөр, Бэлийн овоо, Дунд овоо, Тэнгэрийн овоо, болон баруун, зүүн суга жалга, Бага ахын нуруу, Дунд ахын нуруу, Их Ахын нуруу, Буурал ахын нурууг, Ах бунхант, Өвөр Бунхант, Хойд ба Дунд хориудын зоо нуруу, Даш норовын зоо зэрэг газар орны ам, сүв, салбар салаанд морин хайгуул хийсэн. Мөн өмнөх судалгаануудаар бүртгэгдсэн Сүүл өндөр, Далхай нуурын хойд эрэг, Шар энгэр зэрэг газарт байх археологийн дурсгалуудыг, дахин бүртгэх координатыг нь авах, дахин тодорхойлолт үйлдэх судалгаануудыг хийж гэрэл зургаар баримтжуулав.

Угсаатны зүйн судалгаанд нутгийн уугуул иргэдээс аман түүхийн мэдээ цуглуулах арга зүйг энэ удаагийн хээрийн судалгаанд ашиглаж, Бурхан халдун хайрхан уултай холбогдох хорио цээр, тахилга шүтлэгийн холбогдолтой мэдээлэл цуглуулах, Хэрлэнгийн цагаан арал, тус Цагаан аралд байсан Алтан юүлдийн (зүлдийн) овооны тухай мэдээлэл цуглуулсан болно. Мөн Бурхан халдун уулын орчны бүс, Гурван голын эхэн орчмын нутгийн газар усны нэр, тахилга уул усны тухай сурвалжлан мэдээлэл цуглуулсан.

Түүхэн газар зүйн судалгаанд түүхэн үйл явдал өрнөсөн газар орныг нүдээр үзэж, газар зүй, байгаль орчны хүчин зүйлсийг газар дээр нь дахин тодорхойлж, түүхэн сурвалжуудад буй мэдээ баримттай тулгаж, нягтлах судалгааг хийв. Үүний хүрээнд Бурхан халдун хайрхан уул, Хүрэлх, Их Хориг, Хөхөрт жибур зэрэг газрыг байршил нэрийн судалгааг тодруулах ажил хийгдсэн.

Археологийн хайгуул судалгааг авто машин ба морин тээвэр ашиглаж гүйцэтгэсэн. Гэхдээ тухайн бүс нутагт торлог ургамал маш өндөр ургаж газрын гадаргыг битүү бүрхсэн нь энэхүү хайгуулын судалгаанд нэлээд бэрхшээл учруулж байсан бөгөөд зарим дурсгал анзаарагдалгүй үлдэх нөхцөлийг бүрдүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Археологийн хайгуул судалгааны явцад Ар Бунхант, Бурхан Халдун хайран өвөр, Бэлийн овоо, Дунд овоо, Тэнгэрийн овоо, болон баруун, зүүн суга жалга, Бага ахын нуруу, Дунд ахын нуруу, Их Ахын нуруу, Буурал ахын нурууг, Ах бунхант, Өвөр Бунхант, Хойд ба Дунд хориудын зоо нуруу, Даш норовын зоо зэрэг газар орны ам, сүв, салбар салаанд морин хайгуул хийсэн. Мөн өмнөх судалгаануудаар бүртгэгдсэн Жаргалантын ам, Сүүл өндөр, Далхай нуурын хойд эрэг, Шар энгэр зэрэг газарт байх археологийн дурсгалуудыг, дахин бүртгэх координатыг нь тулгах, дахин тодорхойлолт үйлдэх судалгаануудыг хийж гэрэл зургаар баримтжуулав. Үүнд: Нийт хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш 7, Хүрэл зэвсгийн үеийн хиригсүүр 1, Хүрэл зэвсгийн үеийн чулуун байгууламж 1, Монголын үеийн булш 4-ийг бүртгэлээ.



*Дунд овооны эргэн тойронд ваарны хагархай их хэмжээгээр илэрдэг*



*Хүрэлийн үеийн булш*

### **Түүхэн газар зүйн судалгаа**

Энэхүү хээрийн судалгааны дүнд Түүхэн газар усны нэрийг бүртгэж, гэрэл зургаар баримтжуулах, Бурхан халдун хайрхан уул, түүнийг хүрээлсэн газар нутгийн нэрийг бүртгэж, гэрэл зургаар баримтжуулах ажил хийж гүйцэтгэсэн. Үүний дүнд Монголын нууц товчоон дахь Хөхөртү жибуур, Хүрэлх болон Их Хориг зэрэг түүхэн



газрын баршилтай холбоотой шинэ хэрэглэгдэхүүн цуглуулсан юм. Судалгааны үр дүнгээс дараах хоёр илтгэлийг хэвлүүлсэн.

1. Алтансүх Г., Мөнхбаатар Ш. Монголын нууц товчоон дахь Būrgi-ergi-ийн байршлын тухай // Монголын нууц товчоон: түүхэн газар нутгийн судалгаа (Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). УБ., 2020. т. 73-78
2. Алтансүх Г., Цогтбаатар Б. “Их хориг”-ийн газар нутгийн зарим асуудалд // “Дэлхийн соёлын өв – Бурхан халдун уул: судалгаа, менежментийн зарим асуудал” эрдэм шинжилгээний хурал. Улаанбаатар. 2022.09.16

Түүхэн газар нутгийн хээрийн судалгааны зарим үр дүн.

### **ХӨХӨРТ ЖИБУР**

Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн нь: Тус зохиолын 115-р зүйлд *temüjin to'oril-qan jamuqa qurban qamtutcu merkid- ün corqan ger coqoli'ulju coqtai emeyi arbilaju orqan selengge qoyar-un talqun-aral-aca icurun temüjin jamuqa qoyar qamtu[t]cu qorqonaq-jubur jorin icuba to'oril-qan icurun burqan- qaldun-nu gerü-ber hökörtü-jubur da'arin qaca'uratu-subcit huliyatu-subcit da'arin görü'en inu abala'at tu'ulayin qara tün-ni jorin icuba* “Тэмүжин, Тоорил хан, Жамуха гурав хамтарч Мэргэдийн цурхан гэр цуулж, цогтой эмийг аривлаж, Орхон, Сэлэнгэ хоёрын Талхун арлаас няцруун Тэмүжин, Жамуха хоёр хамтарч Хорхонаг жибур зорин няцав, Тоорил хан няцруун Бурхан халдуны гэрүгээр Хөхөрт жибур даарин Гацуурт сүвчид, Улиат сүвбчид даарин гөрөөн авлаад Туулын Хар түнийг зорин няцав” гэсэн мэдээнд нэг л удаа гардаг. Энэ мэдээг гүүш Лувсанданзан бээр “*burqan-qaldun-i gerübei. Üker-tü jibür dayarin qoyur-a-tu ebe-yin uliy-a-tu qabçil dayarin göröged-i inu abalayat tuyula-yin qara tün (siyui) jorin niçuba (qaribai)*. хэмээн бичжээ.<sup>1</sup>

### Судалгааны тойм:

Энэхүү түүхэн газрын тухай судалгааны тоймыг профессор Э.Равдангийн бүтээлээс тоймлон авч үзвэл дараах байдалтай байна. “Эл газраар Тоорил хан ан гөрөө хийсээр Туулын Хар түндээ буцах бөлгөө. Тиймээс бидний үзлээр Туулын Хар түнд ханы ордны туурь өдгөө нэгэнт олдсон гэж үзвэл тэр нь өнөөгийн Улаанбаатар

---

<sup>1</sup> Чоймаа Ш. “Монголын нууц товчоон”, Лувсанданзаны “Алтан товч” эхийн харьцуулсан судалгаа. УБ., 2002. т. 65

хотоос холгүй Сонгино Хайрхан уулын баруун үзүүр дэх Бөхөг Түргэний гол Туул голд нийлж байгаа битүү шугуй бүхий, нар эрт хүүшилдэг уужим тохойг гэж үзвэл Бурхан халдуны араар буцсан хүмүүс Улаанбаатарын зүүн, зүүн хойд талаас ирэх нь илүү магадлалтай хэмээн цөөнгүй судлаач үзжээ. Х. Пэрлээ абугай (1958, 10-р тал): “(Х)окору жубур. 115 §. Бага Хэнтий, Гачууртын ам хоёрын хооронд, 113-р уртраг, 50-р өргөргийн хавьд байсан бололтой” гэжээ. Пэрлээ гуайн эл тодорхойлолтыг эшлэн *сүбчид* эртний дэвсгэр нэрийн тухай Ч. Догсүрэн (1978, 292-р тал) өгүүлэлдээ: “Уул хоорондын уйтан ам. Одоо Улаанбаатараас зүүхэн тийш байгаа Гачууртын ам, Улиастайн ам хоёр газрыг *сүбчи* гэдэг байжээ. Уул үгийг одоо аман яриа болон бичигт хэрэглэхээ бүр больжээ. Харин төв халхууд *амсар*, *сүв* газар хэмээн хэлэлцсээр буйн *сүв* нь (Нууц товчооны 240-р зүйлд *mör*, *horum*, *sūbes* гэдэг бие даасан нэр буй.) Үүнээс үзэхэд *сүв* гэдэг биеэ даасан нэр тэр үед байсан бөгөөд уул үг *нэвтрэх газар* гэсэн ерөнхий утгатай нэр байсан бололтой” гэж тэмдэглэжээ. Эл газрын байршлыг Х. Пэрлээ гуайн заасныг Элдэндэй, Ардаажав нар (1986, 292-р тал), Ш. Шагдар, С.Дамдинсүрэн нар (2006, 39-р тал) хүлээн зөвшөөрч тэмдэглэжээ.

Х. Пэрлээ гуайн дээрх саналын талаар I de Rachewiltz (2004, vol. I. p.435-6) : “To’oril returned to his camp on the Túla (see above, n.96) by way of the Hórkórtü Valley north of Burqan Qaldun - this valley in the Greet Khentie is still unidentified- and two mountain passes (?) Qač’uratu Subčit and Huliyatu Subčit. According to Perlee<sup>2</sup> (1958, p. 7, 5 Э.П..) the former corresponds to present day Gačuur or Gačuuryn Am east of Ulan Bator at 47°N and 107°E, and latter to Uliatin Am (Uliastain am) at Perlee<sup>2</sup> (1958, p.5 Э.П.) states that the term *subčit* is the plural of *subči*, a term used by the Mongols in ancient times for mountain pass (=am[a]sar) Cf. Perlee<sup>4</sup>, 92 (Kh.Perlee. On Some Place Names in Secret History of Mongols, tr. By L. Moses, MSt 9:1985-86, 83-102 Э.П.). This term may be related to *sūbe* ‘opening, narrow passage’) There are two *subčit* mentioned in this passage: Qač’uratu (= pmo. Qačayuratu, lit. “Having Aspens’ Subčit. In the YS<sup>2</sup>, 2, 29, (МНТ-ы хятад сийрүүлэг, 1976) Э.П.) there is mention of region called of the Three Sūbči(t), where Tolui visited his brother Ögödei in the summer of 1229. Tolui was then regent of the empire and as ‘guardian of the hearth’ his residence was at Činggis qan’s former *ordos* at Kóde’s Aral by the Kerulen. We know that soon after this meeting the great *qurilta* that elected Ögödei was held right there (see de Rachewiltz 1993/948 127; and below, n.269) We also know that ‘Ögödei liked spending part of the summer in the mountains (see Boule 1972, 127) It is then logical to assume that ‘the region of the Three Sūbči(t)’ of the YS was mountainous area south Burqan Qaldun (= Khentei Khan) and

east and north-east of present-day Ulan Bator, thus confirming the localization given for two *sudcit* in the SH, and Perlee's identification." хэмээн өгүүлжээ. Рахевильц энд Пэрлээ гуайн *субчид* – *субчи* (сүв) хослолын –*д* олон тооны нөхцөл болохыг тэмдэглээд МНТ-ы 1976 онд хэвлэгдсэн хятад сийрүүлэгт гутгаар *субчи*-йг Өгөөдэй хаан зууны ордтой холбон Бурхан халдуны арын ууланд буйг тэмдэглэжээ. Тэр бээр Х. Пэрлээ гуайн Гачуурт, Улиастайн хөндийг Hökörtü Valley гэж үзсэнийг нотолсон байна.

Х. Пэрлээ гуайн дээрх тодорхойлолтыг цөөнгүй судлаач аль болохоор баяжуулж уг газрыг тов тодорхой болгоход анхаарсан байна. Тухайлбал, судлаач Г. Бадамсамбуу (2014, 138-р тал)-д энэ тухай өгүүлэхдээ: “*Үхэрт хөндий* Ван хан өнөөгийн Чингисийн хүр уулаас (Хуба-хаягаас) нэг их холгүй ан хийгээд Туулыг уруудан харьжээ. Дээр дурдан буй *Өхөртү жубур* Тээл-Тэрэлжийн бэлчрээс (Хуб-хаяад ойр) үргэлжлэх төгөл шугуй бүхий хөндийн аль нэгтэй байгаа нь тодорхой байна. Гурван Баян, Жалман, Тэрэлж, Будлан, Дулаанхаан, Захарын нуруу зэрэг Бага Хэнтийн уулсын өвөр хэсэг сав газрыг хаадын ан гөрөөний нутаг байсан гэж үзэхээр сурвалж мэдээнүүд энэ мэтээр тааралдана” гэж Лу. “Алтан товч” болон зарим сурвалжийг эшлэн заажээ. Нөгөөтээгүүр *жубур* дэвсгэр нэрийг өөр өөрөөр тайлж түүнээсээ улбаалан *жубур*-ыг “уулархаг тал”, “гол” үзсэн нь ч таарч байна. Үүнд: ӨМӨЗО-ны судлаач Мешиг (2004, 41-р тал)-д: “Тоорил хан бас эндээс ухран гарч Бурхан халдуны араар *Үхэрт жубурыг* дайран Гачуурт субчид Улиат субчид авалагаад Туулын Хар түнд буцав. *Үхэрт* хэмээх газар бол Хэнтий нурууны Тэрэлж уулын баруун хойдох *уулархаг тал* болно. Элдэв зүйлийн араатан амьтан арвин байдаг уулын хөндийгөөр Хэнтий нурууны Тэрэлж уулаас эх авсан түргэн урсгалтай Заан гол хоржигнон урсаж Тэрэлж уулын хөндийгөөр Туул голд цутгана” гэж заажээ. Эл тодорхойлолттой аль нэг байдлаар төстэй саналыг манай газарзүйч О. Сүхбаатар тэмдэглэжээ. Тэр бээр (2017, 95-р тал)-д өгүүлэхдээ: “Энэхүү *Өхөртү шугуй* нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Асралт Хайрханы өврөөс эх авч 30 орчим км урсаад Тэрэлж голд нийлдэг Зааны гол мөн бололтой. Урианхай аялгуунд бугыг *заан* гэдэг байв. Монголчууд бугыг бас *уулын үхэр* гэдэг байжээ. Буга, бор гөрөөс, зэрлэг гахай, хандгай элбэгтэй байв.” гэжээ. Тэгвэл дээрх судлаачдын үзэл бодлоос огт өөр санал ч гарчээ. Тухайлбал Д. Базаргүр, Д. Энхбаяр нар (1990) газрын зурагтаа *Өхөртү жубур*-ыг өнөөгийн Зүүн Хараагаас зүүн тийш, баримжаалбал Таринын гол хавьд тэмдэглэжээ. Эл нутаг нь МНТ-эхэд Ван хан

Туулын Хар түнд, гэртээ морилон ирсэн газрын баримжаагаар тооцон үзвэл арай баруун, баруун хойшоо арай хол зайтай байна.<sup>2</sup>

### Хээрийн судалгааны дүнд дэвшүүлж буй санал

Энэхүү түүхэн газар нутгийн байршлын тухай анхны саналыг 1958 онд Х.Пэрлээ гаргасан юм. Тэрээр “(Х)ОКОРТУ ЖУБУР. 115 §. Бага Хэнтий уул, Гачуурын ам хоёрын хооронд 113 дугаар уртраг, 50 дугаар өргөргийн хавьд байсан бололтой.” хэмээн тойм баримжааг зөв тогтоосон юм. Түүний саналыг Игор де Рахвилтз, Элдэндэй, Ардаажав, Ш. Шагдар, С.Дамдинсүрэн тэргүүтэй эрдэмтэд ерөнхийдөө дэмжиж байжээ. Гэвч энэ бол өргөн цар хүрээг багтаасан хэт ерөнхий санал гэж шүүмжлэлтэй хандсан нь ч байна. Нэрт эрдэмтэн Игор де Рахвилтз энэ тухайд Тоорил хан Туул дахь өргөөрүүгээ буцахдаа Бурхан Халдуны арын Хөхөртний хөндий (Их хэнтий нуруунд байдаг энэ хөндий одоо хүртэл тодорхой болоогүй), Гацуурт сүвчид, Улиат сүвчид дайран явсан” хэмээн тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл Игор де Рахвилтз энэ газар одоо хүртэл тодорхой болоогүйг тэмдэглэхийн зэрэгцээ Бурхан халдуны ард Хэнтий ууланд байдаг гэсэн санаа гаргажээ. Гэвч энд сурвалжийн мэдээнд буй “gegü” хэмээх үгийн тухай асууудал яригдах болно. Энэ үгийг “north ард, хойд” гэж утгачилах нь үнэхээр оновчтой юу гэдэг асуудал гарч ирнэ. Энэ үгийг буруу утгачилбал, Хөхөртү жибурын тухай буруу баримжаа өгөх билээ. Г. Бадамсамбуу (2014, 138-р тал)-д энэ тухай өгүүлэхдээ: “*Үхэрт хөндий* Ван хан өнөөгийн Чингисийн хүр уулаас (Хуба-хаягаас) нэг их холгүй ан хийгээд Туулыг уруудан харьжээ. Дээр дурдан буй *Өхөртү жубур* Туул-Тэрэлжийн бэлчрээс (Хуб-хаяад ойр) үргэлжлэх төгөл шугуй бүхий хөндийн аль нэгтэй байгаа нь тодорхой байна. Гурван Баян, Жалман, Тэрэлж, Будлан, Дулаанхаан, Захарын нуруу зэрэг Бага Хэнтийн уулсын өвөр хэсэг сав газрыг хаадын ан гөрөөний нутаг байсан гэж үзэхээр сурвалж мэдээнүүд энэ мэтээр тааралдана” гэсэн санал гаргасан боловч мөн л тухайн газар зүйн биетийг хайхдаа ан авын нутаг, гөрөөний нутаг гэсэн шалгуураар хайсан нь мөн эргэлзээтэй байна.

Д. Базаргүр, Д. Энхбаяр нар (1990) газрын зурагтаа *Өхөртү жубур*-ыг өнөөгийн Зүүн Хараагаас зүүн тийш, баримжаалбал Тарнын гол хавьд тэмдэглэжээ. Гэхдээ энэ саналыг Э.Равдан “Ван хан Туулын Хар түнд, гэртээ морилон ирсэн


---

<sup>2</sup> Равдан Э. Монголын нууц товчооны газар усны нэрийн судалгаа.....УБ., 2020.

газрын баримжаагаар тооцон үзвэл арай баруун, баруун хойшоо арай хол зайтай байна.”<sup>3</sup> хэмээн шүүмжилжээ.

О. Сүхбаатар “Энэхүү Өхөртү шугуй нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Асралт Хайрханы өврөөс эх авч 30 орчим км урсаад Тэрэлж голд нийлдэг Зааны гол мөн бололтой. Урианхай аялгуунд бугыг *заан* гэдэг байв. Монголчууд бугыг бас *уулын үхэр* гэдэг байжээ. Буга, бор гөрөөс, зэрлэг гахай, хандгай элбэгтэй байв.” гэсэн санал гаргасан нь үндэслэл сонирхолтой боловч тус үндэслэлээсээ илүүтэй газар зүйн ажиглалтын тухайд дэмжиж болох санал юм. Гэхдээ бид арай өөр саналтай байна.

Бидний үзэхээр энэ газар зүйн биетийн байршлыг тодорхойлдог чухал баримжаа бол Монголын нууц товчооны *burqan-qaldun-nu gerü-ber* гэсэн мэдээ юм. Энд дурдагдан буй *gerü* хэмээх үгийг ихэнхи эрдэмтэд ар, хойд гэж ойлгосон бололтой. Тухайлбал, Игор де Рахвилтз умард, хойд (north) хэмээн орчуулсан байдаг. Д.Цэрэнсодном “Бурхан Халдуны араар Өхөртү Жубур дайран, Гацуурт сүбчид, Улиа[с]тай сүбчид дайран” гэхчлэн утга оноожээ.

Энэхүү *gerü* хэмээх үг Монголын нууц товчоонд *düyiren gerü*, *qaldun-nu gerü jeje'er-ündür-ün gerü*, *mau-ündür-ün gerü* гэх зэрэг уулын нэртэй холбоотой дурдагддаг. Энэ үгийг Монголын нууц товчоон дахь газар нутгийн дэвсгэр нэрийн судалгаа хийсэн эрдэмтэн Догсүрэн “Уулын ар биед хүй хүйгээр ургасан ягц модыг монголчууд одоо ‘хэрүү’ /18/ хэмээн нэрлэдэг нь эртнээс уламжлан ирсэн нэрийн нэг байна. Монгол бичгээр  (kegeu) хэмээн бичиж буй.” гэсэн тайлбар хийсэн байна. Гэхдээ Монголын нууц товчооныг сэргээсэн Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном, Ш.Чоймаа тэргүүтэй эрдэмтэд “ар, хойд” гэх утга оноохын зэрэгцээ “хяр” хэмээн хөрвүүлсэн нь ихээхэн оновчтой байна. Хяр гэдэг бол “Өндөрлөг уулс, нуруудын дээд ирмэг, хянга: хяр дамжих...” гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл Монголын нууц товчооны “*burqan- qaldun-nu gerü-ber hökörtü-jubur da'arin qaca'uratu-subcit huliyatu-subcit da'arin görü'en inu abala'at tu'ula-yin qara tün-ni jorin icuba*” гэсэн мэдээ “Бурхан халдуны хярыг дамжин явж, Хөхөртү жибуур дайран Гацуурт сүвчид, Улиат сүвчид дайран гөрөөн авлаад Туулын хар түнийг зорин буцав” гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл тус мэдээнд Ван ханы явсан замыг маш ойлгомжтойгоор тоочин бичсэн байна. Бурхан халдууны хярыг дамжин явсан бөгөөд тус өндөр нурууны хяраас буухдаа дагаж уруудсан хөндий нь Хөхөртү жибуур байж таарна. Үүнээс үзвэл

---

<sup>3</sup> Равдан Э. Монголын нууц товчооны газар усны нэрийн судалгаа.....УБ., 2020.

Хөхөртү жибур нь Хэнтий нуруунаас өмнөш буусан олон салбар гол, хөндийнүүдийн нэг болох билээ.

Бурхан халдун буюу Хэнтий хан уулын хяр зоо, Хэнтий нурууг давдаг гол даваа өнөө хэр Их даваа хэмээн нэрэлэдэг бөгөөд Тоорил, Тэмүжин, Жамуха гурав умраас Хэнтий нурууг давж буцаж ирэхдээ тус даваагаар давсан нь маргаангүй юм. Энэ даваанаас баруун тийш Туулыг зорин одохдоо Тоорил хан Хэнтий нурууны хяр зоог дамжин явсан байна. Ийнхүү явахад гол ус, гардаггүй, шавар намарт саатдаггүй хамгийн дөт зам болдог ажээ. Өнөөгийн ан гөрөөчид ба байгаль хамгаалагчид ч энэ нуруу зоог дамжин явах боломжтойг батлан өгүүлж байна.

Газрын зургаас үзэхэд Их даваанаас эхлэн Хэнтий нурууны хяр зоог дамжин явахад Гацуурт, Улиастайн хөндийрүү маш ойртон ирээд барууш хойш Асралт хайрханы зүг даялан оддог ажээ.



*Их даваанаас баруун үргэлжлэх Хэнтий нурууны хяр. Энэ хярын зургаас харахад Гацуурт, Улиастайн амруу хамгийн их ойртон ирж буй хэсэг нь Горих-Тэрэлжийн хойд уулын хяр ажээ.*

Энэхүү Гацуур, Улайстайн сүврүү хамгийн их ойртож ирсэн хэсгээс урагш буусан хэдэн амны нэг нь Хөхөрт жибур болох билээ. Газрын зургаас үзэхэд энэ хэсгийн Хэнтий нурууны өндөр хяраас буусан хамгийн боломжтой гол бүхий хөндий нь Хөлөрийн голын хөндий байгаа юм. Өөрөөр хэлбэл Хөлөрийн голын хөндий

Монголын нууц товчоон дахь Хөхөрт жибур буюу Хөхөрт хөндий байх магадлалтай байна.

Энэхүү Хөлөр (Хүлэр)-ийн голын эх нь Хэнтий нурууны тагаас буухад нэлээд тохиромжтой даваанаас эх авдаг бөгөөд Хүлэрийн голын хөндий нь нэлээд уужуу сайхан хөндий ажээ. Мөн Туул голын хөндийрүү ороход хамгийн ойр дөт зам болно.



#### *Хөлөрийн голын эх*

Монголын нууц товчооны уг эх Гацуурт сүвчид ба Улиат сүбчид дайран Туулын Хар түнд ирсэн тухай тодорхой тэмдэглэсэн нь Ван ханыг Туул голын хөндийг дагаж орж ирснийг шууд баталдаг. Хэнтий ханы нуруунаас буюу Бурхан Халдуны хяраас Туулын хөндийрүү буух хамгийн боломжтой үзүүр бол энэхүү Хөлөрийн гол юм. Энэ хөндийг уруудалгүй хяраа даган явбал Туул голоос баруун хойш улам алсран холдох юм.

Энэ бүхнийг нэгтгэн үзвэл Тоорил хан умардаас ирэхдээ Хэнтий нурууг Их даваагаар давсан бөгөөд Их даваанаасаа шууд Хэнтий нурууныхаа хярыг дагаж, баруун зүг Горхи Тэрэлжийн уулсыг хүртэл аялаад тэндээсээ Хэнтий нурууны хяраас Туул голын хөндийрүү буусан байна. Ингэхдээ Хөлөрийн голыг дагаж буусан болов уу гэсэн таамаг төрж байна. Монголын нууц товчоонд Бурхан халдуны хяраар явж, Хөхөртийн хөндийгөөр доошоо буугаад Гацуур, Улиатын амаар дайран туулаа ураадан ирсэн хэмээн Ван хан Тоорилын ирсэн замыг шууд тасралтгүй байдлаар тодорхой тэмэглэсэн байна.

## ИХ ХОРИГ

Бидний энэ удаагийн судалгааны зориг хэдийгээр Их хоригтой шууд холбоогүй боловч тус хээрийн судалгааны явцад Монголын түүхийн хамгийн чухал түүхэн газар орон болох Их хоригийн хил хязгаарын судалгаанд өөрсдийн нэгэн саналаа нэмэрлэж болохуйц мэдээлэл цуглуулсан юм.

Монголын түүхийн сурвалж бичгүүдэд олонтаа дурдагдсан “Их хориг”-ийг олж тогтоох, түүний нутгийн хил хязгаарыг тодорхойлох судалгааг манай ахмад эрдэмтэд хийсээр ирсэн. Чингис хааны “Их хориг”-ийн тухай үндсэн мэдээллийг Судрын чуулган өгдөг билээ. Тус сурвалжид өгүүлснээр *غُرُوقِ بزرگ* *γorûq buzurg* буюу “Их хориг” хоёр байжээ. Үүний нэг нь Бурхан халдунд байгуулсан “Их хориг” бол нөгөө нь Сэлэнгэ мөрний ойролцоох Бүрэ(н)-Өндөр хэмээх ууланд байгуулсан “Их хориг” юм.

Бурхан Х.Пэрлээ “Их хориг хаана байна” өгүүлэлдээ хятад элчингүүдийн тэмдэглэл, Рашид-ад Дины “Судрын чуулган” дахь мэдээ сэлтийг сайтар харьцуулан нягтлаад Пэн Да-я, Хэй-Да Ши-лю, Сюй Тин зэрэг хятад элчингүүдийн тэмдэглэл Чингис хааныг тэнгэрт гарснаас 7-8 жилийн дараа бичигдсэн итгэж болохуйц мэдээ болохыг тодотгоод Болд чинсан мэтийн тэр үеийн төрийн хэргийг сайн мэдэх хүний мэдээг эрхэмлэн үзэх хэрэгтэйг тэмдэглэжээ. Тэрээр өнөөгийн Хэнтий хан уул “Их хориг”-ийг байгуулсан эртний Бурхан Халдун уул мөн болохыг олон талаас нь батлахын зэрэгцээ тус хоригийн зарим газар нутгийг тодруулан өгүүлсэн байдаг. Үүнд:

*“Хэрлэн гол уруу солгой талаас орж ирсэн олон ам (амсар)-ыг судалж үзэхэд (аман уламжлалаар) Солооч, Ар Бунхан гэдэг хоёр газарт Хамниган хойлголсон газар (үхэгсдийг оршуулсан газар) гэж ярьдаг байсан байна. Эдгээрээс гадна дээрх хоёр газрын зэргэмжээ Гурван хоригууд (Хойт хоригууд, Дунд хоригууд, урд буюу Мухар хоригууд) гэдэг газрууд мөн Хэрлэний зүүн гараас орж ирсэн байна. Хоригууд гэсэн нэрийг шинжлэхэд Хориг+ууд гэсэн хоёр хэсгээр бүтсэн үг байж болох юм. Гурван хоригууд газар зүйн талаар ч Бурхан Халдун ууланд ойр шадар байна. Энэ гурван газрын нэр Болд чансан, Рашид-ад Дин нарын бичсэн Бурхан Халдунд байсан Их хориг нь хожим үед газрын нэр болон үлдэж манай үед уламжилсан болохоос зайлахгүй боллоо. Нутгийн хүнээс лавлан асуухад хуучин цагт Солооч-д үхэгсдийг ил энгэрлүүлж*



*байсан байх ба Хойт хоригуудын Билчээрийн өвөр; Дунд хоригуудын: Хат, Бөөгийн Хонхор, Баян-Өндрийн Ширэнгэ, Булагтын Солоом, Цагаан хөндий, Овоотын өвөр, Цагаан чулууны хонхор. Энэ хоёр (хойт, дунд) хоригуудын уулзвар Үүд модны (зарим хур бороо элбэг, зам муутай, жилд Хэнтий ханыг энэ Үүд модноос тахьдаг байжээ. Ургаа хоёр модны хооронд эсгий үүд мэтийг унжуулан татаж тахилгаа түүний хойд талд хийж байснаас энэ Үүд мод гэдэг нэр үүсчээ.) зүүн хойно байгаа Ана гэдэг газар, Мухар хоригуудын: Төмст толгой, хоёр Гозорын хооронд зэрэг газруудад хожуу үед хүн тавьдаг байсан байна. Дээр дурьдсан хоригуудыг хэл бичгийн талаар үзэхэд Хориг гэсэн үгээс гаралтай ба хожуу үед үхэгсдийг ил гээж энгэрлүүлэх газрууд болж байсан нь энэ газруудыг эртний Их хоригийн нэг хэсэг нь мөн гэж үзэх гэрч баримт болж байна.”<sup>4</sup> гэжээ.*

Ийнхүү Х.Пэрлээ Босго Тэнгэрийн даваанаас урагш байрлах Солооч, Арбунхант, Гуван хориуд тэргүүтэй хэсэг газар орныг эртний Их хоригийн нэг хэсэгт тооцсон байна.

Х.Пэрлээ гуайн дараа энэ чиглэлийн судалгааг хийсэн хүн бол угсаатны зүйч С.Бадамхатан юм. Тэрээр Хэнтий хан орчмын нутагт хийсэн олон жилийн судалгааны дүнд Их хориг байгуулсан Бурхан Халдун уул өнөөгийн Хэнтий хан уул мөн болохыг лавшруулан батлахын зэрэгцээ, Их өтөг, Ихэсийн газар нь “Их хориг” мөн гээд “Их хориг”-ийн хилийн дээсийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

*“Чингис хаан Их Хоригийн нутгийн дээсийг тогтоохдоо урьд өвгөдийн хүүр оршуулдаг байсан Ихсийн газрын нутгийг хойноос урагш баруунаас зүүнш үлэмж тэлэн томсгосон бололтой. Хойт тал нь Онон голын эх Бэрийн янгаас зүүн тийш Будан цагаан өвөр (Хэрлэнгийн эх) Ононгийн эхээс (Ононгийн халуун рашаан) урагш Илүүрийн голыг уруудан Дэлгэрхаан, урьд Дэлүүний нуруу, Эрдэнэ уул, Эсгийч уул хүртэл, Ононгийн дунд бие зүүн Тарсын рашаанаас урагш Ноён, хатан, Хүү, Будлан хан уулын наагуур Тарвагатайн дэрсгээр, Хэрлэн дагуу Элэгцэг, Босго, Хонин өндөр, Гурван сайханы үзүүр гурван Хориудын*

---

<sup>4</sup> Пэрлээ Х. Их хориг хаана вэ? // Х.Пэрлээ. Бүтээлийн чуулган. III. УБ., 2012. т.325-326

(дээд, дунд, доод гурван ам) доод үзүүр Эсгийч уулын харалдаагаар урд хилийн дэс тогтоогдсон байна.<sup>5</sup>

Энд чухам Бурхан халдун уулыг тойрсон ам сүв, өндөр уулыг оруулан бүсчлэсэн байгаа боловч, байгаль газар зүйн хүчин зүйл, Хойд хориуд, Дунд хориуд, Урд хориудын амны байрлал зэргийг тодорхой харгалзан үзээгүй бололтой. Тиймээс бид өөрсдийн хээрийн судалгааны хүрээнд хийсэн ажиглалтад тулгуурлан илүү тодорхой санал гаргахыг зорилоо.

Бурхан халдун хайрхан уул бол Хэнтий нурууны их оргил бөгөөд Хэнтий хан нэрээр өнөөг хүртэл тахигдаж ирсэн шүтээн уул билээ. Монголын түүхийн сурвалжуудад тодорхой тэмдэглэснээр Бурхан Халдун хайрхан ууланд их хаадыг онголж дархан бүс байгуулсан нь “Их хориг” нэртэй байжээ. Рашид-ад Дины Судрын чуулганы дараах мэдээ Бурхан Халдун ууланд “Их хориг”-ийг байгуулсны шууд нотолгоо болдог.

و بعد از آن .لیکن در عهد چینگگیز خان امیری از امرای هزار دست چپ اوداچی نام از آن قوم بود که در موضع بُورْقَان قالدون او را معین کردانیده اند تا با هزاره خود غُرُوقِ بزرگ چینگگیز خان، و ثُلُوی خان و اُورُوغ او و قُوبیلای قان و مُنگکه .است نگاه می دارند و هرگز به کزیگ نمی روند چینگگیز خان را غُرُوق در و دیگر اُورُوغ .ایشان جمله در آن غُرُوق مدفون اند قان و اُورُوغ موضع دیگر است .*Харин Чингис хааны үед зүүн гарын мянгатын ноёдын захирагч Үдэчи нэртэй ноён энэ аймгийнх байв. Тэгээд дараа нь түүнийг өөрийнх нь мянгантай хамт Бурхан халдунд байдаг Чингис хааны Их хоригт ( غوروق بزرگ bizurg) байж хамгаалахаар томилж, хишигт ( کزیگ kezig) хэзээ ч явахгүйгээр болгов. Толуй хан болон түүний ураг, Хубилай хаан ба Мөнх хаан, тэдний ургуудыг бүгдийг нь тэр хоригт онголсон. Чингис хааны бусад ургуудыг өөр хоригт оршуулсан байдаг.*<sup>6</sup>

Энэ хоригийн байршлыг тухайн цаг үетэй нь хамгийн ойрхон Сүн улсын элчин Пэн Да-я ба Сюй Тиний нар “Тэд хүн оршуулахдаа онгон булш босгодоггүй, харин хүн оршуулсан газраа адуугаар гишгүүлж, газраа тэгшилдэг юм. Тэмүүжиний онгон булшийг тойруулан сум шорог хатгаж хүрээ болгоод өргөн уудмаараа 30 газар хэртэй, морьт харуул манааны хамгаалттай юм. Сюй Тин, би Тэмүүжиний шарилыг

<sup>5</sup> Бадамхатан С. Чингис хаан: Би энд нойрсоно. УБ., 1997. т.10

<sup>6</sup> Reşîdüddîn Fazlullâh Hemedanî. *Câmi'ut-tevârîh*, Tashih Muhammed Rûşen ve Mustafa Mûsevî. C.I, Enteşerat-i Elborz, Tahran. 1373. s. 109

Онон голын хөвөөнд уул усаар хүрээлэгдсэн газарт байхыг олж үзэв. Уламжлал яриагаар бол Тэмүүжин энд мэндэлсэн тул нас нөгчсөний хойно мөн энд оршуулав гэнэ. Үнэн худлыг мэдэхгүй”<sup>7</sup> гэжээ. Энэ мэтчилэн түүхэн сурвалжууд Бурхан Халдун ууланд Чингис хаан ба түүний ургуудыг онголсон “Их хориг” байгуулсан тухай нэгэн дуугаар батладаг. Бурхан халдунд ууланд байгуулсан “Их хориг”-ийн байршлын ерөнхий байрлал баттай тогтоогдсон боловч, чухам Их хоригийн хилийн дээсийг тодорхойлох судалгаа шаардлагатай байна. Бид Бурхан халдун уулын орчны бүсэд морин хайгуул судалгаа хийж, газар зүйн ажиглалт судалгаа хийсний дүнд нэгэн зүйлийг тодорхой болгов.


Бурхан халдун уул нь Хэнтий нурууны төв хэсэгт Онон, Туул хоёр голын эхнээс зайтай боловч чухам Хэрлэн голын эхэд ойр байдаг. Тус уулын баруунаар урсах Илүүрийн гол, зүүнтэйгүүр урсах Богдын гол хоёул Хэрлэн голын эхний цутгалангууд юм. Газар дээр нь ажиглалт хийж, газрын зургаас баталгаажуулан харахад Бурхан халдун уулыг тойрон хүрээлсэн битүү зоо байгаа нь бидний сонирхолыг татаж байна. Өөрөөр хэлбэл Их даваанаас зүүн тийш, Түшлэг-Өндөр, Буурал ахын ян, Идрэнгийн даваа, Буян-Ундрахын ян, Дунд Хориудын урд нуруугаар дамжин хүрээлсэн нэг үргэлж зоо, Их даваанаас баруун тийш Сандлинтай, Даваат, Эмт, Эрдэнэ уул, Сүүл-Өндөр хэмээн үргэлжлэх нэгэн үргэлж зоо байгаа бөгөөд хоёул Гурван хориудын тэнд, Хэрлэнгийн Цагаан арлын орчимд хоёр талаасаа уулздаг. Энэхүү битүү хүрээлсэн өндөр зоо нуруу нь эрт цагт Хориг байгуулан, харуул суулгаж хамгаалалт байгуулсан Гурван хориудын орчимд нийлж байгаа нь магадгүй “Их хориг”-ийн хилийн дээс тус Бурхан халдун уулыг хүрээлэн тогтсон үргэлжилсэн урт зоогоор тогтож байсан болов уу хэмээн таамаглахад хүргэж байна. Хэрлэнгийн Цагаан арлын баруунаас бууж ирэх зоо нурууны нэр өдгөө хүртэл Сүүл-Өндөр нэртэй байгаа нь мөн сонирхолтой. Магадгүй энэ нэр Бурхан Халдуныг тойрсон битүү зоо нурууны сүүлийн өндөр цэг мөн гэдгийг батлах нэгэн баримт болов уу. Газар дээр нь ажиглалт хийж, газрын зургаас баталгаажуулан харахад Бурхан халдун уулыг тойрон хүрээлсэн битүү зоо байгаа нь маш тодорхой байна.

Энэ битүү зооны дотроос эх авч буй Илүүрийн гол, Богдын гол, Бага ахын гол, Дунд ахын гол, Их ахын гол, Баруун салаа гол, Зүүн салаа гол, Хэрээ гурван толгойгоос эх аван урсах Хэрлэн голд нийлэх бөгөөд бүгд нийлж Хэрлэн мөрний

---

<sup>7</sup> Их Монгол улсын түүхэнд холбогдох хоёр сурвалж бичиг. Монгол татарын бүрэн тэмдэглэл. Орчуулсан Ж.Баясах. УБ., 2006. т. 282

эхийг бүрдүүлээд Сүүл-Өндөр ба Хориудын дундуур тус битүү зоог сэтлэн өмнө зүгт урсан гардаг ажээ.



© П.Хатансайхан

*Бурхан халдуныг хүрээлсэн энэхүү битүү зоо нь эртний*

*Их хоригийн хилийн дээс байх магадлалтай*

Энэ битүү зооны уулзвар хэсгийн зүүнтэй Хойд хориуд, Дунд хориуд, Урд Хориуд хэмээх газар, баруунтай Сүүл-Өндөр гэсэн том уул байгаа нь Их хоригийг байгуулахдаа тус үргэлжилсэн зоо нуруугаар хил хязгаараа тогтоож, задгай ам хэсэгт нь хамгаалалтын хоригуудыг байгуулсан гэсэн таамаглалыг төрүүлж байна. Хожмын түүхэн сурвалжуудад чухал энэ битүү зоо хярыг дүрслэсэн мэдээ сэлт мөн тааралддаг. Тухайлбал, Б.Инжиннашийн бичсэн “Хөх судар”-т өгүүлэхдээ:

*Өгэлүн эх, их л зөвшөөгөөд өгүүлрүүн: “Чиний өвгийн үед Бурхан Галдунын (Энэ бурхан хэмээгч ном бурханы бурхан бус, ар газрын ууланд түлээ модтой нь маш цөөн бөгөөтөл энэ Галдунын ууланд нарс, майлаас бурдуйж барайтал ургасан тул Бүр хан Галдуна хэмээн нэрийджүхүй.) өвөрт уулаар хот хийж, бэрх амыг батлан сахиж нутаглажухуй. Эдүгээ самуунаас зайлж, тэнд нүүн эчиж, хэдэн жил тамир хүчийг тэжээж, цэрэг иргэнээ боловсруулбаас зохимуй” хэмээсэнд Тайцзу эхийн зарлиг ба Мохулийн дуртгалыг авч, даруй Бурхан Галдунд нүүж ирээд, Бурхан Галдуны өврийн Арслангийн аманд хорин газрын дэвсэгт нутаглаж, балга хорооны улс албат цөм нүүн ирээд, Бурхан Галдуны сүв ам бэрх хавцлыг бэхлэн сахиж, ус өвс бас сайн тул, Бэт улс их л тэнхжин, Тайцзу-гийн сүр хүч, аугаа алдар улам*






*kyra : Bši : üčbirküda : TTR : birla : Qti : TWQiDM : šinRi : BWDN : ičkdi* : гэж уншжээ<sup>17</sup>. Энэ мэдээ бидэнд тус газар зүйн биетийн байршлын тухай тойм баримжааг өгдөг. Татар болон түрэг аймгуудын нутгийн зааг орчим болох нь ойлгогдоно. Б.Батсүрэнгийн “Туулын сав нутаг ялангуяа одоогийн Улаанбаатар хотоос дээших газар нь VI зууны II хагасаас – VIII зууны II хагас хүртэлх хугацаанд *түрэг, монгол* хэлтэн аймгуудыг заагладаг, завсрын уулзвар бүс (контактный зон) байсныг үгүйсгэх аргагүй.”<sup>18</sup> гэсэн саналыг харгалзан үзвэл бидний сонирхон буй Хэйр ба Гурванбиркү нь Хэрлэнгийн баруун эргээс Туул голын эхэн хавийн нутагт байх ёстой юм. Тиймээс энэ бүс нутагт буй газар нутгаас эдгээр газар зүйн биетүүдийг хайх нь зүйтэй. Энэ бүс нутагт *k'ure*-Хэйрэ нэртэй газар зүйн биетэд таацах магадлалтай хоёр газар байгаа нь Хэрлэн ба Хээр (Сайр хээр) юм. Мөнхүү *üč birkü* буюу Гурван биркү нь өнөөгийн Төв аймгийн Мөнгөн морьт сумын нутаг, Хэрлэн голын баруунаас нийлэх Баруун Бүрхийн гол, Дунд Бүрхийн гол, Зүүн Бүрхийн гол хэмээх Гурван Бүрхи мөн гэж үзэж байна. Энэхүү гурван Бүрхийн голын нэр нь Орхоны бичгийн дурсгалд *üč birkü* хэмээн гардаг эртний нэр ажээ. Үүний бас нэгэн баталгаа нь эрт үед зүүн зүгийг өмнө, умардыг зүүн, өмнөдийг баруун гэж нэрлэж байсны улбаа тус гурван голын нэрээс тодорхой ажиглагддаг. Хэрэв XIII зуунаас хойших нэр байсан бол Хэрэнгийн зүүн эрэг дэх Урд хориуд, Хойд хориудын нэгэн адил Урд бүрхийн гол, Дунд бүрхийн гол, Хойд бүрхийн гол гэж нэрлэгдэх байсан билээ. Тиймээс Б.Батсүрэнгийн Шинэ усны бичээст гарч буй *üčbirkü* бол Монголын нууц товчооны *bürgi-ergi* мөн гэсэн санал: Бүрги эргийг Бүрхийн голд зааснаараа дэмжүүштэй боловч Гурван бүрхи нь Бүрги эрги мөн гэж шууд хүлээн зөвшөөрөхөд учир дутагдалтай юм. Тодорхой хэлбэл, Түрэгийн үед *üčbirkü* (Гурван бүрхи) нэртэй байгаад дундад зууны үед Бүрги эрги нэртэй болоод хожим дахин Гурван бүрхи нэртэй болсон байж таарахгүй. Өөрөөр хэлбэл *üčbirkü* бол Гурван бүрх мөн боловч Бүрги эрэг нь тус голуудын савд орших өөр нэг жижиг газар зүйн биет гэдэг нь ойлгомжтой юм.

*k'ure* хэмээх газар зүйн биетийн хувьд С.Харжаубай ‘Хэйрэ’ (Käyṙä)-г одоогийн Хэрлэн гол” гэсэн санал дэмжүүштэй байна. Учир нь тус үгтэй хамтатган хэрэглэсэн *başı* “тэргүүн, эхэн” хэмээх үгийг Орхоны бичгийн дурсгалуудад *Arqar başı, Şip başı, Çuş başı, Tsiz başı* гэх мэтээр ихэнхидээ голын нэртэй хамт “тэргүүн,

<sup>17</sup> Болд Л. *Орхон бичгийн дурсгал VI*. УБ., 2019. т.166

<sup>18</sup> Б.Батсүрэн. *VI-X Зууны Монгол Аймгууд* (Түүх – угсаа гарвалын шинжилгээ). Түүхийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилох бүтээл. УБ., 2012. т.78

эхэн, дээд урсгал” гэсэн утгаар хэрэглэсэн байдаг. Тийм учраас тус *keure başı* гэдэг газар зүйн биетийн *keure* нэр гол усны нэр болох нь илэрхий ойлгогдож байна. Түүнчлэн авилаа жижиг газарзүйн биетийн байршлийг тодорхойлохдоо ойролцоох томоохон уул, усаар баримжаа болгодог билээ. Хэрэв *üç birkü* буюу өнөөгийн Гурван Бүрхийн гол мөн л бол түүнийг байршлыг тодорхойлохдоо Хэрлэн голоор баримжаа болгох нь гарцаагүй юм.




Зураг №1

Шинэ усны бичээсийн 6-р мөрөнд *keure başında üç birküde*, 7-р мөрөнд *keure başı üç birküde* хэмээн гарч буйг “Хэрлэнгийн эх, Гурван бүрхэд” гэсэн утгатай гэж үзвэл бидэнд Монголын нууц товчоонд дурдагддаг хэд хэдэн газар зүйн биетийн байршлийн тухай мэдээлэл өгч байна.

Нэгдүгээрт, *kelüren-müren-ü teri'ün* гэх ойлголт тодорхой болж байна. Энэ мэдээ ёсоор бол Хэрлэн мөрний тэргүүн, эхэн урсгалын тухайд Гурван бүрхийн голын адаг буюу Хэрлэн гол ба Баруун Бүрхийн голын бэлчир хүртэлх хэсгийг хамруулах тодорхой харагдаж байна. Судалгааны явцад ажиглахад Баруун Бүрхийн гол, Хэрлэн голын бэлчир орчмын нутаг, өнөөгийн Намсрай уул, Хөндлөн булаг, Номгоны эрүү толгой орчмоор Хэрлэн голын том хөндий ерөнхийдөө хоёр хуваагдаж байгаа нь сансрын зургаас тодорхой харагдаж байна. Үүгээр Хэрлэнгийн эхэн урсгал төгсгөл болж байх шиг байна. (Зураг. №2) Намсрай уулын зүүнтэйгүүр Баруун бүрхийн гол нийлснээс эхлэн Хэрлэн гол задгайран маш олон салаалж, өргөн хуурай сайрыг үүсгэсэн байдаг.





(Зураг №2).

Ийнхүү “Хэрлэн мөрний тэргүүн” хэмээх газар зүйн ойлголтыг тодорхой болгосноор Чингис хааны зарлигаар *qurban müred-ün teri'ün ken-e ber bu bawülutqun* хэмээн дархалсан нутгийн өмнөд зах хязгаарыг тоймлох боломжтой болж байна. Онон, Туулын тэргүүнийг Хэрлэн мөрний тэргүүнтэй дүйлгэн ойролцоогоор тогтоож болох болов уу.

Хоёрдугаарт, Хэрлэн мөрний тэргүүнээр баримжаа болгосон Бүрги эрги гэх газрын байршлын талаар ерөнхий мэдээлэл өгч байна. Монголын нууц товчоонд Бүрги эрги гэх нэр нэр нийт 6 удаа гардаг.

*senggür-qoroqan-aca newüjü kelüren-müren-ü teri'ün bürgi-ergi-de nuntuqlan bawuju*<sup>19</sup> “Сэнгүр гохиноос нүүж, Хэрлэн мөрний тэргүүн Бүрги эргид нутаглан бууж”;

*tendece qariju bürgi-ergi-de бүкүй-түр бурqан-qaldun-aca uriangqadai gü'ün jarc'i'udai ebügen kü'ürge-ben ürcü jelme neretü kö'ün-iyen удуритцу иреjү*<sup>20</sup> “тэндээс

<sup>19</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.37

<sup>20</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.37

харьж Бүрги эргид бүхүйд Бурхан Халдунаас урианхадай хүмүүн, жарчиудай өвгөн хөөргөө үүрч, зэлмэ нэрт хөвүүнээ удирдаж ирж”;

*kelüren-müren-nü teri'ün-e bürgi-ergi-de bawuju бүкүй-түр никен manaqar erde gerel siral үдүр geyin бүкүй-түр hö'elün-eke-yin ger dotora gödölküi qo'a[q]cin-emegen boscu ügülerün*<sup>21</sup> “Хэрлэн мөний тэргүүн Бүрги эргид бууж бүхүйд нэгэн маргааш эрт гэрэл шарал өдөр гийн бүхүйд Өгэлүн эхийн гэр дотор хөдлөх Хоагчин эмгэн босч өгүүлрүүн”;

*to'oril- qan morilarun burqan-qaldun-u ebür kelüren-ü bürgi-ergi jorin ayisi ke'en temüjin bürgi-ergi-de бүрүн mör-tür bui ke'en jayilan tünggelik ö'ede newüjü tana-qorqon-a burqan-qaldun-u ebür bawuju ...*<sup>22</sup> “Тоорил хан морилруун Бурхан Халдуны өвөр Хэрлэнгийн Бүрги эрги зорин айсуу хэмээн Тэмүжин Бүрги эргид бүрэн мөрт буй хэмээн зайлан Түнггэлиг өөд нүүж Тана горхинд Бурхан Халдуны өвөр бааж...”;

*bi ö'esün kelüren-ü bürgi-ergi-dece*<sup>23</sup> *uqdu yorciju güse'ür-na'ur-a jolqalduba-je*<sup>24</sup> “би өөрөө Хэрлэнгийн Бүрги эргээс угтан зорчиж, Гүсээр нуурт золголдов зэ”;

Ийнхүү Хэрлэн мөрний түргүүн, Бурхан Халдуны өвөр, Түнггэлиг горхин, Тана горхин, Сэнгүр горхиноос холгүй орших Бүрги эрги нь өнөөгийн Хэрлэнд цутгах Баруун бүрхийн гол, Юүдэгийн голыг цутгалаас дээш, Намсрай уул, Номгоны эрүү толгойгоос өгсөөд байх ёстой ажээ.

Бүрэг эргийн тухай судлаачдын зөрүүтэй саналууд байдаг боловч дээр өгүүлсэн зүйлсэд үндэслэвэд Б.Батсүрэн (2010), V. Recchia RIBA (2010), Ж.Гэрэлбадрах (2019) нарын гаргасан саналууд нэлээд баримжаатай болсон гэж үзэж байна. Эдгээр гурван эрдэмтэн Бүрги эргийг Гурван Бүрхийн голын хөндийд зааснаараа нийтлэг боловч яг байршлын тухайд тус тусын ялгаатай саналууд гаргасан юм. Б.Батсүрэн Шинэ усны бичээст гарах Үчбиркү-г Бүрги эрэг гарцаагүй мөн<sup>25</sup> гэж үзсэн бол Бристолын их сургуулийн эрдэмтэн V. Recchia RIBA “Тэмүжиний

---

<sup>21</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.38

<sup>22</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.43

<sup>23</sup> Үүнийг Монголын нууц товчоонд “kelüren-ü teri'ün-ece cinggis-qahan ö'esün esergü otcu” хэмээн бичсэн буй.

<sup>24</sup> *Index to the Secret History of the Mongols*. By the I.de.Rachewiltz. Bloomington. 1972. p.88

<sup>25</sup> Батсүрэн Б. Уйгур ба Байырку, Есөн татар нар 747-751 онд // *JOURNAL OF EURASIAN STUDIES*. Volume II., Issue 2. April — June 2010. p. 70

хүрээ Бүргийн голын эрэг дэх Бүргийн далангийн зүүн үзүүрт байсан.”<sup>26</sup> гэж таамаглажээ. Харин Ж.Гэрэлбадарах “Зүүн Бүрхийн голын баруун эрэгт буй Бүрхийн дөрвөлжингийн ойр Тэмүжиний зусч байсан Бүрги эрэг байсан”<sup>27</sup> гэжээ. Бид мөн Монголын нууц товчоонд гардаг Бүрги эрэг нь өнөөгийн Гурван бүрхийн голын ойролцоо, Баруун бүрхийн голоос хойшоо Хэрлэнгийн эрэг дагуу байгаа гэдэг ерөнхий чигийг дэмжиж байна.

### **Угсаатны зүйн хээрийн судалгаа**

2020 оны 09 сарын 04-наас 17-ны өдрийг дуустал нийт 14 хоногийн хугацаанд Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Энхбаатар угсаатны зүйн хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тэгэхдээ Хэрлэнгийн эх орчмын тахилга шүтээнтэй газруудыг төлөөлүүлэн Төрийн тахилгат Бурхан Халдун хайрхны тахилга, түүнийг сэргээсэн байдал, социалист нийгмийн үед хүмүүс хэрхэн тахилга шүтээнтэй уул устай харилцаж байв гэдгийг аман түхээр сурвалжлан тодруулах ажлыг гүйцэтгэсэн.

Бие хүн өөрийн биеэр оролцсон, үзэж харсан түүхэн мэдлэгийг нийгэм-соёлын хүн судлалын ухаан болон түүхийн шинжлэх ухаанд “аман түүх” хэмээн тодорхойлдог. Түүхэн баримт, бичгийн сурвалжид тулгуурлан түүхэн харьцуулах аргаар дүгнэлт гаргахаас илүүтэй өөрийн өнгөрсөн амьдралд тохиолдож байсан үйл явдлыг тайлбарлах хувь хүний дурсамжийн шинж чанарыг аман түүх агуулж байдаг. Энэ утгаараа тухайлсан сэдвийн хүрээнд болсон үйл явдал, бүс нутгийн онцлог, ёс заншил зэргийг нийгэм соёлын хүрээнд тодруулах боломжийг олгодог билээ.

Юуны өмнө социалист нийгмийн үед шашин соёл, үндэсний зан заншлын талаар төр засгийн хүрээнд ямар бодлого шийдвэр гаргаж байсан, тэр нь ямархуу хэлбэрээр хэрэгжсэн, үүний өмнөх суурь дэвсгэр нь хаанаас эхэлсэн зэргийг цухас тодруулж үзэх шаардлагатай юм.

Хувьсгалын эхний жилүүдээс шашныг төрөөс тусгаарлаж, сүм хийд, том толгой лам нарын эдийн засгийн хүч нөлөөг устгах улс төр, эдийн засгийн арга хэмжээг тууштай хэрэгжүүлжээ. Лам нарыг дээд, дунд, доод хэмээн анги ялган

---

<sup>26</sup> V. Pecchia RIBA. *Geography of 'The Secret History Of The Mongols'* (Location of C13th Mongol Place Names and Topographical Features in NE Mongolia). In collaboration with the Dept. of Archaeology and Anthropology of Bristol University, Bristol, UK., 2010. p. 21

<sup>27</sup> Гэрэлбадрах Ж. “Монголын нууц товчоон”-д гардаг Бүрги эрэг чухам хаана байсан вэ? // *Acta Historica. Tomus. XX, УБ., 2019. m. 61*

хувааж, нийгмийн тустай хөдөлмөрт татан оролцуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүний зэрэгцээ шашны үзэл суртлыг устгах, ард олонд хувьсгалт ухамсар суулгах, төлөвшүүлэх сурталчлах ажлыг хамт хэрэгжүүлжээ.<sup>28</sup> Тодруулбал, "1921 оны үндэсний хувьсгалаар монголчууд, түүний дотор лам хуврагууд нэгэн адил эрх, эрх чөлөөг эдлэх боломж нээгдсэн юм. Гэвч Коминтерн, ОК (б) Н-ын даралт, шахалтын улмаас тэрхүү эрхээ хасуулан, улмаар 1930-аад оны II хагаст Монгол орныг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хар сүүдэр Монгол орныг нөмөрч, нийт 17 мянга гаруй лам нарыг нийгмийн оюунлаг өвөрмөц бүлгийн нь хувьд аймаглан устгасан (геноцид) юм. Ийнхүү лам нарын дунд анги ялгаварлах бодлого явуулснаар 1930-аад оны эцэс гэхэд сүм хийдүүд эзгүйрч, сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн"<sup>29</sup> байна.

Улмаар 1940 онд олон мянган лам нарыг оролцуулсан 120 гаруй нэгдэлтэй болсон бөгөөд тэдний үйлдэн гаргаж байгаа бүтээгдэхүүний нэр төрөл олширч, яс чанар сайжран улсаас өгсөн тогтмол биелүүлж байснаар<sup>30</sup> шашны асуудлыг шийдвэрлэсний нэгэн илэрхийлэл гэж үзэж болно.

Гэсэн хэдий ч 1940 онд хуралдсан Улсын VIII их хурлаар баталсан II үндсэн хуулийн 94 дүгээр зүйлд: "БНМАУ-д шашныг төр ба сургуулиас тусгаарласан. Үүнд: БНМАУ-ын иргэд шашин шүтэх, ... эрхтэй"<sup>31</sup> хэмээн заасан тэрхүү хамгаалах эрхийн баталгаа болсон тогтмол үйл ажиллагаатай хийд орон үгүйн дээр шүтэх, сүсэглэх лам хувраг нь шашин номынхоо зам мөрөөс хазайн нийгмийн хөдөлмөр эрхэлхэд хүрсэн байжээ.

Ийнхүү 1943 оны 2 дугаар сард маршал Чойбалсан тэргүүтэй төлөөлөгчид ЗХУ-д айлчилхад ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга М. И. Калинин хүлээж авч уулзаад, төлөөлөгчдөд Москвад байнгын ажиллагаатай христосын сүм хийдүүд ажилладаг тухай, монгол улсын үндсэн хуульд шүтэх бишрэх эрх чөлөөний тухай зүйл заалтаа байгаа эсэхийг асуусан байна. Х. Чойбалсан эл айлчлалаас

---

<sup>28</sup> Пунсалдулам П., *Шинэ соёл монголд төлөвшсөн түүх*. Хянан нягталсан Академич Ж. Болдбаатар. (XX зуун) Соёмбо принтинг Уб., 2018, 17

<sup>29</sup> Болдбаатар Ж., *Монголын түүхэнд бурхны шашны лам хуврагуудын гүйцэтгэсэн үүрэг, байр суурь. Монголын улс төр, шашин, соёлын түүхийн судалгаа*. (Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган) Эрхлэн хэвлүүлсэн Д. Заяабаатар. Уб., 2018, 321

<sup>30</sup> Болдбаатар Ж., *1921 оны хувьсгал ба лам нарын хувь заяа. Монголын улс төр, шашин, соёлын түүхийн судалгаа*. (Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган) Эрхлэн хэвлүүлсэн Д. Заяабаатар. Уб., 2018, 352

<sup>31</sup> Бира Ш., *Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа*. (Бүтээлийн эмхтгэл) Боть III, Уб., 2001, 199

буцаж ирсний дараа 1944 онд Гандантэгчинлин хийдийн хурал номын үйл ажиллагаа сэргээсэн...<sup>32</sup> нэг шалтгаан нь үндсэн хуулийн заалт хангах эрхийн баталгаатай байх ёстойг харуулсан хэрэг юм. Энэ нь нийт ард түмний сүсэг бишрэлийн дүнд хийд орныг сэргээснийг үгүйсгэж байгаа хэрэг биш билээ.

Ерөөс БНМАУ-д шашингүйн суртал нэвтрүүлэг хүчтэй болж, шашингүй нийгэм байгуулахыг эрхэм болгосон юм. Үндсэн хуулиар шүтэх бишрэх эрх чөлөөтэй хэмээн тунхагласан боловч, тэрхүү эрхээ бүрэн эдлэх боломж нөхцөл, баталгаа олгож чадаагүй юм. Гэсэн хэдий ч ахмад үеийн зонхи багш ламтай байж, бурханд сүсэглэн, дотроо залбирсаар байсан<sup>33</sup>-ы дотор ардын язгуур шүтлэгийн хэлбэр уул овоо, тахилга шүтээнтэй газраа ч мөн ямар нэгэн байдлаар хүндэтгэн үзсээр иржээ.

Хэнтий хайрхан болон бусад тахилга, шүтлэгтэй уул усан холбоотой аман түүхийн мэдээ өгсөн хүмүүсийг:

-Нас

-Хүйс

-Боловсрол

-Социалист нийгмийн үед эрхэлж байсан ажил

-Нутаглаж байсан газраар нь ангилж үзвэл дараах байдалтай байна.

№	Хүний нэр	Төрсөн он	Хүйс	Боловсрол	Эрхэлдэг ажил	Нутаглаж байсан газар
1	Б. Балдан	1940	Эрэгтэй	Дээд	Биеийн тамирын багш, анчин байсан	Гутай
2	Д. Батжаргал	1967	Эрэгтэй	Бүрэн дунд	Байгаль хамгаалагч, уяач	Нарийн сайхан
3	Ч. Ганчимэг	1970	Эмэгтэй	Дээд	ТГ-ын дарга	Хориуд

<sup>32</sup> Болдбаатар Ж., 1921 оны хувьсгал ба лам нарын хувь заяа. Монголын улс төр, шашин, соёлын түүхийн судалгаа. (Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган) Эрхлэн хэвлүүлсэн Д. Заяабаатар. Уб., 2018, 352-353

<sup>33</sup> Болдбаатар Ж., Монголын түүхэнд бурхны шашны лам хуврагуудын гүйцэтгэсэн үүрэг, байр суурь. Монголын улс төр, шашин, соёлын түүхийн судалгаа. (Эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган) Эрхлэн хэвлүүлсэн Д. Заяабаатар. Уб., 2018, 321-322


4	Ц. Дагвадулам	1944	Эмэгтэй	Дунд	Малчин, анчны гэргий	Тэнүүн
5	Н. Дашдэндэв	1940	Эрэгтэй	Бага	Малчин, багийн дарга байсан	Галтай Булнай, зуун мод
6	Г. Дашзэвэг	1946	Эрэгтэй	Бага	Малчин	Тэнүүн
7	Д. Зоригтбаатар	1958	Эрэгтэй	Дунд	Бөх, анчин, мужаан	Мөнхжаргалант
8	Д. Товууч	1937	Эрэгтэй	Тусгай мэргэжил	Нягтлан, нэгдлийн орлогч дарга байсан	Тэнүүн
9	Ц. Энхбаатар	1966	Эрэгтэй	Дээд	ИТХ-ын дарга, анчны хүү	Дунд хориуд

### **5.1.3. 2021 оны хээрийн судалгаа:**

2021 оны хээрийн судалгааны ажлыг 2021 оны 09 сарын 25-наас 10 сарын 06-ны өдрийг дуустал нийт 11 хоногийн хугацаанд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Археологийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор /Ph.D/, дэд профессор Б.Цогтбаатар, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Эзэнт гүрэн ба дунд үеийн Монголын түүхийн судалгааны салбарын ЭША, доктор (Ph.D) Г.Алтансүх, Түүх угсаатны зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Энхбаатар, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д. Батдалай, Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны эрдэм шинжилгээний ажилтан Өнөрбаяр, Хан хэнтийн Хан Хэнтий улсын тусгай хамгаалалттай газрын Байгаль хамгаалагч Д.Батсайхан, Ө.Бат-Амгалан, Хэнтий амйгийн эрдэм шинжилгээний ажилтан Л.Бүрэнтөгс, зураглаач Н.Ихбаяр, жолооч Г.Дорж гэсэн 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж түүх, угсаатны зүй хээрийн судалгаа, археологийн дурсгалын хайгуул судалгаа хийв.



*Судалгааны багийн бүрэлдэхүүн*



*Хээрийн судалгааны маршрут*

Хээрийн судалгааг Төв Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумдын нутаг, Хэрлэн, Онон голын эхэн хэсэгт хийсэн. Энэ удаагийн хээрийн судалгаанд түүхэн газар зүй, угсаатны зүйн судалгаа, археологийн хайгуул судалгааг хийж гүйцэтгэсэн юм.

Археологийн хайгуул судалгаанд Бурхан Халдун хайрханы өвөр, Хэнтий нуурын эрэг, Хуруу голын эхэн хэсэг, Бага хэнтий уулын ар, Сүглэгэр уулын энгэр, Нанзан уулын энгэр зэрэг газарт судалгаа хийж гэрэл зургаар баримтжуулав. 2020 оны хээрийн судалгаагаар бид Бурхан халдун уулын өвөр, зүүн тал, Ахын гурван дэв, Хориудын нуруу, Бунхант, Солооч гэх мэт газруудад хайгуул хийсэн билээ. Тэгвэл энэ удаа бид Бурхан халдун уулын ар, баруун тарлаар морин хайгуул хийснээр 2020, 2021 оны хээрийн хайгуул судалгаагаар Бурхан халдун уулын орчны бүсийг бүрэн хамарсан хайгуулыг гүйцэтгэж чадсан юм.

Угсаатны зүйн судалгаанд нутгийн уугуул иргэдээс аман түүхийн мэдээ цуглуулах арга зүйг энэ удаагийн хээрийн судалгаанд ашиглаж, Бурхан халдун



хайрхан уултай холбогдох хорио цээр, тахилга шүтлэг, зан заншилтай холбоотой мэдээлэл цуглуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Гэвч энэ удаагийн хээрийн судалгаанд дэлхий нийтээр гарсан ковид-19 цар тахлын улмаас угсаатны зүйн хээрийн судалгааг өргөн хэмжээнд явуулах боломж нэлээд хязгаарлагдмал байсан гэдгийг тэмэглэх хэрэгтэй. Хотоос ирсэн судлаачидтай нутгийн иргэд уулзахаас цааргалж, гэртээ оруулахаас татгалзаж байсан юм.

Түүхэн газар зүйн судалгаанд түүхэн үйл явдал өрнөсөн газар орныг нүдээр үзэж, газар зүй, байгаль орчны хүчин зүйлсийг газар дээр нь дахин тодорхойлж, түүхэн сурвалжуудад буй мэдээ баримттай тулгаж, нягтлах судалгааг хийв. Үүний хүрээнд зарим газрыг байршил нэрийн судалгааг тодруулах ажил хийсэн.

Археологийн хайгуул судалгааг авто машин ба морин тээвэр ашиглаж гүйцэтгэсэн. Гэхдээ тухайн бүс нутагт торлог ургамал маш өндөр ургаж газрын гадаргыг битүү бүрхсэн нь энэнхүү хайгуулын судалгаанд нэлээд бэрхшээл учруулж байсан бөгөөд дурсгал бүртгэлгүй үлдэх нөхцөлийг бүрдүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Археологийн хайгуул судалгаа Бурхан Халдун уулын ар ба баруун талын газар орноор төвлөрч явагдсан. Энэ удаагийн судалгаагаар нэлээд хэдэн овооны ул мөр, дурсгал байж болох чулуун зохион байгуулалтын бүртгэж баримтжуулсан.

Судалгааны ажлын товч үр дүн:

### *1. Археологийн судалгаа*

Археологийн хайгуул судалгааг авто машин ба морин тээвэр ашиглаж гүйцэтгэсэн. Гэхдээ тухайн бүс нутагт торлог ургамал маш өндөр ургаж газрын гадаргыг битүү бүрхсэн нь энэнхүү хайгуулын судалгаанд нэлээд бэрхшээл учруулж байсан бөгөөд дурсгал бүртгэлгүй үлдэх нөхцөлийг бүрдүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Археологийн хайгуул судалгаа Бурхан Халдун уулын ар ба баруун талын газар орноор төвлөрч явагдсан. Энэ удаагийн судалгаагаар нэлээд хэдэн овооны ул мөр, дурсгал байж болох чулуун зохион байгуулалтын бүртгэж баримтжуулсан.

### *2. Угсаатны зүйн хээрийн судалгаа*

Энэхүү судалгааны урьдчилсан мэдээнд тухайн нутгийн иргэдийн тахиж шүтдэг газар нутгийн талаарх мэдээ мэдээллийг нягтлах улмаар энэ нь социалист нийгмийн үед иргэдийн хэрхэн уул хайрхадтайгаа харилцаж байсан бэ гэдгийг цухас тодруулах зорилго тавьж байсан юм. Мөн Урианхай нартай холбогдох хэд хэдэн сэдвүүдээр төлөвлөгөө гарган эх хэрэглэгдэхүүн хуримтлуулж явсан. Хэрлэнгийн эх орчмын тахилга шүтээнтэй газруудыг төлөөлүүлэн Төрийн тахилгат Бурхан Халдун хайрхны тахилга, түүнийг сэргээсэн байдал, социалист нийгмийн үед хүмүүс хэрхэн тахилга шүтээнтэй уул устай харилцаж байв гэдгийг 2013 болон 2020 онд Төв


аймгийн Мөнгөнморьт 2021 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдад хийсэн угсаатны зүйн хээрийн шинжилгээний материалд тулгуурлан, тэр нутгийнхны аман түүхээр тодруулах юм. Мөн их төлөв 2021 оны судалгааны дүнд үндэслэн түүх аж ахуй тэр дундаа мэхээр нээх арга ажиллагааны тухай мэдээлэл цуглуулсан. Дээр өгүүлсэнчлэн энэ удаагийн угсаатны зүйн хээрийн судалгаанд дэлхий нийтээр гарсан ковид-19 цар тахал сөргөөр нөлөөлж олон хүнтэй уулзаж өргөн мэдээлэл цуглууж чадаагүй. Хотоос ирсэн судлаачидтай нутгийн иргэд уулзахаас цааргалж, гэртээ оруулахаас татгалзаж байсан юм.




*Судалгааны ажлын бэлтгэл: авто машин болон морин тээвэр ашигласан.*



*Судалгааны ажлын бэлтгэл: авто машин болон морин тээвэр ашигласан.*



*Хайгуул, судалгааны явц...*



*Хайгуул, судалгааны явц...*



*Хайгуул, судалгааны явц...*

#### **5.1.4. 2022 оны хээрийн судалгаа:**

2022 оны хээрийн судалгааны ажилд тус төслийн голлох судлаачид оролцон Төв аймгийн Мөнгөнморьт, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутагт 2022 оны 06-р сарын 24-нөөс 07-р сарын 02-ны өдрийг дуустал 10 өдөр ажиллаа.

Судалгааны баг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор Б. Цогтбаатар, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эртний түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Г.Алтансүх, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Монголын эзэнт гүрэн ба дундад зууны түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Л.Ганбат, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Чулуун зэвсгийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Г.Лхүндэв, Бурхан халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргааны ажилтан Б.Өнөрбаяр нарын бүрэлдэхүүнтэй Төв аймгийн Мөнгөнморьт сумын хоёрдугаар багийн нутаг Хэрлэн голын зүүн эрэг дагуух түүх соёлын дусргалыг бүртгэх, баримтжуулах, орон нутгийн уугуул иргэдээс эртний уламжлалт тахилга шүтлэгтэй уул, ус, овоо тахилгын талаар сурвалжлах ажлыг 06 сарын 25-28 өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Бид судалгааны ажлыг цааш төлөвлөсөн маршрутын дагуу үргэлжлүүлэн 06 сарын 29 – 07 сарын 02-ны хооронд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Согоот багийн нутаг Хар зүрхний Хөх нуур орчим, Ногоон нуруу, Шарилын дугуй зэрэг газруудад ажиллаж түүх, соёлын өвийг бүртгэх, баримтжуулах, нутгийн иргэдээс эртний тахилга шүтлэгтэй уул, овооны талаар мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэсэн. Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ нутгийн иргэдээс морь түрээслэн авч явсан бөгөөд шаардлагатай үед явган хайгуул хийсэн.

#### *Судлагааны багийн бүрэлдэхүүн*





Судалгааны ажлын товч үр дүн:

**Археологийн судалгаа:** Археологийн хайгуул судалгааг авто машин ба морин тээвэр ашиглаж гүйцэтгэсэн. 2022 оны 06 сарын 24-өөс 07 сарын 02-ны өдөр Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Хар зүрхний Хөх нуур, Ногоон нуруу, Шарилын дугуй, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Хэрлэн голын зүүн эрэг, Тэнүүний голын урд талаар түүх соёлын дурсгалыг бүртгэх баримтжуулах ажлыг гүйцэтгэсэн. Энэхүү ажлын үр дүнд өмнө нь бүртгэгдээгүй гурван дурсгалт газрын 40 орчим түүх, археологийн дурсгалыг бүртгэн баримжуулав. Судлагааны ажил хийхдээ түүх соёлын дурсгалд учирсан эрсдэлийн үнэлгээг мөн давхар хийсэн. Тухайлбал, орон нутгийн иргэдийн ахуйн гаралтай хог хаягдлыг хиригсүүр, дөрвөлжин булшинд ихээр хаясан, ухаж сүйтгэсэн зүйл цөөнгүй тааралдаж байна. Мөн онцгойлон тэмдэглэхэд Цэнхэрмандал сумын нутаг дэвсгэр Ногоон нуруу, Шарилын дугуй орчмын түүх, археологийн дурсгалыг нэг бүрчлэн ухаж сүйтгэсэн байгаа нь хээрийн судалгааны явцад тодорхой ажиглагдаж байлаа. Ногоон нуруу бол машин техник очиход бэрх ой, шугуй, хад асгатай өндөр нуруу боловч түүний оройгоор газар ухагч хүнд техниктэй явж бүх дурсгалыг нэг бүрчлэн ухаж сүйтгэсний дээр, Урианхад нарыг гол шүтээн овоог хүртэл ухаж сүйтгэсэн явдал гарчээ. Энэ нь Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт буюу Дэлхийн өвийн бүс нутагт байгаа түүх соёлын дурсгалд аюул нүүрлэх эрсдэл бодитой тулгарч байгааг харуулж байна. Ой хөвч, шавар намаг, хад асга, уул нуруу, нутгийн иргэдийн сүсэг бишрэл аль алийг нь үл хайрхан ямарч хөвчийн хүнд хүнд техниктэй очиж булш бунхан тонох эрсдэл бодитой байгаа нь энэ байдлаас илэрхий байна. Тиймээс цаашдаа Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт

буй соёлын өвийн хамгаалалтын менежментийг сайжруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна.

***Угсаатны зүйн судалгаа:***

Бурхан халдун уулын тахилга, шүтлэг бишрэл, цаашдын хамгаалалтын менежменттэй холбоотой нэг асуудал Их хоригийг үе улам дамжин хамгаалж байсан урианхай нарын асуудалд чиглэсэн. Гэхдээ өөрсдийгөө урианхай гэж нэрлэдэг хүмүүсийн дунд судалгаа хийж, түүний үр дүнд тулгуурлан бусад урианхай нарыг буюу өөрсдийгөө урианхай гэдгийг матрсан бусад урианхай нарыг таних, илрүүлэх боломжийг эрэлхийлсэн юм. Нутгийн урианхадын дунд яригддаг “Урианхадын гол шүтээн тахилгын овоонь Ногоон нурууны зүүн хойд талын овоо” гэж ярьдаг мэдээг үндэслэн үзвэл Цэнхэр мандал сумын хоёрдугаар баг, Цэнхэрийн голоор нутагладаг өөрсдийгөө “Бишрэлт” хэмээн нэрлэдэг хүмүүс урианхай байх магадлалтай нь тодорхой болсон. Учир нь Бишрэлтийнхний гол тахидаг овоо нь урианхдуудын гол тахидаг овоо байгаа юм. Мөн нутгийн иргэдийн ярианд гарч буй “Цэнхэрийн голын цээжний хүүхэд, урианхадын унаган шавь” гэсэн хэлц нэлээд түгээмэл байгаа нь Өндөр гэгээнд шавь орсон Бишрэлт, Хийдчин хоёр отгийнхон мөн урианхай байх магадлалтайг харуулж байна. Энэ мэт өөрсдийгөө Бишрэлт, Хийдчин эсвэл Бишрэлтийнхэн, Хийдчнийхэн гэх мэтээр нэрлэж буй хүмүүс урьд цагт Бурхан халдуныг хамгаалж байсан урианхай нарын удам байх магадлалтай байна. Үүнийг түүх, архивын судалгаагаар гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Хийдчин, Бишрэлт хэмээх хоёр отгийнхон эдүгээ Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг дахь Бурхан халдууны чигийн хэсэгт буюу Хориуд, Хэрлэн гол, Тэнүүний голоор, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын хойд талаар буюу Хар зүрхний Хөх нуур, Юүдэгийн гол, Цэнхэрийн голын эхээр нутаглаж байна. Өөрөөр хэлбэл, урианхай нар эдүгээ ч Бурхан халдун уулыг тойрон нутаглаж байна гэсэн үг. Гэхдээ зарим хэсэг нь урианхай гэдгээ мартаж, хожим хуваарилсан засаг захиргааныхаа нэрээр нэрлэгдэн явж байгаа бололтой. Цаашид Өмнөдэлгэр, Батширээт сумын Бурхан халдун уул орчмын нутгийн иргэдийн дунд угсаатны зүйн хээрийн судалгаа явуулж урианхай нарыг сурвалжлах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрлээ.



Судалгааны ажлын явц

## 5.2. Мэдээллийн сан бүрдүүлэлт

Төлсийн “Үр дүнгийн даалгавар”-ын 2-рт “Дэлхийн өвийн дурсгалт газрын түүх, археологийн дурсгалын мэдээллийн сан бүрдүүлнэ.” гэж заасан ажлын хэрэгжилтийг хангах зорилгоор төслийн хүрээнд цугларсан бүх мэдээллийг нэгтгэсэн нэгэн багц мэдээлийн сан бүрдүүлэв. Үүнд: 5 удаагийн хээрийн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн (Үүнд: археологийн дурсгалыг баримтжуулах, олж илрүүлэх хайгуул судалгааны үр дүн, угсаатны зүйн судалгааны үр дүн, эх хэрэглэгдэхүүн, түүхэн газар нутгийн судалгааны үр дүн, эх хэрэглэгдэхүүн), 2500 гаруй гэрэл зураг, 20 орчим аудио болон ведио бичлэг, 1347 нүүр архивийн баримт, 20 орчим Бурхан халдун ууланд холбогдох өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл, Бурхан халдун уул, Балданбэрээвэн хийд, Рашаан хадны дурсгалыг виритуал танилцуулга, Дэлхийн өвийн газар нутаг дахь 200 орчим газар зүйн биетийн байршил, нэрийн судалгаа, газрын зураг, газар зүйн мэдээллүүд гэх зэргийг багтаасан мэдээллийн сан бүрдсэн. Тухайлбал:


1. Төслийн хүрээнд нийт 5 удаагийн хээрийн судалгаа хийж, археологийн дурсгалыг баримтжуулах, эрэн хайх судалгааг явуулж үр дүнг стандартын дагуу бүртгэн мэдээллийн санд оруулсан.
2. Төслийн хүрээнд угсаатны зүйн судалгааг хоёр удаа явуулж Хан Хэнтий уул, Бурхан халдуны тахилга тайлгатай, уламжлалт хорио цээр, дэг ёстой холбоотой мэдээллийг цуглуулж мэдээллийн санд оруулсан.
3. Төслийн хүрээнд явуулсан хээрийн судалгааны дүнд төслийн судалгааны тайлбайд хамаарах түүхэн газар нутгийн судалгааг хийж мэдээллийн санд оруулсан.
4. Монголын Үндэсний төв архивийн сан хөмрөгт хадгалгагдаж буй Хан Хэнтий уулын тахилга, тайлга, шүтлэг бишрэл, уламжлалт хамгаалалт зэрэгтэй холбогдох 1347 нүүр материалыг сканердан авч цахим сан бүрдүүлсэн.
5. Хээрийн судалгааны явцад хуримтлагдсан 2500 гаруй гэрэл зургийг мөн электрон байдлаар мэдээлийн санд оруулсан.
6. Бурхан халдун уул, түүний орчны бүс нутагт хамаарах газар зүйн биетүүдийн холбогдох газрын зураг, гэрэл зураг, тойм зургийг үйлдэж санд оруулсан.
7. Бурхан Халдун уул, Балданбэрээвэн хийд, Рашаан хадны дурсгалыг виритуал танилцуулгыг мэдээллийн санд байршуулсан.
8. Төслийн хүрээнд хэвлүүлсэн дөрвөн бүтээлийн цахим эх, эх хэрэглэгдэхүүн мөн тус мэдээллийн санд оруулсан.



### 5.3. Шинэ ном, бүтээлийн танилцуулга

“Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн орчны бүсийн түүх, соёлын өвийн судалгаа” сэдэвт захиалгат төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээнд заасны дагуу 4 багц бүтээлийг хэвлэн гаргаж, нэг цахим танилцуулга бэлэн болгосон. Үүнд:

1. Э.Равдан. *Дэлхийн өв-Бурхан халдуны бүс дэх газар нутгийн байршлын толь*. УБ., 2023. 104 тал.
2. Н.Хатанбаатар, С.Чулуун. *Балданбэрээвэн хийд*. УБ., 2020. 96 тал.
3. Дэлхийн өв – Бурхан халдун: Зурагт альбом. УБ., 2023. 104 тал.
4. Чингис хааны өв, соёл: Архивийн баримтын эмхэтгэл. Крилл үсэгт хөрвүүлж, эрдэм шинжилгээний тайлбар хийсэн Г.Мягмарсамбуу, Г.Цэрэнсугар. УБ., 2020. 727 тал.
5. “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” болон орчны бүсийн дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газруудын виртуал танилцуулга




#### 5.3.1. Э.Равдан. *Дэлхийн өв-Бурхан халдуны бүс дэх газар нутгийн байршлын толь*. УБ., 2023. 104 тал.

Энэ тольд Дэлхийн өвийн газрын нутагт хамаарах 200 орчим газар зүйн биетийн байршлыг газрын зургийн нэр, дугаараар нь тогтоон оруулсан байна. Чингэхдээ Монгол улсын 1:100 000 нарийвчлал бүхий газрын зургаас газрын биетүүдийн байршлыг заахдаа зургийн хэсгийг байршлын тоон үзүүлэлттэй хамтад нь оруулсан нь уг биетийг GPS- гүй тохиолдолд орчны газраар нь тоймлон тогтоох боломжтой болгожээ.

Тус бүтээл нь Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн түүхэн газар орны бүх талын судалгааг хийхэд, тус орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал хэрэгцээтэй мэдээлэл агуулсан бүтээл юм. Ингэснээрээ тус нутагт олон талын судалгаа хийхэд, тус орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал хэрэгцээтэй мэдээлэл агуулсан байна. Бурхан халдун уул 2015 онд НҮБ-ын ЮНЕСКО-гийн шийдвэрээр Дэлхийн соёлын өвийн жагсаалтад “Great Burkhan Khaldun Mountain and its Surrounding Sacred Landscape” нэрээр бүртгэгдсэн. “Дэлхийн соёлын өвийн Их Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-ийн нутаг дэвсгэр нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутгийн зарим хэсгийг багтаасан, нийт 415012 га талбай эзэлдэг.

### 5.3.2. Н.Хатанбаатар, С.Чулуун. *Балданбэрээвэн хийд*. УБ., 2020. 96 тал.

Энэхүү номонд Монголын дорнод бүсийн томоохон хийд Сэцэн хан аймгийн нутагт оршиж байсан Балданбэрээвэнгийн үүсэл хөгжил, бүтэц, зохион байгуулалт, бурхан шүтээн, хурал ном, аж ахуй-эдийн засгийн түүхийн зарим асууллыг тоймлон өгүүлж, Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Сурвалж судлал, баримтын төв, Оросын ШУА-ийн Санкт-Петербургийн салбарын архивт хадгалагдаж буй түүхэн гэрэл зургаар баримтжуулсан болно.



Балданбэрээвэн хийд нь Их шавийн харьяат хийд бөгөөд Богд Жибзундамба хутагтын 7 цоржийн нэг Цэвээндорж номун ханы үүсгэн байгуулсан хийд юм. Уг

хийдийг Халхын Сэцэн хан аймгийн Хөвчийн жонон вангийн хошууны нутаг, одоогийн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутагт Дэлгэрхаан уулын салбар Мөнх-Өлзийт уулын энгэрт Бат нуурын хойд талд 1777 онд байгуулагджээ.

Уг хийд нь эдүгээгээс 230 орчим жилийн тэртээ Хан Хэнтий уулын аймгийн төвд оршдог Оонын цагаан талаас 170 гаруй км алсалсан урьдын Хөвчийн эрдэнэ дайчин жонон ван буюу хожмын Биндэрьяа хан уулын хошууны Хэнтий хан сумын нутаг Баянбараат уулын зүүн умар, хойт Дэлгэрхаан хайрханы дорно чиглэл дэхь онгон зэлүүд ой шугуйн өтгөн шигүү царс, хуш, модод, байц хадан хясаа, элгэн хадан цохио, ус намагтай нэн эрт галвын тогтоц бүхий Хан Хэнтийн урт нурууны салбарын хөгшин уулсын дундахь зай чөлөөний аяган хунхуйн хонхор дахь саруулхан дэвсэг дээр оршиж байсан юм. Тодотгон өгүүлбээс, Мөнх-Өлзийт овооны өвөр элгэнээ Батхөл нуурын умар дэнж дэхь Баянхангай уулын баруун суга арван гурван Сансар уулын ар хормой, баруун Жаргалант голын өрнө хөндийн өвөр талд суурьшиж байгаад 1938-1990-ээд оны эхэн хүртэлх 50 гаруй жилийн туршил мөхөл хэлмэгдэлд өртөж, балгас төдий болон үлдсэн түүхтэй.

### **5.3.3. “Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгал газар” каталоги. УБ., 2023. 96 тал.**

Төлсийн үр дүнгийн даалгаварын 6-рт “Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгалт газрын аялал жуулчлалын маршрут, газрын зурагтай цомог хэвлүүлэх” хэмээн заасны гүйцэтгэлийг биелүүлэхийн тулд “Зургийн цомог: Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгал газар” нэртэй каталогийг бэлтгэн хэвлүүлэв. Цаасны хэмжээ 25,7 х 25,7, 96 тал. Тус каталогид ашигласан зургууд нь 2019-2022 онд төслийн хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны дүнд цуглуулсан гэрэл зургийн сан болон каталогид зориулан авсан гэрэл зургуудаас бүрдэж байна.

Тус каталогийн агуулга дараах үндсэн бүлгүүдээс бүрдэнэ.

1. Дэлхийн өв: Бурхан халдун уул
2. Дэлхийн өв Бурхан халдун уулын түүх, соёлын өв
3. Дэлхийн өв Бурхан халдун уулын байгалийн өв
4. Аялал жуулчлалын маршрут



Эхний хэсэгт, Бурхан халдун уулын тахилга тайлга, Дэлхийн өвд бүртгэгдсэн түүх, Дэлхийн өвд бүртгэгдсэн гэрчилгээ гэх зэрэг Дэлхийн өвийн холбогдолтой гэрэл зураг, тайлбар

Хоёрдугаар хэсэгт, Бурхан халдун уулын түүх, соёл, түүний орчины бүсэд хамаарах түүхэн газар орныг багтаасан. Үүнд: Бурхан халдун, Дээд овоо, Дунд овоо,

Доод овоо, Ахын гурван дэв, Босгын даваа, Үүд мод, Цагаан арал, Хориудын ам, Эрдэнэ уул, Хэнтий нуур, Хэрлэн гол, Онон гол, Бүрги эрэг, Тэнүүний гол гэх мэт байгалийн үзэсгэлэнт нутаг, түүхэн газар орныг багтаасны дээр Бүрхийн дөрвөлжин, Хүрээт дов, Тэрэлжийн дөрвөлжин, Гуа дов гэх мэт түүхэн дурсгалт газруудыг багтаасан болно.

Гуравдугаар хэсэгт, Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн ургамлын бүрхэвч, дээд, доод ургамал, ой мод, ан амьтан, загас, шавж, геологийн онцлог зэргийг багтаасан болно.

Дөрөвдүгээрт хэсэгт, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловруулан гаргасан Бурхан халдун уулын орчимд аялан явах аялалын маршрут, хоноглох цэг гэх мэт холбогдох журмыг оруулсан.


Ийнхүү үр дүнгийн даалгаварт заасан шаардлагад бүрэн нийцсэн аялал жуулчлалын маршрут бүхий зурагт каталогийг бэлэн болгосон.

**5.3.4. Чингис хааны өв, соёл: Архивийн баримтын эмхэтгэл. Крилл үсэгт хөрвүүлж, эрдэм шинжилгээний тайлбар хийсэн Г.Мягмарсамбуу, Г.Цэрэнсугар. УБ., 2020. 727 тал.**

Энэхүү архивын баримтуудын эмхэтгэл нь төслийн үр дүнгийн даалгаварын 8-рт “Хан Хэнтий уул (Бурхан Халдун)-ын тахилга тайлгын тухай архивын баримт,

эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг эмхэтгэх” гэж заасан ажлын хүрээнд цуглуулсан архивын баримтаас зарим баримтыг сонгон хэвлүүлсэн юм.

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Чингис хааны өв, соёлын хүрээлэн хамтран “Дэлхийн өв: Бурхан халдун уул түүнийг хүрээлсэн тахилгат газар орчны бүсийн түүх соёлын өвийн судалгаа” төслийн хүрээнд туурвисан энэхүү эмхэтгэлд Монгол улсын Үндэсний төв архивын Түүхийн баримтын архивт хадгалагдаж буй



Чингис хааны өв, соёлд холбогдох 110 баримтуудыг кирилл үсэгт хөрвүүлэн, эрдэм шинжилгээний тайлбар хийж, уг эхийн хуулбарынх нь хамт оруулжээ. Монголчуудын оюун санааны хүрээнд Чингис хааны эзэлж байсан байр суурь, түүхэн цаг үеүдэд Монголын төр засгаас Чингис хааны талаар баримталж байсан бодлого, гаргасан шийдвэр болон Чингис хааны өв соёлд холбогдох энэхүү ховор чухал баримт сурвалжууд нь эрдэмтэн судлаачдын төдийгүй өргөн олон уншигчдад нэн сонирхолтой бүтээл болсон.

### 5.3.5. Бурхан Халдун уул, Балдан Бэрээвэн хийд, Биндэр уул, Рашаан хадны дурсгалын виртуал танилцуулга

Цахим технологи, түүний дотор виртуал ертөнц, виртуал аялалын технологи сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж хүн төрөлхтний өдөр тутмын амьдралын салшгүй нэгэн хэсэг хэдийн болжээ. Тухайлбал, дэлхийн өнцөг булан бүрт 360 панорама виртуал аялал хийх боломж (Google street view) бүхий Google maps платформыг сар бүр дэлхий даяар нийт 1 тэрбум хүн ашигладаг байна. Технологийн энэхүү өөрчлөлт шинэчлэлт нь аялал жуулчлалд хандах хандлагад мөн ихээхэн

нөлөөлсөн бөгөөд аялал хийхийн өмнө очих газартаа виртуал аялал хийх, аялалаа нарийвчлан төлөвлөх хандлагыг бий болгосон байна. Соёлын өв, түүхэн дурсгалт газруудад түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр зорьж буй Монгол орны тухайд технологийн энэхүү хөгжилтэй хөл нийлүүлж алхах зайлшгүй шаардлага бий болоод байгаа билээ.

Энэхүү төслийн хүрээнд бид Google street view-ийн жишгээр Бурхан Халдун уул, Балдан Бэрээвэн хийд, Биндэр уул болон Рашаан хадны дурсгалын 360 виртуал танилцуулгыг бэлтгэсэн. Виртуал танилцуулга бэлтгэх үе шатууд:

**1-р үе шат:** Газар дээр нь гэрэл зураг авах ажил.

Хээрийн судалгааны ангийн бүрэлдэхүүнтэй хамт томилолтоор явж виртуал танилцуулгад ашиглах гэрэл зургийг Canon EOS 6D дижитал камер болон DJI Mavic 2 Pro маркийн дрон ашиглан авсан.

**2-р үе шат:** Гэрэл зургийг боловсруулан 360 дэлгэмэл зураг болгох.

Тусгайлан авсан гэрэл зургуудийг Kolor AutoPano Giga 4.4 программ хангамж ашиглан 360 дэлгэмэл зураг боловсруулав. (Зураг 1)


**3-р үе шат:** Тайлбар текст бэлтгэх

Виртуал тур боловсруулахад шаардлагатай түүхэн газар усны нэр болон холбогдох тайлбар сэлтийг судалгааны багаар бэлтгүүлэн авч танилцуулгад оруулахад бэлэн болгов.


**4-р үе шат:** Виртуал аялал хийх боломж бүхий танилцуулга бэлтгэх

Бэлэн болсон 360 дэлгэмэл зураг болон танилцуулга текстийг ашиглан Kolor Panotour Pro 2.5 программ хангамжаар нэгтгэн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болох 360 панорама виртуал тур бэлэн болголоо. (Зураг 2)

Цаашид энэхүү виртуал танилцуулгыг интернэтэд байрлуулан олон нийтэд нээлттэй сурталчлах, Google street view-тэй уялдуулбал дотоод болон гадаадын аялагч, жуулчдад нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүн болсон.



Зураг 1. Kolor AutoPano Giga 4.4 программ ашиглан дэлгэмэл зураг бэлтгэж байгаа нь



Зураг 2. Kolor Panotour Pro 2.5 программ хангамжаар виртуал тур бэлтгэж байгаа нь

#### 5.4. Бурхан Халдун уулын дэлхийн өвийн газар нутаг дахь байгалийн нөөцийн судалгааны тайлан

2020-2022 оны хооронд Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны оролцоотойгоор Бурхан халдун уул, түүний орчны бүсийн байгалийн өвийн судалгааг хийж, товч тайлан бичсэн. Судлагааны ажлыг зарим үр дүнгээс танилцуулвал.

Усны судалгаанд Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг, Хэрлэн голын эхэн урсгалыг бүрдүүлэгч гол мөрний урсац, усны чанарын судалгааг гидрохимийн судалгааны арга зүйгээр хийж, Хэрлэн голын эхэн хэсгийн 15 голоор

явж, хэмжилт судалгаа хийж, 13 голын усны сорьц авсан. Шинжилгээгээр бүх голын ус химийн бүрэлдэхүүний хувьд гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-2-р төрлийн, чанарын хувьд эрдэсжилтээрээ нэн цэнгэгээс цэнгэг, хатуулгийн хувь маш зөөлнөөс зөөлөн, харин Их Ах голын ус ганцаараа эрдэслэг, — хатуувтар, бохирдлын үзүүлэлтүүд хамгийн ихээр илэрч байлаа. Энэхүү судалгааны тайлангаас Бурхан Халдун уулын орчмоос эх аван урсдаг Дэлхийн өвийн бүс нутагт хамаарах 15 голын усны урсац, усны чанарын үндсэн мэдээллийг авч болно.

Хөхтөн амьтны судалгаанд Дэлхийн соёлын өвд “Бурхан Халдун хайрхан, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгууд” нэрээр бүртгэгдсэн Дэлхийн хосгүй гайхамшигт өв Бурхан Халдун хайрхан орчмын хөхтөн амьтны тооллого судалгааг хийж, мэдээллийн санг нэмэгдүүлэх зорилготой байв. Энэ зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна.

1. Бурхан Халдун хайрхан орчмын хөхтний амьтны олон янз байдал, тэдгээрийн байршил нутгийн судалгаа хийж, мэдээлэл цуглуулах,
2. Байгаль хамгаалагчдыг хээрийн судалгааны арга зүй ба багаж хэрэгсэлтэй харьцаж сурах, бие даан тооллого судалгаа хийх чадвартай болгох,
3. Тухайн бүс нутагт тохиолдож байгаа хөхтөн амьтны байршил, нутаг, тархац, тоо толгойн талаарх мэдээллийг БИОСАН ба ТХГН-ийн мэдээллийн санд оруулах

Судалгааны явцад нийтдээ 6 зүйлийн 95 бодгаль амьтныг тэдгээрийн ул, мөрний онцлог шинж тэмдэг дээр нь үндэслэн ялган таних болон биетээр харж тоолсон.

№	Зүйлийн нэр	Судалгааны баг			Нийт
		Хэрлэн 1	Хэрлэн 2	Тэнүүн	
1	Халиун буга <i>Cervus elaphus</i>	3	5	15	23
2	Хандгай <i>Alces alces</i>	3	3	1	7
3	Бор гөрөөс <i>Capreolus pygargus</i>	-	3	2	5
4	Зэрлэг гахай <i>Sus scrofa</i>	20	35	-	55
5	Чоно <i>Canus Lupus</i>	1	1	-	2
6	Хүрэн баавгай <i>Ursus arctos</i>	-	2	1	3
Нийт		27	48	19	95

Энэхүү Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүний орчны бүст хийсэн ус, амьтан, ой модны судалгаа нь тухайн бүс нутгийн байгалийн нөхцөл, нөөцийг тодорхойлох үндсэн мэдээллийг өгнө.



## 5.5. Хан Хэнтий уул (Бурхан Халдун) -ын тахилга тайлгын тухай архивын баримт, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийг эмхэтгэх

5.5.1. Төслийн үр дүнгийн даалгаварын 8-р заасанчлан Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн түүх, соёлын асуудал холбогдох эрдэм шинжилгээний сонгомол өгүүлэл, илтгэлийн эмхэтгэлийг бэлтгэв. Энэ эмхэтгэлд нийт 13 өгүүлэл, 10 илтгэл багтсан. Хэмжээ нь А4 240 тал, Үүнд:

### ***Бурхан Халдун уулын түүх, соёлд холбогдох өгүүлэл***

1. Ринчен Б. БУРХАН ХАЛДУН ГЭГЧ ҮГИЙН ТАЙЛБАР.....5
2. Schubert J. BURXAN XALDUN – XENTII XAN? .....6
3. Бадамхатан С. ЧИНГИС ХААН: Энд би нойрсоно.....12
4. Пэрлээ Х. Их хориг хаана вэ?.....35
5. Саруулбуян Ж. ДУРСАМЖ ХАН ХЭНТИЙ УУЛЫН ТАХИЛГА ҮЗСЭН МИНЬ.....41
6. Чулуун С. БУРХАН ХАЛДУН МОНГОЛЫН ЭРДЭМТДИЙН СУДАЛГААНД .....49
7. Дулам С. “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ” “QOSI’UN QUCILIS” ХЭЛЦ БОЛОН “BURQAN-QALDUN” НЭРИЙН ТУХАЙ.....57
8. Равдан Э. БУРХАН ХАЛДУН, ГУРВАН МӨРНИЙ ЭХ, ТАНА ГОРИХОН, БУРГИ ЭРГИ.....69
9. Өлзийбаяр С. “ИХЭСИЙН ГАЗАР”-ЫН УТГА УЧИР ХИЙГЭЭД БИНДЭР ОВООНЫ ТАХИЛГЫН АСУУДАЛД.....97
10. Базаррагчаа М. “БУРХАН ХАЛДУН” ГЭДЭГ ҮГИЙН ГАРАЛ, БҮТЦИЙН ОНЦЛОГ.....106
11. *ᠪᠤᠷᠬᠠᠨ ᠬᠠᠯᠳᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠲᠦ᠋ᠭᠦᠯᠡᠯ* . *«ᠶ᠋ᠢᠬᠡᠰᠢᠶ᠋ᠨ ᠭᠠᠰᠠᠷ»* ᠰᠢ *«ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠨᠠᠭᠤᠴᠤ ᠲᠣᠪᠴᠣᠣ»* ᠲᠦ *ᠭᠠᠰᠠᠷ ᠤᠰᠤᠨᠢ* .....109
12. Пэрлээ Х. «МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО»-НЫ ГАЗАР УСНЫ НЭРИЙН ТУХАЙ УРЬДЧИЛСАН МЭДЭЭ.....118
13. Гэрэлбадрах Ж. МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНД ГАРДАГ БУРГИ ЭРЭГ ЧУХАМ ХААНА БАЙСАН БЭ?.....128

### ***Бурхан халдун уулын түүх, соёлд холбогдох илтгэл***

1. Ж.Саруулбуян АХЫН ГУРВАН ДЭВИЙН НЭРИЙГ АХИУЛАН ЭРГЭЦҮҮЛЖ ӨГҮҮЛЭХ НЬ.....144
2. Алтансүх Г., Цогтбаатар Б. “ИХ ХОРИГ”-ИЙН ГАЗАР НУТГИЙН ЗАРИМ АСУУДАЛД .....148
3. Одмэргэн Б. МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ГАЗАР УСНЫ СУДАЛГАА: БУРГИ ЭРЭГ.....156
4. Өнөрбаяр Б. БУРХАН ХАЛДУН УУЛ, ТҮҮНИЙГ ХҮРЭЭЛСЭН ТАХИЛГАТ ГАЗАР НУТГИЙН ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙН СУДАЛГАА .....169

5. Пүрэв Ю. ЭЗЭН ЧИНГИСИЙН НУУЦЛАГДМАЛ НУТАГ БУЮУ МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ 89 ДҮГЭЭР ЗҮЙЛ.....179
6. Алтансүх Г., Мөнхбаатар Ш. МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ *BÜRGI-ERGI*-ИЙН БАЙРШЛЫН ТУХАЙ.....184
7. Уртнаст Боржигин. МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООН ДАХЬ “БУРХАН БОСГОСОН” ҮГИЙН ТУХАЙ.....189
8. Ганбат Л. БУРХАН ХАЛДУНЫ УРИАНХАДЫН ЗАРИМ ЗАН ҮЙЛИЙГ НЯГТЛАХ НЬ.....197
9. Мэндсайхан Х., Тайванжаргал Г. ХАН ХЭНТИЙ УУЛЫН ЦАГДАА ӨРХИЙН ТУХАЙ.....203
10. Энхбаатар М. ТАХИЛГА ШҮТЭЭНТЭЙ ГАЗАР НУТГИЙН АМАН ТҮҮХЭЭС (*Хэрлэн голын эх орчмын нутгийн жишээгээр*).....211

5.5.2. “Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн орчны бүсийн түүх, соёлын өвийн судалгаа” сэдэвт захиалгат төслийн Үр дүнгийн даалгаврын 8-рт заасан ажлын биелэлтийг хангах зорилгоор Монгол улсын Үндэсний Архивын сан хөмрөгийн хадгаламжийн нэгжүүдээс Хан Хэнтий уулын тахилга, тайлгатай холбогдох баримтуудыг илрүүлэн, цулгуулж, цахим сан бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Эл ажлын үр дүнд судалгаанд хамааралтай 25 хадгаламжийн нэгжийн баримтуудаас 1347 нүүр нугалбаруудыг сканераар хуулбарлан авч цахим сан бүрдүүлэв. Эдгээр баримтуудын гарчиг, хөмрөгийн дугаар, холбогдох он цагийг багтаасан хүснэгт үйлдэж тайланд оруулав. Нэгэнт цахим сан бүрдсэн тул хэвлэмэл тайлан эмхэтгэлд цөөн тооны баримтыг жишээ болгон оруулсан. Эдгээр баримтууд зарим сонирхолтой баримтуудыг дурдвал: 1779 онд хамаарах “Захих бичиг” нэртэй нэгэн баримтыг дурдаж болно. МУУТА.ТБА.М-32.Д-2.ХН-915.Н-1-д хадгалагдаж буй “Да Сэцэн ханы бичиг”-т:

#### **ЗАХИХ БИЧИГ<sup>34</sup>**

*Да Сэцэн ханы бичиг.*

*Жанжин хэбэй бэйл танаа захив. Явуулах учир. Мөнөөхөн амбан танаас,*

*Жанжин да нар манай нэр хамт захир ирсэн нь Сэцэн хан, Жанжин бэйл ахай дэд да ван түүний амрыг лавлаж захих нь.*

*Эдүгээ миний санаанд болвоос, Хан Хэнтий уул чухам манай дээд Чингис богд үүд нээсэн орон, маш өндөр их буян хишиг бүрдсэн гайхамшигтай хайрхан мөн болоод эртнээс манай Өндөр гэгээн (1635-1723) , дээд ноёноос нааш цөм залбиран тахиж тахисаар ирэв.*

*Иймийн тул одоо Богд эзэнд айлтгаад жил бүр нэгэн удаа албын тахилга олгоод манай хоёр аймаг, шавь нар бүгдээр залбиран тахиж байваас Хан Хэнтий хайрханы хишиг ивээлийг үрийн үрд хүртээж өрнөн дэлгэрч ялангуяа одоо цаг цөв болсонд нэн үлэмж зохистой болох болбоос энэ учрыг айлтгавал, Эзэн хаан магад зөвшөөрч айлдмуу. Үүнд эндэх Богд тэнгэр*

<sup>34</sup> МУУТА.ТБА.М-32.Д-2.ХН-915.Н-1.

хайрханы адил сүрэг байгуулахыг байгуул, тус тусын газраас дөрвөн хошуу малаас нэжгээд ес зохисыг үзэж мал сэтэрлэж, айлтгасанд

Зарлиг ёсоор болгоож явуулан, дөчин дөрөвдүгээр<sup>35</sup> (тэнгэрийг тэтгэсэн 1779) оноос эхэлж нэгэн жилд хоёр удаа тахиулав.


Миний санасан санаа энэ хан дүү, бэйл ахай ван дүүд зөвшиж захив. Тэдний газраас баруун аймгийн да ван, шанзудбад зөшилцөж захимуй.

Хан Хэнтий гэгч мөн хоёр аймгийн уулын хан мөн тул нэгэн аймгаар тахиж болохгүй бас чу үүнийг бас мэдэх хэрэгтэй буй хэмээн захир ирсэн ёсоор жанжин хэбэй бэйл, дэд да ван танаа нэгэн адил зөвшин явуулаад уг захисан зүйлийг эрхэмүүдийн газраа тольдон үзээд энэ ёсоор явуулах ба эсхүл хэрхэн болговоос зохих аль нэг нь хянан тогтоож даруй бидний нэр хамт явуулах захианы эхийг тус тус зохиолгож, илгээмү.

Ирснийг үзэж санаа нийлүүлэн явуулья хэмээмүй. Үүний тул захив.

Хорьдугаар он найман сарын хорин есөн

хэмээн өгүүлсэн байдаг. Хан Хэнтий уулын тахлигатай холбогдох хамгийн эртний бичиг бөгөөд Чингис хааны үеэс хүндэтгэн тахиж, Өндөр гэгээн, дээд ноёноос эхлэн тахиж ирсэн гэдгийг баталсан баримт болж байна.



<sup>35</sup> 1779 он.

甲子年  
 乙未年  
 丙申年  
 丁酉年  
 戊戌年  
 己亥年  
 庚子年  
 辛丑年  
 壬寅年  
 癸卯年  
 甲辰年  
 乙巳年  
 丙午年  
 丁未年  
 戊申年  
 己酉年  
 庚戌年  
 辛亥年  
 壬子年  
 癸丑年  
 甲寅年  
 乙卯年  
 丙辰年  
 丁巳年  
 戊午年  
 己未年  
 庚申年  
 辛酉年  
 壬戌年  
 癸亥年

甲子年  
 乙未年  
 丙申年  
 丁酉年  
 戊戌年  
 己亥年  
 庚子年  
 辛丑年  
 壬寅年  
 癸卯年  
 甲辰年  
 乙巳年  
 丙午年  
 丁未年  
 戊申年  
 己酉年  
 庚戌年  
 辛亥年  
 壬子年  
 癸丑年  
 甲寅年  
 乙卯年  
 丙辰年  
 丁巳年  
 戊午年  
 己未年  
 庚申年  
 辛酉年  
 壬戌年  
 癸亥年

Handwritten text in cursive Japanese style (sōsho) on a two-page spread. The text is arranged in vertical columns within a red-lined border. The right page contains approximately 10 columns of text, while the left page contains approximately 8 columns. The ink is dark and the paper shows signs of age and staining.

Handwritten text in cursive Japanese style (sōsho) on a two-page spread. The text is arranged in vertical columns within a red-lined border. The right page contains approximately 10 columns of text, while the left page contains approximately 8 columns. The ink is dark and the paper shows signs of age and staining.

## **Архиваас хуулбарлан авсан баримтын жагсаалт**

Д/Д	ГАРЧИГ	ОН	ХӨМРӨГИЙН ДУГААР
1.	Бадаргуулт төрийн хорин есдүгээр оны зун цаг Хан хэнтий хайрхан уулыг тайгаад баярын ёслолоор наадам бэлэглэхэд бөх оноосон туслагч түшмэд, бичээч, жич, зарлага нарын нэрсийг тодорхойлон жагсаасан нь.	1903 он	М-9-5- 1927.Н-1
2.	Сэцэн хан аймгийн да-аас Хан Хэнтий уулыг цагдуулахад Богд хаан хайрхан, Отгон хайрхан уулуудыг цагдуулаар суулгасан цагдаа нарын адил хорин илүү өрх цэрэг суулгаж хааж дагнах албаны хувиар тэгшлэн шийтгүүлж болох эсэхийг заана уу хэмээн өргөсөн хэрэг.	1915 он	А-3-1-706.Н-1
3.	Сайдаас Хэнтий Хан уул тайх өдрийг хойшлуулж тушаасан хэрэг.	1906 он	М-9-5- 1995.Н-2
4.	Хан Хэнтий уулын цагдаа өрхийг нөгөө хоёр уулын цагдаа цэргийн адил данслан суулгаваас зохих явдлыг дөрвөн аймгийн да жанжины зэрэг зургаан газар явуулан тушаах бичгийн эх.	1915 он	А-3-1-706.Н-2
5.	Бадаргуулт төрийн хорин есдүгээр он илүү таван сард Хан хайрхан, Хэнтий Хан уулсыг тайгаад бэлгэтэй ёсоор наадам үйлдэхэд Сэцэн хан аймгаас сур харваж тэргүүлсэнд цол гуйх нь.	1903 он	М-9-5- 1927.Н-3
6.	Богд хаан хайрхан зэрэг гурван уулсыг хуучин удаагаар таван газар тайлган харвуул наадам үйлдэх зэргийг зөвлөж дөрвөн аймгийн нэр хамт Эрдэнэ шанзудба нарт явуулах бичгийн эх.	1919 он	А-29-1-637.Н- 5
7.	Сэцэн хан аймгийн Да дайчин жонон вангийн бичиг.	1919 он	А-29-1-637.Н- 6
8.	Сайшаалт ерөөлтийн хорин дөрөвдүгээр он зуны дунд сард.	1819 он	М-31-2- 400.Н-16
9.	Сэтэртэн сүргийг захирах туслагч Цэрэнпунцагаас дагалт Цэрэнпилийн адуулсан сүргээс оноосны тоог тодорхойлон өргөсөн хэрэг.	1915 он	А-3-1-683.Н- 18
10.	Дотоод яамнаас энэ жил намар цаг Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсыг тайх сар, өдрийг сонгон үзүүлж, өөр өөрийн аймгаас хэрэгсүүлэх эл зүйлийг бэлтгэн гүйцэтгүүлэх зэрэг учир тушаасан хэрэг.	1914 он	А-29-1-328.Н- 94
11.	Шашныг тэтгэгч Богд хаан хайрхан уул, Хан хэнтий уулсыг тус тус тайхаар тогтсон учир эл хэрэглэх зүйлүүдийг бүрнээ бэлтгэн гүйцэтгүүлж зохих газраа хүргүүлэе гэх зэргээр сайд жанжинд явуулах бичгийн эх	1915 он	А-29-1-388.Н- 98
12.	Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир хуучин удаагаар усчин хүмүүн нарыг сонгон томилж сайд да дайчин жонон ван, дархан гүн Барайширын хошуудад тушаах бичгийн эх.	1915 он	А-29-1-388.Н- 99

- |     |   |         |                  |
|-----|---|---------|------------------|
| 13. | Хан Хэнтий уулыг тайхад хэрэглэх зуламны үхэр, хонийг дархан гүн Барайширын хошуунд ноогдуулж харьяат газраа энэ учир сайд да дайчин жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх.                         | 1915 он | А-29-1-388.Н-100 |
| 14. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир харьяат газарт хадгалуулсан шар асар зэрэг зүйлийг хүргүүлэн бэлтгүүлэхээр дархан гүн Барайширын хошуунд тушаах бичгийн эх.                                     | 1915 он | А-29-1-388.Н-101 |
| 15. | Хан Хэнтий уулын тайлгын газраа эл хэрэгсэх зүйлийг бэлтгэн гүйцэтгэхээр оноосон зүйлийн нэр тоог сийрүүлэн сайд да дайчин жонон ван, дархан гүн Барайшир нарын хошуудад тушаах бичгийн эх.           | 1915 он | А-29-1-388.Н-102 |
| 16. | Дотоод яамнаас энэ жил зун цаг Богд хаан хайрхан, Хан хэнтий уулсыг тайх болзоог тогтоож эл хэрэгсэх зүйлийг хуучин удаагаар нийлүүлэн гүйцэтгүүлэхээр тушаасан хэрэг.                                | 1915 он |                  |
| 17. | Шашныг тэтгэгч Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсыг тус тус тайхаар тогтсон учир эл хэрэгсэх зүйлүүдийг бүрнээ бэлтгэн гүйцэтгүүлж зохих газраа хүргүүлэе гэх зэргээр сайд жанжинд явуулах бичгийн эх | 1915 он | А-29-1-388.Н-2   |
| 18. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир, харьяат газарт хадгалуулсан шар асар зэрэг зүйлийг хүргүүлэн бэлтгүүлэхээр дархан гүн Барайширын хошуунд тушаах бичгийн эх.                                    | 1915 он | А-29-1-388.Н-4   |
| 19. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир хуучин удаагаар усчин хүмүүн нарыг сонгон томилж сайд да дайчин жонон ван, дархан гүн Барайширын хошуудад тушаах бичгийн эх.                                    | 1915 он | А-29-1-388.Н-5   |
| 20. | Хан Хэнтий уулын тайлгын газраа эл хэрэгсэх зүйлийг бэлтгэн гүйцэтгэхээр оноосон зүйлийн нэр тоог сийрүүлэн сайд да дайчин жонон ван, дархан гүн Барайшир нарын хошуудад тушаах бичгийн эх.           | 1915 он | А-29-1-388.Н-6   |
| 21. | Хан Хэнтий уулыг тайхад хэрэглэх зуламны үхэр, хонийг далай дархан гүнгийн Барайширын хошуунд ноогдуулж харьяат газар энэ учир сайд да дайчин жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх.                | 1915 он | А-29-1-388.Н-7   |
| 22. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир тайх сайдыг дагалдан мөргөх түшмэлд сайд да дайчин жонон вангийн хошууны туслагч Гонгоржавыг томилж харьяат газарт тушаах бичгийн эх.                           | 1915 он | А-29-1-388.Н-10  |
| 23. | Хан Хэнтий уулын тайлгад хэрэглэх зулмын үнэд хүргүүлэн ирсэн мөнгийг уул хошууны дутагдалд хураасан учрыг мэдтүгэй хэмээн харьяат далай дархан гүн Барайширын хошуунд тушаах бичгийн эх.             | 1915 он | А-29-1-388.Н-12  |
| 24. | Хан Хэнтий уулыг тайхад хэрэглэх зуламны үхэр, хонийг дархан гүн Барайширын хошуунд ногуулж харьяат газраа энэ учир сайд да дайчин жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх.                           | 1915 он | А-29-1-388.Н-14  |

- |     |   |         |                 |
|-----|---|---------|-----------------|
| 27. | Хан Хэнтий уулын тайлгын газраа хэрэгсэх зүйлийг бэлтгэн гүйцэтгэхээр оноосон зүйлийн нэр тоог сийрүүлэн сайд да дайчин жонон ван, дархан гүн Барайшир нарын хошуудад тушаах бичгийн эх.                    | 1915 он | А-29-1-388.Н-18 |
| 28. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир тайх сайдыг дагалдан мөргөх түшмэлд сайд дайчин жонон вангийн хошууны туслагч Гонгоржавыг томилж, харьяат газарт тушаах бичгийн эх.                                   | 1915 он | А-29-1-388.Н-19 |
| 29. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир хуучин удаагаар усчин хүн нарыг сонгон томилж сайд да дайчин жонон ван, дархан гүн Барайшир нарын хошуудад тушаах бичгийн эх.   | 1915 он | А-29-1-388.Н-20 |
| 30. | Шашныг тэтгэгч Богд хаан хайрхан уул, Хан Хэнтий уулсыг тус тус тайхаар тогтсон учир эл хэрэгсэх зүйлүүдийг бүрнээ бэлтгэн гүйцэтгүүлж зохих газраа хүргүүлэе гэх зэргээр сайд жанжинд явуулах бичгийн эх.  | 1915 он | А-29-1-434.Н-4  |
| 32. | Хан Хэнтий уулыг тайхад хэрэглэх зуламны үхэр, хонийг далай дархан гүнгийн Барайширын хошуунд ногдуулж харьяат газар энэ учир сайд да дайчин жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх.                       | 1915 он | А-29-1-434.Н-10 |
| 33. | Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир, харьяат газарт хадгалуулсан шар асар зэрэг зүйлийг хүргүүлэн бэлтгүүлэхээр дархан гүн Барайширын хошуунд тушаах бичгийн эх.  | 1915 он | А-29-1-434.Н-12 |
| 34. | Аймгийн яамнаас Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсыг тайхад харьяат хошууны харваачин нарт хэрэглэл зүйлийг олгож заасан болзоонд зохих газар хүргүүлэхээр тушаасан хэрэг.                                  | 1924 он | Ф-68-1-20.Н-4   |
| 35. | Бадаргуулт төрийн хорин долдугаар оны зун, намар цаг Хэнтий хан уулын тэнгэр тайхуйн балин тахил ба хэрэглэл зүйлийг шинэтгэн бичсэн нь.  | 1901 он | Ф-72-1-5.Н-1    |
| 36. | Да-гаас Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсын сэтэртэн сүрэг малыг сангийн яам эрхлэх явдлыг айлтгаад ёсоор болгосон учрыг уламжлан мэдэгдэн илгээсэн хэрэг.   | 1921 он | Ф-72-1-38.Н-1   |
| 37. | Олноо өргөгдсөний арван гуравдугаар он есөн сард Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсын сэтэртэн сүргийн тухай эл бичгүүдийг ялган салгаж товъёог данс үйлдэж тодорхойлон тэмдэглэсэн толь.                   | 1922 он | Ф-72-1-127.Н-1  |
| 38. | Дотоод яамнаас Богд хаан, Хан Хэнтий уулсыг энэ есөн сарын хорин хоёронд тайлгах учрыг мэдэгдэн тушаасан хэрэг.   | 1925 он | Ф-72-1-273.Н-12 |
| 39. | Хан Хэнтий уулын тайлгын зүйлүүдийг мөнхүү өдөр цагт зааж тушаасан ёсоор гүйцэтгүүлэхээр Биндэрьяа хан уулын хошуу энэ учир сангийн яамнаа мэдүүлэн тушаах бичгийн эх.                                      | 1926 он | Ф-72-1-336.Н-3  |
| 40. | Хан Хэнтий уулын сэтэртэн сүргээс дутагдуулсаныг нөхөж төлүүлсэн малыг уг тоот өрхийн дотор багтаан адгуулах зэргээр гүйцэтгэн шийтгүүлэхээр Сэцэн хан аймгийн Да-гийн зэрэг хоёр газраа тушаах бичгийн эх. | 1914 он | А-9-3-565.Н-2   |



41.	Хан хэнтий уулын адуулсан сүрэг малыг хар Донойгоос шилжүүлэн оройд хэн нэртэй хүн томилон тушаасныг зүс мэдүүлэн ирүүлэн Сэцэн хан аймгийн Да-д тушаах бичгийн эх.	1915 он	A-3-1-683.H-4
42.	Засагт хан аймгийн жасаанаас Хан хэнтий уулын сүргийг зарлага Цэрэндоржид шилжүүлэн тушааж адуулсан учир нэр сольж олгуулмуй хэмээн уул бичиг өгүүлэн өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-5
43.	Дотоод яамнаас гадаадын зэрэг дөрвөн яамнаа хуудас дагуулан зөвлөн явуулах учир эдүгээ Дарьганга, Цагаанбулаг өртөөний занги Бат-Очир баруун, зүүн хоёр гар тэмээн сүрэг адууны дарга Ядамсүрэнгийн зэрэг хэдэн хүн нараас харьяат дөрвөн гарын сарнин дарагч ирсэн захирах сахих хүн үгүй	1915 он	A-3-1-683.H-6
44.	Өргөх бичиг.	1915 он	A-3-1-683.H-7
45.	Сэцэн хан аймгийн Да-гаас захирагч Цолмонд адуулсан сүргийг хэвээр адуулсан учрыг гаргаж өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-8
48.	Хэнтийн сүргийг ерөнхийлөн захирах гүн Мишигдоржоос харьяат сүргийг адуулсан хуяг Цагаанхүү цагийн гачиг эмгэг зүйлд эцэж туйлдсан адуу тавыг арилжаалан худалсан нь нийлэлцэх өгөхийг заахыг ирж өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-12
55.	Хан Хэнтийн сүргийг захирах гүн Мишигдоржоос харьяат аймгийн түшмэл ардад адуулсан сүрэг малаас цагийн гачигт унасан хорсны нас зүсмийг тодорхойлж өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-20
57.	Сэцэн хан аймгийн Да-аас хар Донойд адуулсан хан Хэнтийн сүргийг шилжүүлэн түшмэл Дагмид-Очирт тушааж адуулав хэмээн мэдүүлсэн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-22
58.	Хан Хэнтийн ачигдсан сүргийг дор бүр арилжаалсан нь нийлэлцэн өгөх учрыг мөн сүргийг захирах гүн Мишигдоржийн зэрэг хоёр газар тушаах бичгийн эх.	1915 он	A-3-1-683.H-23
59.	Түшмэл Цолмонд адуулсан сэтэртэн сүргийг шилжүүлэх өгөхийг түүгээр гүйцэтгэн шийтгэж мэдүүлэн ирүүлэхээр Сэцэн хан аймгийн Да-д тушаах эх.	1915 он	A-3-1-683.H-24
60.	Сайн ноён хан аймгийн жасаанаас тус аймагт адуулсан сэтэртэн сүргийн нэгэн өрхийн албыг хуяг Дүнгүд дагасаар адуулваас болох эсэхийг заамуу хэмээн өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-25
61.	Сэцэн хан аймгийн Да-аас хар Донойн адуулан буй Хан Хэнтий уулын сүргийг шилжүүлэн адуулваас болмуй хэмээн өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-26
63.	Сэцэн хан аймгийн чуулганы даргаас Хан Хэнтий уулын сүрэг адуулах харьяат аймгийн Ахай Бэйсийн хошууны хуяг Шараваас уул сүргийг шилжүүлэн дагалт Дамдинсүрэнд адуулсан учрыг уламжлан мэдүүлсэн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-28

65.	Сэцэн Хан аймгийн чуулганы даргаас харьяат аймгийн сэцэн ван Гомбосүрэнгийн хошуунаас Богд Хаан хайрхан уулын сэтэртэн сүргийг адуулах хуяг Гомбо нарын сүргийг шилжүүлж мөн хошууны Цэсүнжавд адуулахыг ирж мэдүүлсэн хэрэг.	1915 он	A-3-1-683.H-30
66.	Зарлигт холбогдсон чухал яаралтай албан тушаалдах аваас сэтэртэн сүргээс нийлүүлэхэд үл болох газар үгүй явдлыг харьяат захирал гүн Мишигдоржийн зэрэг түр газар тушаах бичгийн эх.	1915 он	A-3-1-683.H-31
67.	Санд хураалгах хонийг харьяат таван гараас нийгэмчлэн гаргуулснаас үхэр хонин сүргийн нэгэн гарыг илүү чирэгдүүлсэн газар үгүй хэмээн зохих газраас тодорхойлон мэдүүлсэн явдлыг сайд бэйс Магсаржавт мэдэгдэн явуулах эх.	1915 он	A-3-1-683.H-32
69.	Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамны бичиг.	1915 он	A-3-1-683.H-34
	<b>СЭЦЭН ХАН АЙМГИЙН ЧУУЛГАН ДАРГЫН ЖАСААНЫ ХӨМРӨГ</b>		A-29
70.	Өргөх бичиг.	1914 он	A-29-1-328.H-1
71.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-2
72.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-4
73.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-7
74.	Өөр өөрийн нутгийн доторх эрхэм сүлд тахилга уул усны нэр зэргийг тодорхойлон цэс үйлдэж мэдүүлэн ирүүлээр олон засаг хошуу, сайд Егүзэр Хутагтын Шанзудба нарт явуулан тушаах бичгийн эх.	1914 он	A-29-1-328.H-10
75.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-11
76.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-13
77.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-15
78.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-18
79.	Баатар гүн Лхамын хошуунаас сүлд тахилга бүхий онгон дархан уулсын нэрсийг цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-21
80.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-22
81.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-25

82.	Сайд Да Эрдэнэ далай вангийн хошуунаас тус нутгийн доторх эрхэм тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-27
83.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-28
84.	Зоригт гүн Мишигдоржийн хошуунаас харьяат нутгийн доторх онгон дархан уул усны нэр тоог тодорхойлсон цэс нэгэн хувийг үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-31
85.	Мөнгөн Дэлгэр Өлзийт Баясгалант талд Улаан Өндөр, Баян хааны баруун талын толгой, зүүн талын толгой, Ухаа богд, Цагаан өндөр, Талын толгой, Дашманг гурван өндөр	1914 он	A-29-1-328.H-20
86.	Тодорхойлсон цэс нэгэн хувийг үйлдэж бичгийн дугтуйд агуулж өргөн хүргүүлсэн явдлыг үйлдвээс сайд чуулганы дарга Эрдэнэ далай ван танаа өргөн мэдүүлсүгэй. Үүний тул өргөв.	1914 он	A-29-1-328.H-32
87.	Сайд Соёнт гүнгийн хошуунаас онгон дархан уулсын нэрсийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-33
88.	Үнэн сүжигт ван Доржпалам нараас харьяат хошууны нутгийн доторх эрхэм тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-34
89.	Хошой Чин вангийн хошуунаас эрхэм сүлд тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлсон цэс нэг хувийг үйлдэж хүргүүлэв. Хэмээн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-35
90.	Эрдэнэ гүн Пунцагдэжидийн хошуунаас харьяат хошууны сүлд тахилга бүхий онгон дархан уул овоо усны нэр тоо зэргийг тодорхойлон цэс үйлдэж хүргүүлэв. Хэмээн дөрвөн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-36
91.	Чин ван Гомбосүрэн нараас харьяат хошууны доторх сүлд тахилга бүхий уул овооны нэрийг тодорхойлж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-37
92.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-38
93.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-40
94.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-42
95.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-45
96.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-48
97.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-51
98.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-53

99.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-56
100.	Эрх гүн Лувсанюндэнагваанпэлжээдашцэрэн агсны харьяат хошууны эрхэм сүлд тахилга бүхий уул усыг тодорхойлон цэс үйлдэж хүргүүлэн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-58
101.	Сайд Егүзүр хутагтын Шанзудба Чойжингоос эрхэм сүлд тахилга бүхий уул овооны нэр тоог тодорхойлсон цэс нэг хувийг үйлдэж хүргүүлэв хэмээн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-59
102.	Ёст гүн Доржжав нараас харьяат хошууны эрхэм сүлд тахилга бүхий онгон дархан уул овоо усны нэр тоо зэргийг тодорхойлон цэс үйлдэж хүргүүлэв хэмээн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-60
103.	Сайд Эрдэнэ Жонон вангийн хошуунаас онгон дархан уул овооны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-61
104.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-62
105.	Сайд эрхэмсэг Бэйлийн хошуунаас тус хошууны доторх эрхэм тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-65
106.	Сайд Жанжин Бэйлийн хошуунаас харьяат хошууны доторх эрхэм сүлд тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-66
107.	Сайд сэцэн ханы хошуунаас онгон дархан уул овоо усны нэр зэргийг тодорхойлж цэс үйлдэж илгээсэн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-67
108.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-68
109.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-70
110.	Дархан гүн Барайширын хошуунаас тус нутгийн дотор буй эрхэм тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цус үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-73
111.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-74
112.	Саруул гүн Дамдинжавын хошуунаас тус нутгийн доторх эрхэм сүлд тахилга бүхий овоо усны нэр тоог тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-78

113.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-79
114.	Өргөх цэс.	1914 он	A-29-1-328.H-84
115.	Сэргэлэн гүн Дугарсүрэнгийн хошуунаас харьяат хошууны эрхэм сүлд тахилга бүхий онгон дархан уул овоо усны нэр тоо зэргийг тодорхойлон цэс үйлдэж хүргүүлэв. Хэмээн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-88
116.	Ахай Бэйс Нармандах нараас онгон дархан уул овоо усны нэр зэргийг тодорхойлж цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-89
117.	Дайчин Бэйс Дашцэрэн нараас тус нутгийн доторх эрхэм тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-90
118.	Хурц Бэйс Дүдэлийн хошуунаас эрхэм сүлд тахилга бүхий уул усны зэрэг газрын нэр тоог тодорхойлсон цэс нэг хувийг үйлдэж хүргүүлэв. Хэмээн өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-91
119.	Үйзэн Бэйс Гомбосүрэнгийн хошуунаас тус нутгийн доторх эрхэм тахилга бүхий уул усны нэр тоог тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-92
120.	Чин Ачит Бэйс Сансарайдорж нараас харьяат хошууны доторх эрхэм сүлд тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-93
121.	Их Богд Хаан хайрхан уулыг дээр удаах сайдыг дагалдан мөргөхөд Далай дархан гүн Барайширыг томилж энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх.	1914 он	A-29-1-328.H-95
122.	Далай дархан гүн Барайширын хошуунаас Богд Хаан хайрхан уулыг тайх сайдыг дагалдан мөргөх албан томилогдсон харьяат засаг гүн Барайширын бичиг лугаа зөрөлдөн нутагт ирсэн учрыг гаргаж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-96
123.	Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир тайх сайдыг дагалдан мөргөх түшмэлд дархан гүн Барайширын хошууны туслагч Гэмпэлдэндэвийг томилж харьяат газарт тушаах бичгийн эх.	1914 он	A-29-1-328.H-97
124.	Их Богд Хаан хайрхан уулыг тайхаар тогтсон учир жагсаан явуулах дагалт хүн дөрвийг сэцэн Чин ван Гомбосүрэнгийн хошуунаас мордуулахаар харьяат газар энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх.	1914 он	A-29-1-328.H-102

125.	Хан хайрхан, Хан Хэнтий уулсыг тайхаар одох сайд лам нар, түшмэд, бичээчин нарын улаа ба мөн уулсын сэтэртэн сүргүүдийг тухай бүрийн заасан болзоо тус тус бэлтгэн нийлүүлэхээр зоригт гүн Мишигдоржид тушаах бичгийн эх.	1914 он	A-29-1-328.H-104
126.	Мэргэн засаг Цэрэнвандувбудоржийн хошуунаас эрхэм тахилга бүхий уул усны нэрийг тодорхойлон цэс үйлдэж өргөсөн хэрэг.	1914 он	A-29-1-328.H-105
127.	Богд хаан хайрхан уулын цагдааг захирах занги Гомбоос Бэйс Батсуурийн хошуунд оноосон Ихбулагийн амны цагдаагийн албан хаах лам Лувсанбалдан уул албыг Их шавь шүхэрч лам Дашдэндэвээр төлөг хаалгасан учрыг гаргаж өргөсөн хэрэг.	1915 он	A-3-1-706.H-3
128.	Хамаарсан жанжин Сэцэн Чин вангаас Богд Хаан хайрхан, Хан Хэнтий уулсыг тайх ялдар түшмэл цэргүүдийг хуралдуулж бөмбөг намгуулан сур харвуулах зохих газруудад тушаасан нь мэдэгдэж илгээсэн хэрэг.	1919 он	A-29-1-637.H-1
129.	Эрх Гүн Пунцагдалайнамжил нараас Дарьганга дахь Дарь овоог тайлгах сайд түшмэд дагагсад бүрэн хэрэгссэн зүйлүүдийг хоёр сийрүүлэн дээшлүүлэхийг эрж өргөсөн хэрэг.	1919 он	A-29-1-637.H-2
130.	Сайд Да Жонон Вангийн хошуунаас харьяат хошууны ядуурсан байдал учрыг гаргаж онох болон гаргуулах Хан Хэнтий уулын хоёр удаагийн тайлгын эл хэрэглэлийг шилжүүлэн өршөөхийг гуйж өргөсөн хэрэг.	1919 он	A-29-1-637.H-3
131.	Эрдэнэ ялгуулсан хутагтын Шанзудба Навааншараваас Богд Хаан хайрханы зэрэг уулсын наадам тухайд харьяат шавьд унасан бөхийг уг болзоог хүрч чадах үгүй болсон учрыг гаргаж заахыг эрж өргөсөн хэрэг.	1919 он	A-29-1-637.H-4
132.	Өргөх бичиг. (Хан уулын чуулганы дарга Чин ван Цэдэндорж дэд чуулганы дарга түшээ гүн Сономванчингийн бичиг.)	1819 он	M-1-1-3675.H-6
133.	Өргөх бичиг. (Хан уулын чуулганы дарга Чин ван Цэдэндорж дэд чуулганы дарга түшээ гүн Сономванчингийн бичиг.)	1819 он	M-1-1-3675.H-20
134.	Өргөх бичиг. (Хэрлэний барс хотын чуулганы дарга халхын Сэцэн хан Ардсэд дэд чуулганы дарга ван Бат-Очирын бичиг.)	1819 он	M-1-1-3675.H-24
135.	Өргөх бичиг. (Шашныг мандуулах амьтныг жаргуулагч Жавзундамба ламын хүрээний хэргийг шийтгэх шавь нарыг бүгд захирагч Эрдэнэ Шанзудба Гомбожав)	1819 он	M-1-1-3675.H-25

136.	Өргөх бичиг. (Сэцэн хан аймгийн Орос зүгийн харуулыг захирах засгийн тэргүүн зэрэг тайж нэг зэрэг нэмсэн хоёр зэрэг тэмдэглэсэн Цэмпэлдоржийн бичиг.)	1819 он	M-1-1-3675.H-26
137.	Өргөх бичиг. (Хан уулын чуулганы дарга Чин ван Цэдэндорж чуулганы дэд дарга Түшээ гүн Содномванчингийн бичиг.)	1819 он	M-1-1-3675.H-30
138.	Өргөх бичиг. (Сэцэн хан аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж Цэдэнгаравийн бичиг.)	1821 он	M-1-1-3743.H.1
139.	Төр Гэрэлтийн арван наймдугаар он хавар цаг хуваан зарласан мөнөөх данс.	1830 он	M-31-1-511
140.	Зарлигаар зарсан хүрээнд сууж тэргүүлэн хэрэг шийтгэгч сайд шадарт явах халхын засгийн төрийн Жүн ван төрийн эфү, туслан хэрэг шийтгэгч сайд, тэргүүн зэрэг Хиа таны бичиг.	1819 он	M-1-1-3675.H-56
141.	Өргөх бичиг. (Хан уулын чуулганы дарга Чин ван Цэдэндорж халхын зүүн гарын цэргийг захирах туслагч жанжин Түшээт хан Ойдовдорж, дэд чуулганы дарга түшээ гүн Сономванчигийг бичиг.)	1818 он	M-1-1-3675.H-71
142.	Өргөх бичиг. (Сэцэн ван аймгийн засгийн тэргүүн зэрэг тайж нэгэн зэрэг нэмсэн Цэмпэлжавын бичиг.)	1819 он	M-1-1-3675.H-72
143.	Ван Одсэрбазар нарын таван хошуу суурин жасаанд Хэнтий хан уулын тэнгэрийг тайхын элдэв хэрэглэх зүйлийг гүйтэтгүүлэн зарлан тушаасан эх.	1895	M-9-5-1759.H-1
144.	Сайд Түшээт хан нарын арван хошуу суурин жасаанд тайлгын наадмын бүх харваачныг оноолон зарлаж дагаж гүйцэтгүүлэх ван түшмэдийг томилон жич хэрэглэгдэх данс бичгийг хүргүүлэн тушаасан эх.	1895 он	M-9-5-1759.H-3
145.	Ван Одсэрбазар нарын гурван хошуу сэтэртэн сүрэг захирах тэргүүн Түндэв суурин жасаанд Хан уулыг тайхад элдэв хэрэгсэх зүйлийг оноолон хувааж гүйцэтгэн бэлтгүүлэхээр тушаасан эх.	1895 он	M-9-5-1759.H-9
146.	Бадаргуулт төрийн гучин хоёрдугаар он гурван сарын арван тавны өлзий учрал бүрдсэн сайн өдөр.	1906 он	M-9-5-1995.H-1

147.	Сайдаас Хан уул тайх өдрийг хойшлуулж тушаасан хэрэг.	1906 он	M-9-5-1995.H-3
148.	Суурин жасаанаас гүн Батсуурийн хошуунаас Чингисийн бадранд хүргүүлсэн мөнгийг хэн нэртэй хүнд өгсөн данс тэмдэг олоход үгүй учир гаргаж мэдүүлсэн хэрэг.	1906 он	M-9-5-2003.H-1
149.	Сайд ван сайдын газраас Хан хайрхан уулын тэнгэрт сэтэрлэж өргөсөн малыг байцаахад өдөр гуядуулсан дээр түүний бие өвдөв хэмээн эс ирсэн засаг Цэмбэлжавыг байцаан шийтгээд хэрхэн шийтгэснийг хариу мэдүүлэн өргөлөө хэмээн тушаасан хэрэг. Өргөх бичиг. (Засаг Цэмбэлжавын газраас Хан хайрхан уулын сэтэрт малыг байцаахад эс очвой хэмээсэн засаг Цэмбэлжав өдөр тушаасан уг бичиг есөн сарын арван есөнд хүрч ирсэн боловч хүлээн авсан цагт мөрдвөөс зохих Бэйлийн гагцхүү гэрт хуучин өвчин үгдэрээд яван чадсангүй хэмээн мэдүүлсэн хэрэг.)	1819 он	M-31-2-400.H-1
150.	Жасаанаас гүн Ихэд илгээв.	1819 он	M-31-2-400.H-2
151.	Гүн Самандбадралын тамгын түшмэдээс Хэнтий хан уулыг тайхад бүгдээр баярлалдан сүслэж тэнгэрийн хишиг мөргөсөн явдлыг өргөв хэмээсэн хэрэг.	1819 он	M-31-2-400.H-3
152.	Да танаа өргөв. Мэдүүлэхийн учир энэ намар цаг Хэнтий хан уулын тайлгын хэрэглэлд бэлтгэж ирсэн улааны морьд ба тэмээ ологч хүн майхан зэргээс бага хассан боловч.	1819 он	M-31-2-400.H-4
153.	Хорин дөрөвдүгээр он зуны цаг Хан уул тайхад шавиас амбан ван эфү танд.	1819 он	M-31-2-400.H-5
154.	Дэд Да вангийн зэрэг есөн хошуунд тушаан илгээв. Явуулахын учир энэ зургаан сарын хорин найманд хүрээнд суух хэрэг	1819 он	M-31-2-400.H-6
155.	Хэрлэний Барс хотын чуулганы даргын тамгыг түр хамаарсан дэд чуулганы дарга засгийн төрийн Жүн ван таны дэргэдэх жасааны мээрэн Шажиний бичиг.	1819 он	M-31-2-400.H-7
156.	Хүрээн дэх Да Цэцэн хан аймгийн жасаанд суусан тайж Цэрэнжавын бичиг.	1819 он	M-31-2-400.H-8
157.	Дархадыг захирах засаг танаа өргөн илгээв.	1819 он	M-31-2-400.H-9



158.	Гүн Сэнгэдорж, засаг Гомбожав, засаг Цэрэндаш, Цэмбилжав нарт тушаан илгээв.	1819 он	M-31-2-400.H-10
159.	Да Сэцэн хан, засаг Пунцагдорж нарын тамга засаг Дамдинцэрэн нарт тушаан илгээв.	1819 он	M-31-2-400.H-11
160.	Жасаанаас хүрээний жасааны тайж Цэрэнжавд илгээв.	1819 он	M-31-2-400.H-12
161.	Хан уулын овооны сүмд хэрэглэх модыг ачиж гаргах арван таван тэмээ ...	1819 он	M-31-2-400.H-13
162.	Хорин дөрөвдүгээр он зуны тэргүүн сард хуваан зарласан энэ зуны цаг Хан уулыг тайхад хэрэглэх юм зүйлийг хуучин ёсоор эхлээ оноосон Да Сэцэн ханы зэрэг арван нэгэн засаг хошуунд хуваан зарласан данс энэ.	1819 он	M-31-2-400.H-14
163.	Да Сэцэн хан Хэбэй Чин ван Бэйс бун гүн Сэнгэдорж, гүн Цэдэн, засаг Цэдэв, Цэрэндаш, Гомбо, Цамба, Пунцаг нарт тушаан илгээв.	1819 он	M-31-2-400.H-15
164.	Засаг Цэмпилжавд тушаан илгээв.	1819 он	M-31-2-400.H-20
165.	Хүрээний сайдуудын газраас Хэнтий хан ууланд сэтэрлэж өргөсөн малыг адуулах өрхийн хуяг гурвыг харьяат аймгийн шавь Чин Нэжигүнээр гаргуулж эдүгээгээс даруй засаг Цэмбэлжавын газар илгээгээд сэтэрлэсэн малыг адуулахаас гадна цагдаа суулгасан ардыг засаг Цэмбэлжавд тушааж захирах хэмээн тушаасан хэрэг.	1819 он	M-31-2-400.H-21
166.	Сайд ван сайдын газраас Хэнтий хан ууланд сэтэрлэж өргөсөн малыг засаг Цэмбэлжаваар захиргая хэмээснийг уламжлан зарлаж ирсэн хэрэг.	1819 он	M-31-2-400.H-23
167.	Сангийн яамнаас зүүн баруун ангийн үржүүлэх тэмээнээс унаж дутсан тэмээдийг зохисыг үзэн тоо хорогдуулж үнэ бодож уул адгуулагсдаас гаргуулан ирүүлэхээр зохих газар тушаагаад мэдэгдэн өргөсөн хэрэг.	1914 он	A-3-1-565.H-1
168.	Сэтэртэн сүргийг захирах гүн Мишигдоржоос Чин ван Гомбосүрэнгийн хошуунаас төлбөрт хураасан үхэр хоньдийг сүрэг малыг байцаасан түшмэлийн тушааснаар өрхийн хүн нэмэх эсэхийг заамуу хэмээн өргөсөн хэрэг.	1914 он	A-3-1-565.H-3

169. Сэцэн хан аймгийн Да-аас захирагч Цолмонд адгуулсан сэтэртэн сүргийг шилжүүлэн адгуулахыг эрж өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-5
170. Сангийн яамнаас дөрвөн аймагт хадгалан үржүүлсэн хонийг тодорхойлон исэргэн жил мэдүүлэхээр болзоолон зохих газруудад тушаагаад мэдэгдэн өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-6
171. Хан Хэнтий уулын сэтэртэн мал адгуулагчдаас энэ жилийн хураах зүйлийг түргэн гаргуулж ирүүлэхээр харьяат захиралд тушаах бичгийн эх. 1914 он А-3-1-565.Н-7
172. Баруун замын шархөв зэрэг өртөөдийг захирах туслагч Сэрээтэрээс дээдийн сүрэг адууг байцаан тоолохоор гаргасан сайд түшмэдийн гэр зүйлийг нийслэл хүрээнээ хүргэх тушаалыг хэрэгссэн үгүй тасалдуулав хэмээсэн нэр бүхий улаач нарыг байцааж тэдний мэдүүлэхийг сийрүүлэн өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-8
173. Хан Хэнтий уулын сүргийн малаас тоо дутагдуулан буй ба арилжаалан худалдаж авсан малын өрийг зохигчдоос хүнс төлүүлэхээр Сэцэн хан аймгийн Да-ын зэрэг хоёр газар тушаах бичгийн эх. 1914 он А-3-1-565.Н-9
174. Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулуудын сэтэртэн сүргийн захирал туслагч Цэрэнпунцагаас тус сүргийн унасны нас зүсийг ялган салгаж арьс ширний тоог тодорхойлон өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-10
175. Дотоод яамнаас Богд хаан хайрхан уулын сэтэртэн сүргийг байцаан тоолохоор түшмэл Цэмбэлцэгмэдэд тушаах учир эдүгээ харьяат түшмэлээс эл малаас урьд хожид тогтоосон дүрмийн дотор оноож тайлах тоо чухам алин болохыг лавлан мэдүүлэхээр... 1914 он А-3-1-565.Н-11
176. Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулын сэтэртэн сүргийн захирал гүн Мишигдоржоос тус сүргийг адгуулагчид эмхэглэсэн эцсэнийг арилжаалан худалдсан болохыг заамуу хэмээн өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-12
177. Өргөх цэсэн. 1914 он А-3-1-565.Н-13
178. Бүгд ерөнхийлөн захирах яамнаас Дарьгангын хонин сүргийн хошуу албан элдэвд мөшгөгдөн буй хэмээх зэрэг учир гаргаж хамгаалан тэнхрүүлэхийг ирсэн хэргийг түүгээр гүйцэтгэн шийтгэмүү хэмээн өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-14
179. Дарьгангын бүгдийн тэргүүн ван Цэвэгжаваас санд хураалгах хонийг харьяат таван гараас нийгэмчлэн гаргуулснаас үхэр, хонин сүргийн нэгэн гарыг илүү чирэгдүүлсэн газар үгүй хэмээн зэрэг өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-15

180.	Сэтэртэн сүрэг малыг захирах гүн Мишигдоржоос хуяг Гомбонэрэнд түр тулгаж адуулсан малуудаас эмгэг үгүйг нь харьяат ойрын хуягуудад хуваан адгуулсан ба он тулгах үгүйд хүрснийг нь үнэ тооцоолон ор нөхүүлэхээр бусдад арилжаалсан зэрэг учрыг гаргаж гүйцэтгэн шийтгэхийг эрж өргөсөн хэрэг.	1914 он	A-3-1-565.H-16
181.	Дотоод яамнаас Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсын сэтэртэн сүргийг захирах Зоригт гүн Мишигдоржид хуудсаар тушаав...	1914 он	A-3-1-565.H-17
182.	Түшээт хан аймгийн Зоригт чин ван Цэрэнбаавай хуудсаар дотоод яамнаа өргөв мэдүүлэх учир эдүгээ өчүүхэн миний биед хуучин оршсон өвчин бүхий нь төлөв эдгэсэн боловч ...	1914 он	A-3-1-565.H-18
183.	Нийслэл хүрээн дэх Сайн ноён хан амйгийн жасааны хэргийг шийтгэх гүн түшмэдээс дотоод яамнаа хуудас бичгээр өргөн мэдүүлэх учир...	1914 он	A-3-1-565.H-19
184.	Тушаалаар гаргасан түшмэл зайсан Содов нарын бичгийг дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөв.	1914 он	A-3-1-565.H-20
185.	Дотоод яамнаас Хан Хэнтий уулын сэтэртэн сүрэг малыг байцаан тоолохоор гаргасан түшмэл зайсан Содов нарын бичиг.	1914 он	A-3-1-565.H-21
186.	Дотоод яамнаас Хан Хэнтий уулын сэтэртэн сүрэг малыг байцаан тоолохоор гаргасан түшмэл зайсан Содов нарын бичиг.	1914 он	A-3-1-565.H-22
187.	Тушаалаар гаргасан түшмэл зайсан Содовын бичиг.	1914 он	A-3-1-565.H-23
188.	Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулын сэтэртэн сүргийг захирах туслагч Цэрэнпунцагаас тус захирах сүргээс унасны зүс шүдийг тодорхойлж арьс турсаганы тоог жагсаан базаж өргөсөн хэрэг.	1914 он	A-3-1-565.H-24
189.	Тушаалаар гаргасан түшмэл Цэмбэлжигмэд нар хичээнгүйлэн дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа өргөв...	1914 он	A-3-1-565.H-25

190. Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулын сэтэртэн сүргийг захирах гүн Мишигдоржоос тус захирах сүргүүдээс унасан хорогдсон зэргийг ялган салгаж жагсаан базаж өргөсөн хэрэг. 1914 он А-3-1-565.Н-26
191. Их Богд хаан хайрхан уулыг тайхаар одох сайдыг дагалдан мөргөхөд Үйзэн бэйс Гомбосүрэнг томилж энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-3
192. Хан хайрхан, Хан Хэнтий уулсыг тайхаар одох сайд лам нар, түшмэд, бичээч нарын улаа ба мөн уулсын сэтэртэн сүргүүдийг тухай бүрийн заасан болзоонд тус тус бэлтгэн нийлүүлэхээр Зоригт гүн Мишигдоржид тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-8
193. Их Богд хаан хайрхан уулыг тайхаар тогтсон учир жагсан явах дагалт хүн дөрвийг Сэцэн чин ван Гомбосүрэнгийн хошуунаас мордуулахаар харьяат газар энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-9
194. Богд уулсын наадамд барилдах бөхчүүд засуулаас харьяат аймагт унасан нь хувааж сайд Сэцэн ханы зэрэг арван нэгэн хошуу Эрдэнэ ялгуусан хутагтын шавь нар учир сайд жанжинд тус тус явуулан тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-11
195. Өгөөмөр, Түргэн хоёр газрыг тайхад хэрэгсэх зүйлийг урьд нэгэнт тогтсоноос өөрчлөх үгүй хэмээн дотоод яамнаас зохих газар тушаагаад мэдэгдэн тушаасныг уламжлан сайд жанжинд явуулах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-13
196. Дотоод яамнаас Их Богд хаан хайрхан, Хан Хэнтий уулсыг тайх өдөр цагийг үзүүлж тогтоон тушаасан хэрэг. 1915 он А-29-1-388.Н-17
197. Их Богд хаан хайрхан уулыг тайхаар одох сайдыг дагалдаан мөргөхөд Ёст гүн Доржжавыг томилж энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-21
198. Хан Хэнтий уулыг тайхаар тогтсон учир, харьяат газарт хадгалуулсан шар асар зэрэг зүйлийг хүргүүлэн бэлтгүүлэхээр Далай дархан гүн Барайширын хошуунд тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-22
199. Их Богд хаан хайрхан уулыг тайхаар тогтсон учир, жагсан явах дагалт хүн дөрвийг мордуулахаар Сэцэн чин ван Гомбосүрэнгийн хошуу энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1915 он А-29-1-388.Н-25
200. Захирал туслагч Сүрэнжаваас харьяат Баянзүрх өртөө нутгаар гачигдсан ба албан үлэмжит чармайгдсан учир, Өгөөмөр булгийг тайхаар одогчдын улаа зэргийг залгамжилж чадах үгүй болсон зэрэг учир гаргаж жанжны тушаал хэмжээлж өргөсөн хэрэг. 1916 он А-29-1-434.Н-1

201. Зочдын уяаг сэтэртэн сүргээс Өгөөмөр, Түргэн хоёр газрын тайлгын улааг түмтээс тус тус данслуулахаар тогтоосон учир сайд жанжин Ван басхүү албан малын өрх оноосон Сайд да дайчин жонон чин вангийн зэрэг таван хошуунд чвуулан тушаах бичгийн эх. 1916 он А-29-1-434.Н-2
202. Далай ван Намсрайжавын хошуунаас тус хошууны гүн Ганцэрэнгийн насан буурай болсон учир даншигийн их ёслолд ирж чадах үгүй учрыг гаргаж өргөсөн хэрэг. 1916 он А-29-1-434.Н-3
203. Дотоод яамнаас Хан хайрханы зэрэг хоёр уулын тайлганы хэрэглэл зүйлийг харьяат дөрвөн аймгийн дотор тэгшитгэн мэдүүлэхээр жанжны тушаал хамталж тушаасан хэрэг. 1916 он А-29-1-434.Н-5
204. Өгөөмөр, Түргэн хоёр булгийн тайлгын улаа зүйлийг нийлүүлж чадах үгүй учрыг дахин мэдүүлвээс ямар хэмээн зөвлөж хэрвээ зүйтэй хэмээвэл мэдүүлэх бичгийн эх зохиолгон ёсчлон бичүүлж гүйцэтгээд хойш илүүлмүй хэмээн уг ирсэн бичгийг хүргүүлээд сайд жанжинд зөвлөн явуулах бичгийн эх. 1916 он А-29-1-434.Н-7
205. Эрх засаг Пунцагдалайнамжил нараас дотоод яамнаас тушаасан нь дагаж зарлигаар Дарь овоог тайлгахад томилогдон барьсан засаг тамгыг туслагч Дугаржавд хамруулан мөнхүү хүлээн авбаас хэрэг шийтгэсэн учрыг гаргаж өргөсөн хэрэг. 1916 он А-29-1-434.Н-8
206. Зоригт бэйс Мишигдоржийн хошуунд удаа дараа унасан Хан Хэнтий уулын тайлгын хэрэглэлээс тасалдсан нь төлөө гүйцэтгэсэн сайд Да жонон вангийн хошууны нэр агчдад уг төлөө гүйцэтгэсний орыг гаргаж олгуулахаар Зоригт бэйс Мишигдорж энэ учир сайд Да жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх. 1916 он А-29-1-434.Н-9
207. Сайд хамаарсан жанжин Да-аас харьяат захирах сэтэртэн сүргээс зочдод уях уянгыг энэ завсар цаг улиралын тооны бичиг хүлээн авсан учир дахин нугалан зарлаж гүйцэтгэх зэрэг учир тушаасан хэрэг. 1916 он А-29-1-434.Н-11
208. Их Богд хаан хайрхан уулыг тайхаар одох сайдыг дагалдан мөргөхөд Далай дархан гүн Барайшир томилж энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1916 он А-29-1-434.Н-13
209. Их Богд хаан хайрхан уулыг тайхаар тогтсон учир жагсан явах дагалт хүн дөрвийг Сэцэн чин ван Гомбосүрэнгийн хошуунаас мордуулахаар харьяат газар энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1916 он А-29-1-434.Н-14



210. Дотоод яамнаас Их Богд хаан хайрханы зэрэг гурван уулыг тайлгах сар өдрийг сонгон үзүүлж тайлгын эл хэрэглэлийг хуучин удаагаар гаргуулж гүйцэтгэн бэлтгүүлье хэмээх зэргээр тушаасан хэрэг. 1916 он А-29-1-434.Н-15
211. Эрх засаг Пунцагдалайнамжил нараас зарлигийг дагаж овоо тайлгахаар мордоход тайлгын газар туслагч Чалхаажавын хамаарсан хүлээн авч хамаарсан учир тушаасан хэрэг. 1916 он А-29-1-434.Н-16
212. Хэнтий уулсын наадамд барилдах бөхчүүд засуулаас харьяат аймагт унасныг хувааж Сайд сэцэн ханы зэрэг арван нэгэн хошуу Эрдэнэ ялгуусан хутагтын шавь энэ учир сайд жанжинд явуулан тушаах бичгийн эх. 1916 он А-29-1-434.Н-17
213. Сайд дайчин жонон вангийн хошуунаас энэ зун цаг Хан хэнтий уулын тайлгын албанаа Сэтэртэн сүргээс нийлүүлэх улаа улаач дагалдаж тус хошууны тасалдаж тус хошууны түшмэл Дэндэв нарын төлөг нийлүүлсэний ацагийг зохих газраас хүсэн гаргуулж улмаар олуулах гуйж өргөсөн хэрэг. 1921 он ф-72-1-16.Н-8
214. Тус аймаг жасаанаас Хан Хэнтий уулыг тайхаар одогчдын хэрэгсэх морьдоос тасалдаж төлөг гүйцэтгүүлсний хөлсийг олгонуулмай хэмээн өргөсөн хэрэг. 1921 он ф-72-1-16.Н-9
215. Сайд Дайчин жонон вангийн хошуунаас Хан Хэнтий уулыг тайлгахад онож тасалдуулсныг төлөг гүйцэтгэсэний үнэ мөнгийг хүргүүлэн ирснийг зохигчдод түүгээр олгуулья хэмээн хүрээ жасаан басхүү харьяат сүргээс нийлүүлвээс зохих морьд улаачийн тасалдсан өр хөлсийг гаргуулан ирүүлье хэмээхээр сэтэртэн сүргийг захирах Сэргэлэн гүн Дугарсүрэнд тушаасан бичгийн эх. 1921 он ф-72-1-16.Н-10
216. Сүжигт бэйл Дэмчигванжилын хошуунаас харьяат засаг бэйлийн бие өвчтэй учрыг гаргаж бат оршил өргөх их ёслолд чөлөө олгуулахыг гуйн өргөсөн хэрэг. 1921 он ф-72-1-16.Н-12
217. Хан Хэнтий уулыг тайхаар одогчдын улаачийг тасалдуулсан бичээч Дамдинсүрэнгээс уг улаан малын хөлсийг хэвээр хөөн гаргаж төлүүлэхээр Ахай гүн Дашравданд тушаах бичгийн эх. 1921 он ф-72-1-16.Н-42
218. Хан Хэнтий уулын энэ зун цагийн тайлгад сэтэртэн сүргээс нийлүүлэх улаа улаач тасалдсан нь ацгийн мөнгийг хүлээн авсан харьяат хошууны тайж Монмандалаас түүгээр хураан авч зохигчдод олгуулан дуусгасугай хэмээн сайд Дайчин жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх. 1921 он ф-72-1-16.Н-44

- |      |  |         |                |
|------|--|---------|----------------|
| 219. | Ахай гүн Дашравдан нараас Хан Хэнтий уулыг тайхаар одогчдын улаа зүйлийг сэтэртэн сүргээс гаргуулахыг тасалдуулсан тус хошууны дагалт Дамдинсүрэнгийн мэдүүлгийг сийрүүлэн уг зарлал бичгийг мөрдөн байцаалгаж дарагдуулсан зохигчдоос төлүүлж болох эсэхийг заахыг эрж өргөсөн хэрэг. | 1921 он | ф-72-1-16.Н-45 |
| 220. | Хан Хэнтий уулыг тайхад хэрэгсэх шар асар зэрэг зүйлийг тусгай түшмэлд авуулан хуучин удаагаар сийрүүлэн гүйцэтгүүлье хэмээн Хан Хэнтий уулын хошуунд болзоолон тушаах бичгийн эх.   | 1925 он | ф-72-1-273.Н-1 |
| 221. | Хан Хэнтий уулыг тайлгахад эл хэрэгсэх зүйлийг гүйцэтгэн харьяат ба хичээн юу хэрэглэсэн зэргийг мэдүүлэн ирүүлэхээр Хан Хэнтий уулын хошуунд тушаах бичгийн эх.   | 1925 он | ф-72-1-273.Н-9 |

## Хавсралт: Зарим баримтын хуулбар

Хан Хэнтий уулыг тайхад хэрэглэх зуламны үхэр, хонийг Дархан гүн Барайширын хошуунд ухуулж харьяат газраа энэ учир сайд да Дайчин



жонон вангийн хошуунд тушаах бичгийн эх<sup>36</sup>



<sup>36</sup> МУУТА.ХА-29.Д-1.Хн-388.Х-1030-1031.



Сэцэн хан аймгийн талаас Хан Хэнтий уулыг цагдуулахуйд Богд хаан, Отхан хайрхан хайрхан уулуудыг цагдуулахаар суулгасан цагдаа нарын адил хорь илүү өрх цэрэг суулгаж хааж тагнах албаны хуваариар тахиглан шүтүүлж болох эсэхийг заамуй хэмээн өргөсөн хэрэг.<sup>37</sup>



<sup>37</sup> МУУТА Х.А-3, ХН.1-706

## ЗУРГАА. ШИНЭЛЭГ ТАЛ

Эртний тахилгат “Бурхан халдун” уул, хаадын ариун биеийг оршоосон “Их хориг”, монгол угсаатны уугуул нутаг “Гурван мөрний эх” гэдэг бол дан ганц шүтлэг бишрэл, тахилга тайлгын газар байгаагүй монголчуудын улс төрийн сэтгэлгээний цөм, оршихуйн үндэс байсан хэмээн судлаачид үздэг билээ. Бурхан Халдун уулын тахилгын уламжлал, шинэчлэл, учир холбогдол төдийгүй орчны бүсийн түүх соёлын өвийн бүртгэл, газар усны нэрийн хувирал өөрчлөлт, овгийн бүрэлдэхүүн, угсаатны зан үйлийн онцлог, нүүдэл суурьшил зэрэг асуудлыг шинжлэх ухааны үндэстэй судлах ажлыг хийж гүйцэтгэх үүднээс дараах ажлуудыг хийсэн нь тус төслийн шинэлэг тал, шинэ үр дүн болно. Үүнийг тоймлон хэлбэл, Бурхан халдун уулыг 2013 онд “Үндэсний бахархалт хайрхан” хэмээн зарлаж, 2015 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн соёлын өвийн жагсаалтанд бүртгүүлсэн билээ. Гэвч 1990-1993 оны хооронд хэрэгжсэн Япон, Монголын хамтарсан “Гурван гол” төслийн судалгаанаас хойш Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хүрээнд дорвитой судалгаа огт хийгдээгүй байсан юм. Тиймээс бидний энэ төсөл Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн газар нутгийн хүрээнд хэрэгжсэн хамгийн анхны үндэсний төсөл гэдэг утгаараа шинэлэг бөгөөд ач холбогдолтой байсан юм. Төслийн үр дүнд тус бүс нутгийн археологийн хайгуул судалгаа, тус бүс нутагт оршин суугчдын дунд угсаатны зүйн хээрийн судалгаа, Дэлхийн өвийн бүс нутагт хамаарах түүхэн газар нутгийн судалгааг цогц байдлаар хийсний дээр Бурхан халдун уулын түүх, соёлын судалгаанд хамаарах эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлүүдийн эмхэтгэл, Хан Хэнтий уул буюу Бурхан халдун уулын тахилга тайлга, хамгаалалт, шүтлэг бишрэлд холбогдох 1347 хуудас архивын материал зэргийг нэгтгэхийн зэрэгцээ хээрийн судалгааны хүрээнд цуглуулсан 2500 орчим гэрэл зургийн сан бүрдүүлсэн нь “Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-ийн тухайд бүрдүүлсэн нэг багц мэдээлийн сан болж байна. Ийнхүү төслийн ажлын үр дүнд манай улсад урьд байгаагүй шинэ мэдээлийн сан бүрдсэн нь энэ төслийн шинэлэг үр дүн болно. Үүнээс зарим ажлыг дурдвал:

- Дэлхийн өвийн дурсгалт газар түүний орчны бүсийн нутагт 2019-2022 онд нийт 4 удаа түүхч, түүхэн газарзүйч, археологич, угсаатан судлаачид оролцсон хээрийн шинжилгээний экспедиц зохион байгуулж, “Бурхан халдун уул”-ын бүх талыг хамарсан явган ба морин хайгуул хийж гүйцэтгэсэн. 2020 онд Бурхан халдун уулын өвөр ба зүүн хэсэг, Ахын гурван дэ, Хориудын ам, хөндий, Дашноровын зоо, Бунхант, Солооч, Жаргалантын ам, Нарангийн

энгэр, далхаа нуурын орчим, 2021 онд Бурхан халдун уулын баруун, хойд талыг бүрэн самнасны дээр Хуруу голын эх, Илүүрийн гол, Нанзан уулын өвөрт хайгуул судалгаа хийсэн. Энэ 2 жилийн хайгуул судалгааны үр днд Бурхан халдун уулын бүр талыг хамарсан анхны хээрийн хайгуул судалгаа хийгдсэн гэж үзэж болно. Мөн түүний орчны тахилга тайлгатай бүс нутгуудад хайгуул судалгаа хийгдсэн.

- 2019 оны хээрийн судалгаа нь Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газар түүний орчны бүс болон Дэлхийн өвийн бүс нутгийн газар усны нэрийн судалгаанд бичгдсэн. Мөн энэ төслийн хүрээнд дэлхийн өвийн газар нутагт багтах газарзүйн биетийн нэр, байршлын толийг хэвлэн гаргасан нь тухайн судалгааны нэг шинэ үр дүн болсон.
- Энэхүү төслийн хүрээнд бид Google street view-ийн жишгээр Бурхан Халдун уул, Балдан Бэрээвэн хийд, Биндэр уул болон Рашаан хадны дурсгалын 360 виртуал танилцуулгыг бэлтгэсэн. Энэхүү виртуал танилцуулгыг интернэтэд байрлуулан олон нийтэд нээлттэй сурталчлах, Google street view-тэй холбон байршуулвал дотоод болон гадаадын аялагч, жуулчдад нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүн болсон.
- Төлсийн үр дүнгээс хэвлэгдэн гарсан бүтээлүүд нь мөн Бурхан халдун уулын тухай шинэ судалгаа шинэ үр дүнгүүд болно.
  - i. Э.Равдан. *Дэлхийн өв-Бурхан халдуны бүс дэх газар нутгийн байршлын толь*. УБ., 2023. 104 тал.
  - ii. Н.Хатанбаатар, С.Чулуун. *Балданбэрээвэн хийд*. УБ., 2020. 96 тал.
  - iii. Дэлхийн өв – Бурхан халдун: Зурагт альбом. УБ., 2023. 104 тал.
  - iv. Чингис хааны өв, соёл: Архивийн баримтын эмхэтгэл. Крилл үсэгт хөрвүүлж, эрдэм шинжилгээний тайлбар хийсэн Г.Мягмарсамбуу, Г.Цэрэнсугар. УБ., 2020. 727 тал.

## **ДОЛОО. ШИНЖЛЭХ УХААН, ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДОЛ:**

Дэлхийн соёлын өв: Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутагт Чингис хааны алтан ургийн их хаад, язгууртнуудыг нууцлан онголсон “Их хориг” оршин буй нь баттай учир Монгол улсын төдийгүй дэлхийн нийт монгол угсаатны эрхэм нандин өв сан, итгэл, бишрэлийн нэгэн төв орон зай мөн.

Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 7 дугаар зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна”, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн. 1.1.6.Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн хэмээн тус тус тодорхой заасан байдаг.

Тус төслийн судалгааны ажлын хүрээнд түүх, археологи, түүхэн газарзүй, угсаатан зүйн салбар ухааны эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийн түвшинд нэгтгэн дүгнэж, шинээр судалгаа хийж, мэдээлийн шинэ сан бүрдүүлж, Дэлхийн соёлын өв: Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг түүний орчны бүсийн дурсгалт газруудын байршлыг тогтоох, нэрийн судалгаа хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, түүхэн аялал жуулчлалын маршрут гаргах эхлэлийг тавьснаар Монгол улсын түүх, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангахад томоохон хувь нэмэр болсон. Цаашид “Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”-т буй соёлын өвийн хамгаалалтын менежментийг сайжруулах, тус бүс нутагт аялал жуулчлалыг бодлоготойгоор хөгжүүлэхэд суурь мэдээллүүд энэ төслийн судалгааны үр дүнд хуримтлагдсан.

## ЕС. ДҮГНЭЛТ

“Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн орчны бүсийн түүх, соёлын өвийн судалгаа” сэдэвт захиалгат төслийг “Санхүүжүүлэх, хэрэгжүүлэх гэрээ”-ний “Үр дүнгийн даалгавар”-т 9 ажил, үүрэг зааснаас бүгд чанарын шаардлага хангахуйц түвшинд 100 хувь гүйцэтгэлтэй болсон. Үүнд: Хээрийн судалгааны ажлын үр дүнд түүх, соёлын өвийн 4 багц тайлан, байгалийн өвийн нэг тайлан бичихээс түүх, археологи, түүхэн газар нутгийн судалгааны 5 багц тайлан, байгалийн өвийн нэг тайлан бичиж бэлэн болгосон; Түүхэн газар нутаг, дурсгалт газар, аялал жуулчлалын чиглэлийн 3 бүтээл хэвлүүлэхээс тус төслийн хүрээнд нийт 4 бүтээл хэвлүүлсэн. (Э.Равдан. *Дэлхийн өв-Бурхан халдуны бүс дэх газар нутгийн байршлын толь*. УБ., 2023. 104 тал; “Бурхан Халдун уулын Дэлхийн соёлын өвийн дурсгал газар” нэртэй каталогийг бэлтгэн хэвлүүлэв. Цаасны хэмжээ 25,7 х 25,7, 96 тал.; Н.Хатанбаатар, С.Чулуун. *Балданбэрээвэн хийд*. УБ., 2020. 96 тал.; Чингис хааны өв, соёл: Архивийн баримтын эмхэтгэл. Крилл үсэгт хөрвүүлж, эрдэм шинжилгээний тайлбар хийсэн Г.Мягмарсамбуу, Г.Цэрэнсугар. УБ., 2020. 727 тал). Нэг хээрийн судалгааны багц тайлан, нэг баримтын эмхэтгэл, гурван илтгэл илүү хэвлүүлсэн нь тус төсөлт ажлын нэмэлт үр дүн болно; Дэлхийн соёлын өвийн урьдчилсан жагсаалтад бүртгэгдсэн Бурхан Халдун уул, Балдан Бэрээвэн хийд, Биндэр уул болон Рашаан хадны дурсгалын 360 виртуал танилцуулгыг Google street view-ийн жишгээр бэлтгэсэн; Хан хэнтий уул буюу Бурхан халдун уулын түүхэнд холбогдох 10 илтгэл, 13 өгүүлийн эмхэтгэлийг бэлэн болгосон; Бурхан халдун уулын тахилга тайлга, өв соёл, хатгаалалтад холбогдох Монголын Үндэсний Төв Архивт хадгалгагдаж буй 25 хадгаламжийн нэгжийн 1347 нүүр нугалбаруудыг сканераар хувилан авч цахим сан бүрдүүлсэн. Түүний зарим баримтыг сонгон авч нэг боть тайлан бэлтгэсэн. Ингэснээр тус төслийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.

Тус төслийн судалгааны хүрээнд түүх, археологи, газарзүй, угсаатан судлалын шинжлэх ухааны салбарын эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаа шинжилгээний ажлыг өнөөгийн түвшинд нэгтгэн дүгнэж, “Монголын нууц товчоон” ба бусад эх сурвалжид бичигдсэн Бурхан Халдун уулын түүх, тахилга, тайлгын уламжлалыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, Дэлхийн соёлын өвийн бүс нутгийг аялал жуулчлал, түүхэн ёслол хүндэтгэлийн цогц хэлбэрээр ашиглах, бүтээгдэхүүн ажил үйлчилгээ бий болгох суурь боломж бүрдсэн. Өөрөөр хэлбэл

энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн мэдээллүүдийг энэ төслийн үр дүнд хуримтлуулж, нэгэн цогц мэдээллийн сан бүрдүүлсэн.

Энэ төсөл нь 1990-1993 онд Япон, Монголын хамтран хэрэгжүүлсэн “Гурван гол” төслөөс хойш “Дэлхийн өв: Бурхан халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг”, болон “Монгол улсын үндэсний бархархалт хайрхан Бурхан Халдун уул”-ын түүх, соёлын өвийн талаар хэрэгжүүлсэн анхны үндэсний судалгааны төсөл байв. Энэ төслийн үр дүнд “Бурхан халдун уул, түүний орчны бүс”-ийн талаар Монгол улс өөрсдийн судлаачдын цуглуулсан археологи, угсаатан судлал, түүхэн газар нутаг, байгалийн нөхцөл, нөөц, газар зүйн тодорхой мэдээллийг багтаасан мэдээллийн сантай болсон. Ингэснээр эртний тахилга шүтээнт “Бурхан Халдун” уул, их хаадын ариун биеийг оршоосон “Их хориг”, Монгол үндэстний угуул нутаг “Гурван мөрний эх” зэргээр монголчуудын улс төрийн сэтгэлгээний цөм, оршихуйн үндэс, сүсэг бишрэлийн төв болсон газар орныг цаашид зөв зохистой хөгжүүлэх, хамгаалах менежментийн төлөвлөлтийг хийх, гадаад дотоодод сурталчилах, аялал жуулчлалыг зохистой хэлбэрээр хөгжүүлэхэд энэ төслийн үр дүн чухал ач холбогдолтой. Энэ утгаараа тус төслийн судалгааны ажлын үр дүн нь Монгол улсын түүх, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой болсон гэж дүгнэж болно.

Тайлан бичсэн:

Төслийн удирдагч . . . . . академич С.Чулуун